- Бертагаев Т.А., Цыдендамбаев Ц.Б. Грамматика бурятского языка. Синтаксис. Москва: Восточная литература, 1962.
- Грамматика русского языка. Синтаксис. Москва, 1982.
- Скрибник Е.К. Бурятские полипредикативные конструкции с показателем гэжэ // Показатели связи в сложном предложении. – Новосибирск, 1987.
- Baranova V. Grammaticalization paths of the verb gi- ‘say’ in Kalmyk // Mongolica Pragensia 15/2, 2015.
- Cristofaro, Sonia. Utterance Complement Clauses. In Matthew S. Dryer & Martin Haspelmath (eds.) *The World Atlas of Language Structures Online*. Munich: Max Planck Digital Library, 2011, chapter 128. Available online at <http://wals.info/chapter/128>. Accessed on

2013-05-26.

Givón, Talmy. *Syntax*. Amsterdam/Philadelphia: Benjamins, 2001 [1990].

Hashimoto, K. Metarepresentational Motivation: The Grammaticalization of the Verb of Saying ge- in Mongolian. In: Tsukuba English studies. Vol.22. University of Tsukuba, Tsukuba, pp. 35-49, 2004.

Список глосс

V- глагол, глагольная основа

N- имя

A- прилагательное

L- лексема

NOM- неопределенный падеж

GEN- родительный падеж

ACC- винительный падеж

DAT- дательный-местный падеж

ABL- исходный падеж

INS- орудный падеж

COM- совместный падеж

SG- ед. число

PL- мн. число

INTENS- интенсивное действие

SOC-совместн. действие

PST- прошедшее время

PRS-настоящее время

FUT- будущее время

PCL- частица

PSTP- послелог

REFL- притяжание

POSS-личн. притяжание

CVB- деепричастие

PC- причастие

PASS- страдательный залог, пассив

논 문 투 고 일 : 2018년 10월 30일
논 문 심 사 일 : 2018년 11월 15일
논문게재결정일 : 2018년 11월 30일

О принципах составления бурятского словообразовательного словаря

Харанутова Дарима Шагдуровна*

Abstract

The principles of compiling the Buryat word-formation dictionary

Kharanutova Darima Sh.*

The article is devoted to the problems of developing a word-formation dictionary of the Buryat language. The paper notes that the structuring of word-formation nests of single-root words is determined by the word-formation features of the language. The questions of the development of a vocabulary, the construction of a dictionary entry are raised. A variant of the lexicographic presentation of the material in the Buryat dictionary of words is proposed.

Keywords : derivational nest, Buryat language, dictionary entry, step principle, graphically-formant principle

Современная лексикография располагает значительным по объему и разнообразию материалом, представленным в словообразовательных словарях, построенных по гнездовому принципу, когда определяется производящая основа словообразовательного гнезда, устанавливаются словообразовательные структуры дериватов (производных слов) и демонстрируются их связи с производящими. Словообразовательное гнездо – это упорядоченная совокупность однокоренных слов в соответствии с их деривационными связями и взаимоотношениями. Словообразовательные гнезда являются важной лингвистической классификацией словарного состава, отражающей объективные характеристики слов – объединения по общей мотивирующей базе (Казак 2004: 10)

В монголоведении создание словообразовательных словарей остается важной теоретической

* Бурятский государственный университет / dkharanutova@mail.ru
(Buryat state university)

и практической задачей, несмотря на имеющийся «Словообразовательный словарь калмыцкого языка», составитель Д.А. Сусеева (Сусеева 1997). Автором использован опыт составления «Школьного словообразовательного словаря русского языка» А.Н. Тихонова (Тихонов 1978), который является автором «Словообразовательного словаря русского языка» (Тихонов 1985), остающегося одним из авторитетных деривационных словарей.

Калмыцкое словообразовательное гнездо образовано согласно ступенчатому принципу, постулируемому в словообразовательном словаре русского языка: дериваты, образованные непосредственно от вершины гнезда, находятся на первой ступени, производные от них - на второй ступени и т.д.

Несмотря на единый подход к структурированию, имеются значительные расхождения в моделировании гнезд, связанные с разноструктурностью русского и калмыцкого языков, поскольку структурирование словарного фонда языка гнездовым способом предопределяется системным подходом к описанию словообразовательной системы языка. Отсюда и вытекают особенности объединения однокоренной лексики гнездовым способом, в частности, в калмыцком словаре дается более широкое понимание производности, применяется этимологический критерий. В отличие от русского языка калмыцкие словообразовательные гнезда возглавляют не только свободные корневые морфемы, но и связанные, так как данное явление частотно для монгольских языков. Например:

Ивт - *ивт* — *день* `насквозь`

- *ивт* — *л(х)* `проходить насквозь`

- *ивт-р(х)* `проходить насквозь` - *ивтр-кэ* `сквозной, пронизываемый`

- *ивт-лһн* `сквозное проникновение`

(Сусеева 1997: 129).

Как отмечает Д.А. Сусеева, «словообразовательные гнезда в монгольских языках, наряду с универсальными признаками, имеют особенные, связанные с грамматическим строем монгольских языков, и специфические, связанные с национальными чертами каждого конкретного языка» (Сусеева 1997: 4). На наш взгляд, имеющиеся расхождения в понимании словообразовательного гнезда русского и калмыцкого языков не дают возможности развернуться полностью калмыцкому словообразовательному гнезду.

Оценивая значимость калмыцкого словообразовательного словаря, принимая во внимание выдвигаемые Д.А. Сусеевой принципы построения и наполнения калмыцких гнезд, выскажем некоторые соображения по поводу лексикографической подачи

материала в бурятском словообразовательном словаре.

Составление словаря такого типа потребовало разработки основных принципов его построения, что оказалось невозможным без тщательного изучения проблем словообразования бурятского языка, имеющих прямое или косвенное отношение к словарю, и специального исследования ряда вопросов, связанных с созданием теоретической базы словаря (Харанутова 2012, 2014 и др.).

Проблема лексического состава гнезд решена при помощи толковых словарей бурятского языка, в работе над словником используются все издания Бурятско-русских словарей, начиная от Бурят-монгольско-русского словаря, составитель К.М. Черемисов (БРМС 1951). В основном, лексическая база словаря базируется на Бурятско-русском словаре, составители Л.Д. Шагдаров, К.М. Черемисов (БРС 2006, БРС 2008).

Особые трудности при структурировании однокоренных слов вызывают вопросы размещения однокоренных дериватов в гнездах, возглавляемые словами разных частей речи. В качестве вершин словообразовательных гнезд предлагается использовать наиболее употребительные бурятские слова. При выявлении таких слов мы опирались на алфавитно-частотный словарь Г.А. Дырхеевой, где предложен список словоформ, составленный по произведениям классика бурятской литературы Х. Намсараева и сопровождающийся количественными характеристиками (результат морфологического анализа списка словоформ представлен на компакт-диске) (Дырхеева 2005).


Структурирование однокоренной лексики бурятского языка требует несколько иного подхода, нежели в русском языке, в первую очередь, при моделировании словообразовательного гнезда необходимо учитывать, что структурирование дериватов напрямую связано с особенностями словообразовательной системы языка. Известно, что деривационная система русского языка основана на способности слова к поступенчатому развертыванию, хотя, понятно, что ступенчатость организации гнезда – понятие относительное, ведь существуют понятие чересступенчатого словообразования, не прямой и неединственной мотивации, понятие «эллиптических моделей». По мнению А.А. Аминовой, словообразовательное гнездо русского языка напоминает «ромашку», (Аминова 1995: 43), так как деривационное развитие идет и по горизонтали, и по вертикали, в связи с чем, ступенчатый способ наиболее приемлем для структурирования.

При моделировании же бурятских гнезд ступенчатым способом обнаруживается вытянутость (удлиненность) по вертикали, так как бурятские словообразовательные цепи обрываются уже на третьей, реже четвертой ступени, а кодериваты выстраиваются в обширные парадигмы. В отличие от словообразовательной системы русского языка, где

вершина гнезда традиционно расположена слева от совокупности своих производных, бурятское словообразовательное гнездо, неравномерно расширяясь по вертикальным и горизонтальным осям, строится на специфических семантических основаниях, имеет гроздевую структуру – напоминает дерево с ветвями и гроздьями (подр. Харанутова 2012: 128-141).

Многозначительный термин «гроздья, гроздевая структура» часто применяется синтаксистами, исследующими сложноподчиненные предложения и сложные синтаксические целые, он используется в некоторых работах В.В. Виноградова. На наш взгляд, этот термин в полной мере применим к бурятскому словообразованию.

Данная особенность бурятского языка была проиллюстрирована нами на примере словообразовательного гнезда *дуун* (Харанутова 2012: 138).



В нашем случае вершина находится в центре, при моделировании гнезда «просится» поворот вокруг оси – вершины словообразовательного гнезда. И тогда все встает на свои места: результатом развития по вертикали является последовательная производность (ветви, в русском языке - цепочки), результатом развития по горизонтали является образование гроздей (веера дериватов, в русском языке - парадигмы) одного яруса.

Графически бурятское словообразовательное гнездо представлено из переплетений словообразовательных гроздей и словообразовательных ветвей однокоренных слов, скрепляющим началом выступает слово, являющееся вершиной гнезда (или стволом дерева), в нашем примере – это *дуун*. При этом отметим, бурятское гнездо ведет себя больше как парадигмальное образование, где парадигматический план представлен обширными гроздьями и развитие идет как бы вширь. То есть, в бурятском языке доминирует горизонтальное построение, структура гнезда имеет тенденцию к расширению (на одном ярусе оказываются дериваты из одной или нескольких гроздей), превалирует двух-, трех- или четырехъярусность.

Соответственно, способ подачи словообразовательных гнезд бурятского языка будет несколько иной, чем в словаре А.Н. Тихонова. За основу берется алфавитный порядок (начально-алфавитный): словарные статьи в соответствии с вершинами словообразовательных гнезд должны располагаться строго по алфавиту.

Вершина словообразовательного гнезда (исходное слово словообразовательного гнезда) выделяется полужирным курсивом, в нашем случае – *дуун*. Следует отметить, что в бурятском словообразовательном словаре переводом на русский язык снабжается только вершинное слово¹⁾.

Если вершинное слово многозначное, значения слов даются под римскими цифрами курсивом без полужирности, например:

Дуун

I . *дуун* `звук`

II . *дуун* `песня, голос`

III. *дуун* `голос (при голосовании на выборах)`

Дериваты гнезда выстраиваются в столбик. Слова, образованные непосредственно от вершины гнезда, пишутся с прописной буквы и будут иметь одиночную нумерацию (1, 2, 3, 4 и т.д.), например: I.1. *дуулаха*, I.2. *дуухан*, I.3. *дуушан*, I.4. *ябаган дуун*; II.1. *дуулаха*, II.2. *дуугарха*, II.3. *дуугай*, II.4. *дуугүй*, II.5. *дуутай*, II.6. *дуудаха*, II.7. *үгэ дуу*.

Дериваты, образованные от слов с одиночной нумерацией, становятся обладателями дробной нумерации (1.1., 1.2, 1.3.; 4.1., 4.2., 4.3. и т.д.), при этом в деривате каждого узелка выделяется производящая основа для последующего деривата. Например:

1) Планируется снабдить переводами каждый дериват в Словаре лексико-словообразовательных гнезд бурятского языка.

I. дуу(н)

I.1. дуу/ла/-ха

I.1.1. дуула/гда/-ха

I.1.2. дуула/лга/

I.1.3. дуула/лда/-ха

I.1.3.1. дуулалд/аан/

I.1.4. дуула/лса/-ха

I.1.4.1. дуулалс/аан/

Или

II.2. дуугар-ха

II.2.1. дуугар/уул/-ха

II.2.1.1. дуугаруул-ха/гуй/

Дериватор, при помощи которого образуется производное слово, отмечается в словообразовательной структуре слова косыми линиями «/».

В связи с агглютинативностью бурятского языка на одном деривационном шаге могут присоединяться два и более однотипных аффикса, что не характерно для русского языка. В связи с этим, в словаре применяется знак «-», являющийся показателем того, что слово образовано коалицией суффиксов (на одном деривационном шаге присоединилось несколько суффиксов одновременно).

Например:

I.1. дуулаха

I.1. 9. үгэ дуулаха

I.1. 9.2. (үгэ) дуул/га-бари-тай/

В словарной статье представлен ход образования нового слова. Предлагается *графически-формантный* способ, который позволит графически выразить все элементы, при помощи которых образуются слова. Такой способ подачи позволит легко ориентироваться и запоминать особенности деривационного процесса. В словаре каждый дериватор (формант словообразования, средство, при помощи которого образовано слово) имеет свое обозначение.

Приведем некоторые из них:

Аффиксальный способ — ^

Неаффиксальные способы:

+ – сложение слов, основ

// – контаминация

= – лексико-семантический.

Такой способ представления позволит легко ориентироваться и запоминать способ словообразования деривата.

Например:

Дуун

I. дуу(н)

^ I.1. дуу/ла/-ха

^ I.1.1. дуула/гда/-ха

^ I.1.2. дуула/лга/

^ I.1.3. дуула/лда/-ха

^ I.1.3.1. дуулалд/аан/

^ I.1.4. дуула/лса/-ха

^ I.1.4.1. дуулалс/аан/

Или

^ I.1. дуулаха

+ I.1. 9. үгэ дуулаха

^ I.1. 9.2. (үгэ) дуул/га+бари+тай/

На наш взгляд, эта система подачи словарной статьи однокоренных дериватов бурятского языка удобна, понятна для пользователя. С другой стороны, графически-формантный способ подачи словарной статьи позволит с максимальной полнотой отобразить словообразовательную активность бурятских слов, парадигмальность бурятского словообразовательного гнезда, воспроизвести деривационную выводимость вторичных образований, показать непрерывность бурятского деривационного механизма.

ЛИТЕРАТУРА

1. Аминова А.А. Производный глагол в сопоставительном аспекте (на материале русского и татарского языков) / А.А. Аминова. – Казань: Изд-во Казанского ун-та, 1993. – 187 с.
2. БРМС – Бурят-монгольско-русский словарь / сост. К.М. Черемисов. – М.: Гос. изд-во

- иностр. и нац. словарей, 1951. – 852 с.
3. БРС 2006 – Бурятско-русский словарь: в 2 т. Т. 1: А-Н / Л.Д. Шагдаров, К.М. Черемисов. – Улан-Удэ: Изд-во ОАО «Респ. тип.», 2006. – 636 с.
 4. БРС 2008 – Бурятско-русский словарь: в 2 т. Т. 2: О-Я / Л.Д. Шагдаров, К.М. Черемисов. – Улан-Удэ: Изд-во ОАО «Респ. тип.», 2008. – 708 с.
 5. Дырхеева Г.А. Морфологическая структура слова в бурятском языке: лингвостатистическое описание (на материале художественного текста) / Г.А. Дырхеева, О.С. Ринчинов. – Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2005. – 98 с.
 6. Казак М.Ю. Интегративная теория словообразовательного гнезда: грамматическое моделирование; квантитативные аспекты; потенциал; прогнозирование / М.Ю. Казак. – Белгород, 2004. – 298 с.
 7. Сусеева Д.А. Словообразовательный словарь монгольского и калмыцкого языков / Д.А. Сусеева. – Элиста: Калм. кн. изд-во, 1985. – 244 с.
 8. Сусеева Д.А. Словообразовательный словарь калмыцкого языка: на калм. и рус. языках / Д.А. Сусеева. – Элиста: Калмиздат, 1997. – 312 с.
 9. Тихонов А.Н. Словообразовательный словарь русского языка. Т. 1: А-П. – 2-е изд., стереотип. – М.: Рус. яз., 1990. – 856 с.
 10. Тихонов А.Н. Словообразовательный словарь русского языка. Т. 2: Р-Я. – 2-е изд., стереотип. – М.: Рус. яз., 1990. – 887 с.
 11. Тихонов А.Н. Школьный словообразовательный словарь русского языка / А.Н. Тихонов. – М.: Изд-во «Просвещение», 1978. – 727 с.
 12. Харанутова Д.Ш. Словообразование бурятского языка: монография / Д. Ш. Харанутова. – Улан-Удэ : Изд-во Бурят. госуниверситета, 2012. – 270 с.
 13. Харанутова Д.Ш., Сусеева Д.А., Ц. Өнөрбаян. Монгольское словообразование: структура и способы / Д. Ш. Харанутова, Д. А. Сусеева, Ц. Өнөрбаян; отв. ред. Г. А. Дырхеева. – Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2012. – 261 с.
 14. Харанутова Д. Ш. О гроздевой структуре бурятского словообразовательного гнезда / Д. Ш. Харанутова // Актуальные проблемы современного монголоведения и алтаистики. – Элиста: Изд-во Калмыцкого госуниверситета, 2014. – С. 320-322.

논 문 투 고 일 : 2018년 10월 30일
 논 문 심 사 일 : 2018년 11월 15일
 논문게재결정일 : 2018년 11월 30일

ҮГИЙН БУРУУ ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛД

- Цахим шуудан, харилцааны хэрэгслийн бичвэрийн хэлний
жишээгээр -

Батбуяны Золжаргал*

Abstract

ISSUE OF THE INAPPROPRIATE USAGE OF A WORD

- Example of E-communications and other communication facilities -

ZOLJARGAL Bathuyan*

Radio, television, newspaper articles and nowadays e-mails, mobile phone announcements, and text messages which are written form of oral language must follow Mongolian language norms. But there are inappropriate use of words such as language distorting and excessive use of foreign words. Language is a main tool for our daily communication. Therefore, we aimed to express that a language is living and the most important thing that constitutes a culture of the nation. For this purpose we explained the current situation of inappropriate use of the media, e-mail, mobile news and advertising language which influenced negatively to young people and children. Our research is based on certain examples, facts and we aimed to explore how to avoid this distortion and solve the problems using methods of analysis, synthesis for the research.

Keyword : applied linguistic, usage of word, foreign words, stylistics

Удиртгал

Хувь хүний ярианы хэлийг журамлах боломж хомс учир бичгийн хэлийг эрхэмлэх нь аль ч улс үндэстний баримталдаг жишиг юм. Хэл шинжлэлийн ухаанд “зөв бичих зүй, зөв дуудах зүй, хэлзүй, найруулга зүйн тогтсон хэм хэмжээтэй, сайтар боловсорсон хэлийг

* ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан / Zolushzol@icloud.com
(Institute of Language and Literature, Mongolian Academy of Science)

бичгийн хэл” хэмээн тодорхойлдог (Ганболд, 2017: 155). Радио, телевиз, сонин нийтлэл болон сүүлийн үед цахим шуудан, гар утсаар түгээдэг зар мэдээ, мессеж зэргийн хэл нь аман бичгийн хэл болох бөгөөд эдгээр нь монгол хэлний тогтсон хэм хэмжээг мөрдөх ёстой боловч үгийг зохисгүй хэрэглэх, хэлийг гажуудуулах, харь үгийг ихээр хэрэглэх болжээ. Иймээс бид энэхүү судалгаагаараа, хэл нь бидний өдөр тутмын харилцааны хамгийн гол хэрэглүүр болохын хувьд тухайн үндэстний сэтгэлгээг бүрэлдүүлэгч амьд шинжтэй, соёлыг бүрэлдүүлэгч хамгийн гол зүйл болох талаар тодорхой баримтад тулгуурлан тайлбарлах зорилго тавьж, энэхүү зорилгодоо хүрэхийн тулд, манай өнөөгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон цахим шуудан, гар утасны мэдээ, зар сурталчилгааны хэлний үзүүлж буй сөрөг нөлөөллөөс эх хэлний дархлаа гүйцэд суугаагүй залуус, хүүхэд багачуудад шууд нөлөөлж, буруу хандлага хэвших нөхцөлийг бүрэлдүүлдэг болсныг тодорхой жишээ, баримтаар тайлбарлах, энэ гажуудлаас хэрхэн зайлсхийж, зөв голдрилд нь оруулж болох талаар эрэл хайгуул хийх зорилт тавьж, судалгаандаа ажиглалтын болон анализ, синтезийн аргыг хослуулан хэрэглэнэ.

Яагаад энэ сэдвийг сонгосон бэ? Зорилго, хэрэгцээ

Монголын телевиз, сонин сэтгүүл, радио зэрэг олон нийтийн хэрэгслийн зар сурталчилгааны үг хэллэг, найруулгын талаар олон эрдэмтэн судлаачид судалж, эрдэм шинжилгээ болон хэрэглээнд нэвтрүүлсэн байдаг хэдий ч цахим шуудан, харилцааны хэрэгслээр зар сурталчилгаа, мэдээ мэдээллийн хэлний судалгааг төдийлөн сонирхон судалсан нь ховор. Цахим шуудан болон харилцааны хэрэгслээр илгээж буй зар сурталчилгаа, мэдээ мэдээллийн үг хэллэг, найруулга, түүний онцлог, нийгэмд үзүүлэх нөлөө зэргийг судлан үзэхэд эх хэлний наад захын хэрэглээний түвшин ямар байгааг эндээс харж болно гэж бодож байна. Иймээс энэ сэдвийг сонгож, өчүүхэн ажиглалт хийсэн юм.

Хэдийгээр цахим шуудан, харилцааны хэрэгслээр ирж буй зар сурталчилгаа, мэдээ зангийг жижиг зүйл хэмээн орхиж болох боловч уншаад үзэхээр монгол хэлний хэм хэмжээ, хэрэглээний найруулга зүй, үгийн зохистой хэрэглээ, харь үгийн хэрэглээ болон эх хэлний боловсролын түвшин хэр зэрэг байгааг харж болох тул энэ сэдвийг хөндөн судлах нь чухал юм.

Сүүлийн үед телевизийн зар сурталчилгааг хүмүүст хүрэх нь өмнөх жилүүдээс буурсан ба ийм зар сурталчилгаа нь өртөг өндөр, сонин сэтгүүлийн зар сурталчилгаа цаг хугацааны хувьд хүнд хүрэх нь хүртээмжтэй бус, сонин уншигчдын тоо цөөрч байгаатай холбогдуулсан интернет болон цахим шуудан, харилцааны хэрэгслээр зар сурталчилгаа илгээх болсон нь: хямд өртөгтэй, илүү олон хүнд хүрдэг, илгээлтийн тоо хязгааргүй,

хугацаа хэмнэдэг, уншигчдыг илрүүлэн хянадаг гэх мэт давуу талуудтай тул энэ талын зар сурталчилгаа илүү хөгжих төлөвтэй болж байгаа юм.


Зар сурталчилгааны хэлбэр:

- Телевизийн зар сурталчилгаа
- Сонин, сэтгүүлийн зар сурталчилгаа
- Гадна талбайн самбар, гэрэлт самбар
- Радио, богино долгионы зар сурталчилгаа
- Цахим шуудангийн зар сурталчилгаа
- Харилцааны хэрэгсэл
- Танилцуулга, тараах материал байгаагаас бид *цахим шуудан, харилцааны хэрэгслээр* илгээгддэг цахим захидал, мессеж зарын хэлэнд шинжилгээ хийсэн билээ.

Цахим шуудангийн зар сурталчилгааны давуу тал нь: хүлээн авагчдын цахим шууданд инбокс (inbox) хайрцагт шууд орох, хурдан, мэйл илгээснээс хойш 10 хоногт илгээсэн статистик үзүүлэлтийг гаргадаг бөгөөд хэрэглэгчдийн тоо, захидлыг нээсэн тоо, график үзүүлэлтийг гаргах, зорилтот хэрэглэгчтэй, үнэ хямд, сурталчилгааны оновчтой шийдэл, загвар зэрэг нь энэ төрлийн сурталчилгааг сонгоход хамгийн ихээр нөлөөлдөг зэргийг дурдсан байна.

Иймээс цахим шуудан, харилцааны хэрэгслээрх зар сурталчилгаа олон хүнд хүрдэг учир бичвэрийнх нь хэлийг судлах нь чухал юм.

Харилцааны хэрэгслээр илгээдэг зар сурталчилгааны давуу тал



Зар сурталчилгааны хэл, найруулгын талаар судалсан байдал

Зар сурталчилгаа нь хэл шинжлэлийн чухал бөгөөд сонирхолтой сэдэв байсаар ирсэн бөгөөд энэ талаар судалсан эрдэмтэд цөөнгүй. Жишээлбэл: Э.Сонинтогос “телевизийн зар сурталчилгааны хэлний онцлог”, Ж.Бат-Ирээдүй “Монгол зар сурталчилгааны хэлний тухай асуудалд”, О.Шинэбаяр “Зар сурталчилгаа дахь хэлний соёл, хэрэглээний асуудалд”, Б.Магсаржав “Хэлний засаглалтай зар сурталчилгаа холбогдох нь, Д.Уянга “Телевизийн реклам, рекламн хэл найруулгад хийсэн зарим ажиглалт, дүгнэлт” гэх мэт нэрлэвэл цөөнгүй байдаг.

Гэвч цахим шуудан, харилцааны хэрэгслээр илгээгддэг зар сурталчилгааны үг хэллэг, найруулгын талаар анхааран судалсан зүйл ховор байна.

Зар сурталчилгааны хэл нь:

- Маш тодорхой
- Товч
- Ойлгомжтой
- Маш богино хугацаанд хүний оюун санаанд бууж чадах
- Хүний анхаарал татаж чадах
- Үнэн
- Хэт шинэ биш байх шаардлагатай.

Зар сурталчилгааны бичвэрийг үүрэг, бүтэц, төрөл, хэрэглээгээр нь доорх мэт ангилж болмоор байна.

Үүрэг	Бүтэц	Төрөл	Хэрэглээ
Анхаарал татах Сонирхол татах Итгэл үнэмшил	Гарчиг, уриа	Бичгэн	Цахим шуудан, харилцааны хэрэгсэл (гар утас)
Хүсэл өдөөх Үйлдэлд хүргэх	Үндсэн эх - бичвэр Цуурай мөр	Аман, хосолсон	Радио, телевиз

Хэрэглээний найруулга зүй гэж юу вэ?

Хэрэглээний найруулга зүй бол утга зохиолын хэлний хэм хэмжээ, найруулах ур маягийг өдөр тутмын ярианы хэл, бичгийн хэрэглээнд ашиглах аргыг судалдаг найруулга зүйн үндсэн хэсгүүдийн нэг юм. Хэрэглээний найруулга зүй нь зохион найруулах онолын

эш үндэст тулгуурлан дүрслэх хэв маяг болон найруулгын чухал хэрэглүүр болох ойролцоо үг зэргийг ярианы болон бичгийн эх, илтгэл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зохистойгоор хэрэглэх аргад сургах, төлөвшүүлэх зорилготой (Баттөгс, 2017: 7).

Хэрэглээний найруулга нь өөрийн гэсэн тодорхой хэм хэмжээ онцлогтой, хэлний яруу илэрхийлэх арга хэрэгслийг ярианы хэлний хэв маягт тулгуурлан тухайн нөхцөл байдалд тохируулан зүй зохистой хэрэглэх ярианы найруулгын нэгэн хэсэг юм.

Цахим шуудан болон харилцааны хэрэгслийн зар сурталчилгааны хэл нь хэрэглээний найруулга зүйн нэг судлагдахуун бөгөөд хэл найруулгыг нь ажиглавал *ярианы найруулгын сайжруулсан бичгийн төрөл* гэж хэлж болно.

Цахим шуудан, харилцааны хэрэгслийн бичвэрт хийсэн ажиглалт

Хувь хүний ярианы хэлийг журамлах боломж хомс байдаг тул аливаа улс орон бичгийн хэлийг эрхэмлэдэг. Хэл шинжлэлийн ухаанд, зөв бичих зүй, хэл зүй, найруулга зүйн тогтсон хэм хэмжээтэй, сайтар боловсорсон хэлийг “бичгийн хэл” хэмээн тодорхойлдог.

Өдөр тутам бидэнд ирдэг цахим шуудан болон гар утасны мессеж зар, мэдээллийн хэлийг ажиглахад эх хэлний боловсрол, үгийн утга, хэрэглээ, мэдлэг боловсрол ямар түвшинд байгааг харах нэгэн өнцөг болж байгаа юм.

Цахим шуудан, харилцааны хэрэгслээр ирж буй бичвэрийг ажиглавал доорх мэт байна. *Өгүүлбэрийн зорилго, аялгын хувьд:*

- Асуух өгүүлбэр: Ямар нэгэн хариу шаарддаггүй, зөвхөн анхаарал татахад чиглэсэн байна. Жишээлбэл: “Ойрын хугацаанд Та гэр ахуйн цахилгаан бараа, тавилга, компьютер, гар утас худалдан авахаар төлөвлөж байна уу?”, “Юнителийн 4G LTE-тэй хамт зуныг зугаатай өнгөрөөмөөр байна уу?”, “Та хаашаа аялах вэ? Аялалд гарахын өмнө “Сэрүүн богцоо” авсан уу?” гэх мэт асуусан өгүүлбэрүүд байх бөгөөд хэн нэгнээс хариулт шаардлагагүй, харин ч бусдад санал болгох, сэдэл өгөх үүднээс ингэж асуусан өгүүлбэр илгээдэг байна.
- Нэрлэсэн өгүүлбэр: “Өнөөдөр “Аутизм”-ыг таниулах дэлхийн өдөр”, “эх орны брэнд Эвсэг”, “заавал ирэх зад хямдралтай шөнийн худалдаа” гэх мэтээр өгүүлэхүүнгүй нэрлэсэн өгүүлбэр олон байна.
- Анхааруулсан өнгө аястай: “Бүртгэлийн тоо хязгаартай тул та яараарай” гэсэн нь болох гэж буй үйл ажиллагаа хугацаатай, хязгаартайг сануулж, нөгөө талаар уриалан дуудсан, өдөөсөн шинжтэй байна.

- Сэрэмжлүүлсэн өнгө аястай: “Уб хотод усархаг бороо орж байгаа тул үер, усны аюулаас урьдчилан сэргийлнэ үү” гэх мэтээр болох болзошгүй аюулаас урьдчилан сэргийлсэн, сэрэмжлүүлсэн мэдээллийг хүргэж байна.
- Уриалсан өнгө аястай: “Төрт ёсны уламжлалаа дээдэлж, түвшин амгалан сонгуульдаа оролцъё” гэх мэтээр аливаа нийтээр оролцох ажил үйлст идэвхжүүлсэн, уриалан дуудсан мессэжүүд байна.
- Хэлц үгээр утга илтгэсэн: “Дулаан явбал мянган лан, өвлийн малгай ороолт бээлий тал үнээр” гэх мэт.

Түгээмэл алдаа, түүнийг залруулах нь

Найруулга зүйн шаардлагыг доктор, профессор Ц.Сүхбаатар “хэлж, ярьж, бичиж, туурвиж байгаа зүйл нь *ойлгомжтой, сонирхолтой, яруу сонсголонтой, гоо зүйн хэм хэмжээг харгалзан үзсэн* байх ёстой” (2004: 147) гэжээ.

Найруулгын үндсэн шаардлага, хэл найруулгын дүрэм горимыг зөрчсөний үр дагаврыг найруулгын алдаа гэдэг.

Цахим шуудан, харилцааны хэрэгслээрх бичвэрийн найруулгад ажиглалт хийж, улмаар түүнийг хэрхэн залруулах тал дээр санал дүгнэлтээ гаргахыг зорилоо. Бидний судлагдахууны хувьд найруулгын болон найруулгын бус алдаанууд түгээмэл байсан бөгөөд тэдгээрийг доор жишээгээр үзүүлж, боломжтой хувилбаруудыг оруулав.

а. Өгүүлбэрийн гишүүдийн байр солигдоход...

Цахим шуудан болон харилцааны хэрэгслээр ирсэн мессэж заруудаас өгүүлбэрийн гишүүдийн байр, дэс дарааны алдаа нэлээд ажиглагдаж байна. Үгийн байр гэдэг зүйл утга санаа илэрхийлэхэд онцгой чухал үүрэгтэй тул хэл шинжлэлийн хөгжилд хэлний нэгж хийгээд өгүүлбэр дэх үгийн байрыг онцлон үздэг “*байриил хэл*” шинжлэл хэмээх бие даасан чиглэл бий болсон юм.

“...12:00 болон 13:00 цагуудад сууж үзэн, *талбөргүй түвшингээ тогтоолгоорой*” гэсэн өгүүлбэрт “*Талбөргүй түвшин*” гэж бичсэн байх ба англи хэлний мэдлэгийн түвшингээ аль зэрэгт байгаагаа шалгуулах хэрэгтэй бөгөөд энэ нь “талбөргүй түвшин” гэж тусдаа түвшин байдаг гэсэн ойлголтыг өгч байна. Тэгвэл “талбөртэй түвшин” гэж бас байх нь ээ. Үүнийг “түвшингээ талбөргүй тогтоолгоорой” гэсэн бол зохимжтой болох байжээ.



Барилгын компаниас ирсэн байрны танилцуулгад: “оновчтой өрөөний зохион байгуулалттай” гэсэн өгүүлбэр байна. Тодотголын байрыг буруу газар хэрэглэснээр “оновчтой өрөө” гэдэг ойлголтыг бий болгож байна, “оновчтой өрөө” гэж байдаг бол “оновчгүй өрөө” гэж бас байх болно, утга нь юу гэсэн үг болохыг ухаж ойлгоход амаргүй юм. Үүнийг харин “өрөөний оновчтой зохион байгуулалт”

гэсэн бол хялбар ойлгогдох болов уу.

б. Үг сонгохуйн алдаа буюу үг буруу сонговол...

“ажилбарын өмнө, ажилбарын дараа” гэсэн үг байна. “Ажилбар” гэх үг нь зөв бичих зүйн алдаатай бөгөөд “ажиллавар” гэсэн үгийг ийн бичжээ. “Монгол хэлний тайлбар толиудад “1. Эд эрхтэнд гараар болон мэсээр хийх эмчилгээний арга, 2. Гараар болон мэсээр анагаах өвчин, эмгэг, эмчилгээний аргыг судалдаг анагаахын салбар ухаан” гэсэн байна. “Цонхонд хийсэн мэс ажиллавар” ч юм шиг хүнд санагдаж болох юм. Үүнийг ажиллагааны өмнө ба ажиллагааны дараа гэсэн бол илүү тохиромжтой.

Тус цахим шууданд “Цонх болон амлагаа, тавцанг арчилж цэвэрлэхэд илүү хялбар” гэснийг “арчилж цэвэрлэх” бус “арчиж цэвэрлэх” гэвэл илүү зохистой болох байв. Толь бичигт “арчлах” гэдэг үгийг: “1. Арчлах үйлийн нэр, юмыг хайрлаж тордох байдал, арчилгаа сайтай, арчилгаа тордлого, арчилгаа маллагаа, 2. Өвчтэй хүнийг сувилах нь, арчилгаа сувилгаа” гэсэн байхаас үзэхэд хүн болон амьд амьтан, ургамлыг арчлан хамгаалах, сувилахад энэ үгийг хэрэглэж, харин цонх тавцан зэрэг эд зүйлийг “арчиж цэвэрлэх” гэж хэрэглэвэ илүү оновчтой юм.

“Цонх” Констракшны зар сурталчилгааны бичвэрт “Жавартай өвлийн жаргалтай цонх” гэсний “жаргалтай” гэх үг монгол хэлний толиудад: “жаргал бүхий; жаргалтай хүн, жаргалтай гэр бүл, жаргалтай амьдрал, жаргалтай газар, жаргалтай нас, үе” гэх мэт утгыг



зааж, хүнтэй холбоотой бодит болон хийсвэр зүйлтэй хамт хэрэглэгддэг. “Жаргалтай цонх” гэх үү эсвэл “жаргалтай гэр бүл” гэх үү? амьгүй зүйлийг жаргалтай гэснээс өөр тодотгол хэрэглэсэн бол илүү оновчтой найруулга болох байжээ.

Мөн бүтээгдэхүүний танилцуулгадаа: “Энэ тавцан нь таны гэрт чимэг болж, *сонгодог уур амьсгалыг бүрдүүлэхээс (бүрдүүлэхээс)* гадна дулаан техникийн *хамгийн өндөр чанарыг таны гал голомтын үеэс үеийг хамтдаа туулах урлагын (урлагийн) бүтээл юм*” гэжээ. “Сонгодог уур амьсгал” гэдэг нь магадгүй орчуулгын үг байж болох юм. “Классик” гэдэг үгийг шууд хуулбарлан орчуулсан байж болно. “Хамгийн өндөр чанар” бус “сайн чанар” гэвэл болно.

Цонхны тавцан “урлагийн бүтээл” болно гэдэг нь “хэтэрсэн гоёл” болжээ. Хэтэрхий содон, яруу дүрслэх гэж чамирсанаас гоо зүйн алдаа гарах нь элбэг тохиолдож байна.

Цахим шуудангаар ирсэн нэгэн сурталчилгаанд “Таны оффисын хажууд дэлхийд алдартай “Ажисен Рамен”, “Хот Пот” халуун тогоо сүлжээ хоолны ресторан, “Тэгээнтэн Энтертайнмент” кино театр, “Гранд Фарм” эмийн сан, “Тэгээ караоке” автомат тоглоомын газар, худалдаа үйлчилгээ, банк санхүүгийн байгууллага гээд жилийн дөрвөн улиралд *хүний урсгал* үл тасрах бизнес орчин хүлээж байна” гэсэн бичвэрт “Хүний урсгал” гэсэн үг байна. Монгол сэтгэлгээнд олон хүн байнга ирж очдог, олон хүн холхисон газар орныг “хүний хөл тасрахгүй” гэж хэлдэг болохоос “хүний урсгал” гэдэггүй, урсгал гэдэг үг нь “аль нэгэн чигт урсан хөдлөх байдал, урсаж байгаа нь” (Монгол хэлний тайлбар толь) гээд голын урсгал, замын урсгал, цахилгааны урсгал, агаарын урсгал, салхины урсгал гэх мэтээр хэрэглэдэг. Тиймээс “хүний урсгал үл тасрах” гэснийг “хүний хөл үл тасрах” гэж бичих нь илүү тохиромжтой байжээ.

Мөн энэ захидалд, танд оффис хэрэгтэй байна уу, хотын төв цэгээс 2-хон км-т байрлах гэгээнтэн цогцолборт оффис таныг хүлээж байна” гэх мэтчилэн “оффис” гэх харь үгийг хэрэглэсэн байна. “Оффис” гэдэг нь “албан газар, албан тасалгаа” гэсэн утгатай. Энэ үгийг орлож чадахуйц монгол үг байсаар байхад харь үг хэрэглэдэг болсныг хязгаарлах шаардлагатай байна.

Хэл сэтгэхүйн холбооноос үүдэж учир шалтгааны үнэлгээ гарч ирдэг. Цахим шуудан болон харилцааны хэрэгсэлд ирж буй бичвэрүүдийг ажиглахад зарим нь хүний анхаарлыг татах гэж, сонин содон болгох гээд улам дордуулсан, бусдыг илт доромжилсон даажигнасан өнгө аястай болгосон зүйл цөөнгүй байна. Жишээлбэл:

Text Message
Ня 4-р сар 2 11:25

Unegui gutaI huvtsas taraj bn
gne.Araichde zarim baraa
4900-8900han tugrug bolsn ym
baiha kkk.Ungursun 4/1.Ta
hojimdogui! 4.2nd 22:00 hurtel.
S.Outlet.88084240

Text Message
Лх 5-р сар 3 18:18

Black&White: Havriin buh hymdral
1n zereg zuwhun unuudur.Arai I
denduu hymdarche! 4.9-19.9T
Unegui gutaI huvtsas taraaj bn. S-
Outlet: 5/3nd
12:00-24:00.88084240

Дээрх мессеж зарын бичвэр нь “үнэгүй гутал хувцас тарааж байна гэнэ. Арай ч дээ, зарим бараа 4900-8900 төгрөг болсон юм байх аа ккк. Өнгөрсөн 4 сарын 1. Та хожимдоогүй!” гэж бичсэн байх ба “үнэгүй хувцас гутал тарааж байна” гэсэн өгүүлбэр нь зар сурталчилгааны журам дахь мэдээлэл үнэн байх гэсэн шаардлагад нийцээгүй, хоёрт, “ккк” гэж бичсэн нь тоглосон, үгүйгэсэн аястай, гуравт, “өнгөрсөн 4 сарын 1” гээд хуурсан, даажигнасан өнгө аясыг илэрхийлсэн нь хэтэрхий содон, өвөрмөцөөр илтгэх гээд гоо зүйн алдаа гаргаж байна. Олон нийтэд түгээж буйгаараа харилцааны хэрэгслээр ирж буй сурталчилгааны бичвэрт “ккк” гэж бичсэн нь тохиромжгүй байгаагаас гадна үл хүндэтгэсэн, албан ёсных гэхээс илүүтэй хувийн харилцааг илэрхийлсэн өнгө аястай болсон байна.

Хүний анхаарлыг татах гээд

“Та 100000 төгрөгийн эрхийн эзэн боллоо” нэртэй цахим захиаг хараад хэн ч гайхах, баярлах сэтгэл төрөх нь мэдээж. Харин захианы агуулгыг уншвал “Дэлхийн усны өдөр”-г зориулан нэгэн компанийн бараа 100000 төгрөгөөр хямдарсан байх жишээтэй. Хэн нэгний анхаарлыг татаж, өөрсдийн байгууллагын сурталчилгааг илгээдэг бас нэгэн менежментийн арга ч юм шиг, нэг бодлоор хүний сэтгэхүйгээр тоглож байгаа хуурмаг зүйл ч гэмээр.

Цахим шуудан, харилцааны хэрэглээр (гар утасны мессеж) 200 гаруй бичвэрийг



түүвэрлэн авч ажиглалт хийсэн болно.

Эдгээрийг агуулгаар нь: *зар сурталчилгаа*, *мэндчилгээ* (баяр наадмын, ерөнхийлөгчийн г.м), *сэрэмжлүүлэг* (цаг агаарын, цагдаагийн газрын г.м), *уриалга* (үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг, сонгуулийн г.м), *зааварчилгаа* (гар утасны үйлчилгээний, шинээр нэвтэрч байгаа зүйлийн) гэж ангилж болмоор байна.

Эдгээрийн бичвэрийн эхийг ихэвчлэн захиалагчид өгдөг бөгөөд илгээгч тал найруулга, үг хэллэгийн хувьд өөрчлөх эрх хомс, харин захиалагч тал тухайн илгээгч талаар бичвэрийг хийлгэвэл тэд найруулан бичдэг байна.

Харь үгийн хэрэглээ

Цахим шуудан болон харилцааны хэрэгслээр ирж буй зар сурталчилгаа, мэдээллийн бичвэрийн үгийн сангийн онцлогийг ерөнхийд нь ажиглахад:

- Утга зохиолын ба аман ярианы бүхий л найруулгын оновчтой хэллэгийг ашигладаг.
- Харин албаны хэл төдий л өргөн хэрэглэдэггүй.
- Харь үг хэрэглэх нь элбэг. Жишээлбэл: *big sale, super sale*
- Орчуулгын үг хэллэг хэрэглэдэг. Жишээлбэл: *maui том хямдрал - big sale*
- Харь үгийн хэрэглээ их.

Бидний түүвэрлэн судалсан нийт зар сурталчилгааны бичвэрийн 52.6% нь харь үг хэрэглэсэн байна.

Харь үгийг хэл найруулгад оруулан найруулж болох хэдэн тохиолдол байдаг бөгөөд эдгээр нь:

- а. Мэргэжлийн үг хэллэг (атом, молекул...)
 - б. Улс орны нэр, байгууллага, оноосон нэр
 - с. Олон улсын дундын шинж чанартай үг хэллэг (фестиваль, театр, симпозиум)
- зэрэг үгийг орчуулахгүй хэрэглэж заншсан байдаг.

Эрдэмтэн Д.Отгонсүрэн “Тадаад хэлний боломжтойг нь эх хэлний дүйх үгээр орчуулан найруулгынхаа өвөрмөц шинжид нийцүүлэн найруулах учиртай” гэжээ. Гэтэл зар сурталчилгааны үг хэллэгт орчуулан хэрэглэж болохоор, монгол үг нь байсаар байхад

харь үгийг ихээр хэрэглэж байна. Жишээлбэл: хямдралтай, хямдарсан, хөнгөлөлттэй үнэ гэхийн оронд sale гэх үгийг хэрэглэх болсон байна. Нийт зар сурталчилгааны бичвэрийн 66% нь “хямдралтай, хямдарлаа, хөнгөлөлттэй, хөнгөлүүлэн аваарай” гэсэн үгийг, 34% нь “off, sale, big sale, super sale, classic sale” гэсэн харь үгийг, мөн “bodit sale, ontsgoi sale” гэсэн холимог хэлбэртэйгээр хэрэглэсэн байна.

Мөн “маш том хямдрал зарлалаа” гэсэн өгүүлбэрийн маш том хямдрал гэдэг нь “big sale” гэсэн үгийн орчуулга бололтой. Монгол хэлэнд том гэдэг нь “юмны овор дүр ба хэмжээгээр их байдал”-ыг илтгэдэг бодит зүйлийг дүрсэлдэг тэмдэг нэр. Гэтэл хямдрал гэсэн хийсвэр нэрэнд зохимжтой эсэх нь эргэлзээтэй юм.

Text Message
Бя 12-р сар 9 13:15

SHIRT SHOP: Shine jil ehellee - Buh erchudde zoriulan brandiin kostumnuuddaa MASH tom hymdral zarlалаа. 50%-70% classic SALE. Bodit hymdraliig meder. [88084240](tel:88084240)

Газрыг инч-ээр (inch) хэмждэг болсон гэвэл...?

Мя 7-р сар 11 15:12

Ever numiig evsheelgen tataj tavisан sum tani mergen baig Gazriin inch evhen hurtsлах uysan huleg tani hurdan baig Devjeegee hotolзуулан deveh buh tani davaатай baig. Ta saihan naadaарай. Ta ayalгуут mendчилгее ilgeeh бол 1435 dugaart zalгаарай. Une: 1min-100tug.

Эвэр нумыг эвшээлгэн татаж тавьсан сум тань мэргэн байг

Газрын инч эвхэн хурцлах уясан хүлэг тань хурдан байг

Дэвжээгээ хотолзуулан дэвэх бөх тань даваатай байг. Та сайхан наадаарай. Та аялгуут мэндчилгээ илгээх бол 1435 дугаарт залгаарай.” гэсэн үүр телефоны компаниас ирсэн наадмын мэнчилгээн дэх “инч” (inch=2,54см) гэдэг хэмжүүрээр газар хэмждэг болсон гэхээр хачирхалтай

ч юм шиг, харамсалтай ч юм шиг санагдана.

Монголчууд газрыг хэмжихдээ хүн малын явдлаар (хоногийн газар, сарын газар, жирэмсэн эмийн шээх газар), нүүдэл суудлаар (саахалтын газар, суман газар), бэлчээрээр (морины аргамжааны газар 25-50м, хонины бэлчээрийн газар 1-2км), газрын хэмжүүрээр (газар - 180 хос алд, мод газар - 1,06км, бээр газар - 1,5-2км, өртөө газар - 30 км) гэх мэтчилэн уламжлалт хэмжээ заасан үг хэллэгээр хэмждэг. Гэтэл энэ мэндчилгээнд буй инч (inch 2,54см) буюу монгол хэмжүүрээр бол “хуруу” (2см)-тай дөхөж очно. Монгол

наадамд хурдан морины уралдаанд азарга 22-24км, их нас 24-26км, соёолон 18-20км, хязаалан 15-17км, шүдтэн 12-14км, даага 10-12км-ийн зайнд уралддаг. Ийм хол замыг яаж хуруу хүрэм хэмжээгээр хэмжинэ гэж бодож олсон нь эмгэнэлтэй.

Мя 9-р сар 19 10:49

Энэ бичвэрт: нийт үгийн тоо - 20, үүнээс харь үг - 10 (*BSB, MEGASALE, Sony, home theater, PS4, Elecrtolux, dollar, Toshiba, super*) байгаа нь эх хэлний цэвэр ариун байдал алдагдаж, харь үгийн хэрэглээ ихэссэнийг илтгэж байна.

BSB MEGASALE: Sony zuragtand home theater, PS4 belgend, Electrolux avaad 50 hurtelh dollar butsaan avch, Toshiba sugalaanii super aztan болоорoi. [77220272](https://www.youtube.com/watch?v=77220272)

Харь үгийг махчлан орчуулж монгол хэлнээ шууд хуулбарлан авсан үг, хэллэгийг орчуулгын үг гэдэг.

Жишээлбэл: *big sale - том хямдрал, black Friday - хар баасан гараг* гэх мэт.

“Хар баасан гараг” гэвэл монголчуудын хувьд тийм ч таатай хүлээн авах үг биш, монголчууд “хар өдөр” гэвэл ямар нэгэн гунигтай, харуусалтай, тааламжгүй үйл явдал болсон өдрийг хэлдэг. Гэтэл энэ өдөр дэлгүүрүүд хамгийн их хямдралтай өдрөө ингэж нэрлэх болжээ. АНУ-д Талархлын өдрийн маргаашийн хямдралтай баасан гарагийг ийнхүү хэлдэг байна. Энэ өдөр машины түгжрэл, хүмүүсийн бөөгнөрөл хамгийн их байдаг тул ийнхүү нэрлэснийг манайхан шууд хуулбарлан орчуулжээ.

ДҮГНЭЛТ

Хэдийгээр зар сурталчилгаа нь хүний анхаарлыг татах, шинэ содон, сонирхолтой байх хэрэгтэй боловч аливаа юм хэм хэмжээтэй байвал гажуудал гарахгүй тул эх хэлнийхээ цэвэр ариун байдлыг хамгаалж, нийтийн хэлний боловсролд сайнаар нөлөөлөхүйц үг хэллэгтэй, зөв зохистой найруулгатай бичих нь чухал юм.

Судалгаанд хамрагдсан нийт 200 цахим шуудан, харилцааны хэрэгслээрх зар сурталчилгаа, мэдээ мэдээллийн чанартай бичвэрүүдийн 42% нь харь үг байх бөгөөд орчуулгын үг ч цөөнгүй байгаа нь монгол хэл, соёлын дархлаа сулрах аюултай. Тиймээс орчуулж болох үг бүрийг монгол хэлнээ дүйцүүлэн орчуулж хэрэглэх нь шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

Баттөгс Ш., “Хэрэглээний найруулга зүй ба найруулах эрдэмт суралцах нь”, Улаанбаатар хот, 2017 он, 156 хуудас.

Ганболд Б., “Зарим үгийн буруу хэрэглээг журамлах асуудалд”, Хэрэглээний хэл шинжлэл сэтгүүл, 2018 он, Уб хот, 155-159 тал.

Сонинтогос Э., “Телевизийн зар сурталчилгааны хэл найруулга” (Монголын телевизүүдийн жишээн дээр), Улаанбаатар хот, 2011 он, 138 хуудас.

Сүхбаатар Ц., “Монгол хэлний найруулга зүй”, Улаанбаатар хот, 2004 он.

Шинэбаяр О., “Зар сурталчилгаан дахь хэлний соёл, хэрэглээний асуудалд”, Монгол хэлний хэрэглээ, уран сайхны эхийн шинжлэл, Улаанбаатар хот, 2012 он, 78-87 тал.

논 문 투 고 일 : 2018년 10월 30일
논 문 심 사 일 : 2018년 11월 15일
논문게재결정일 : 2018년 11월 30일

МОНГОЛ ХЭЛ ИНТЕРНЭТ ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН СУДЛАГДАХУУН БОЛОХ НЬ

Д.Боролзой*

Abstract

Mongolian language is Internet linguistics' object

D.Borolzoi*

Mongolian evolving process is happening today. It is noted how social network sites and online journalism are depended of Mongolian language. Websites for public are official news media. Therefore, Mongolian language norm must be obeyed in these official websites. Whereas, social network sites are private communication tools. Thus, Mongolian language norm must not be obeyed in these social network sites. Also, this article describes how the internet is analyzed and how the internet affects the evolution of the Mongolian language. Mongolian language is internet linguistics' object. Internet research in Mongolia is developing successfully.

Keywords : Mongolian language, Internet, Internet linguistics, online journalism, social network, language norm

Удиртгал

Аливаа хэл нь байнга хөгжин хувьсаж өөрчлөгдөж байдаг “амьд организм” билээ. Монгол хэл ч бас энэхүү хэлний хөгжлийн түүхэн үйл явцыг тойрч биш дайрч өнгөрсөөр өнөөг хүрлээ. Энэ үйл явц өнөөдөр ч өрнөж байна. Эдүгээ техник технологийн дэвшил,

* ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан / borolzoid@gmail.com

(Research worker of Linguistic sector, Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences)

нийгэм цаг үеийн өөрчлөлтөөс шалтгаалсан монгол хэлний хувирал өөрчлөлт нэлээд идэвхтэй өрнөж буй орчин нь интернэт болжээ. Интернэт хэмээх зүйл нь мэдээлэл авахаас гадна хүмүүс хоорондын харилцааны маш том талбар юм.

Энэхүү интернэтийн орчинд өрнөж буй монгол хэлний хувьсал өөрчлөлтийг нийгэм хэл шинжлэл болоод сэтгэц хэл шинжлэлийн талаас нь голчлон судалдаг. Мөн энэ харилцааны орчинг судлах хангалттай хэрэглэгдэхүүн бий болсон тул хэл найруулга, үгийн сан, хэл зүй, зөв бичих зүй зэрэг олон талаас нь судлах боломжтой болжээ. Нэгэн үе үүнийг “блогийн хэл”, “интернэтийн хэл” гэх мэтээр муушаан ярьж хэлийг зөвхөн бохирдуулж байгаа талаас нь ярьж байсан бол одоо монгол хэл нь интернэт хэл шинжлэлийн судалгааны баттай нэгэн объект болсон байна.

Судалгааны зорилго

Дэлхийн болоод монголын хэл шинжлэлд үүсэн бий болоод удаагүй байгаа хэл шинжлэлийн нэгэн шинэхэн салбар бол “интернэт хэл шинжлэл” юм. Дэлхийн олон улсад энэ чиглэлийн судалгаа амжилттай хөгжиж байгаа бөгөөд Монголд ч гэсэн энэ талаарх судалгааг идэвхтэй хийдэг болжээ.

Дэлхийн олон хэлний нэгийн хувьд монгол хэл шинжлэлд энэ чиглэлийн судалгааг илүү нарийвчлан хийхийг хэл шинжлэлийн ухаан биднээс шаардаж байна. Энэ илтгэлээр “интернэт хэл шинжлэл” хэмээх шинэхэн чиглэлийн судалгаа Монголд хэрхэн хөгжиж байгаа талаар тодорхой харуулахыг зорив.

Судалгааны асуулт

Уг илтгэлээр дараах асуултад хариулт өгөх зорилготой байна. Үүнд:

1. Интернэтийн хэлийг судлах чухал шаардлага юу вэ?
2. Монголд интернэт хэл шинжлэлийн судалгаа хэрхэн хөгжиж байна вэ?
3. Интернэтийн монгол хэлэнд нөлөөлж байгаа сөрөг талууд юу байна вэ?
4. Монголын интернэт хэл шинжлэлийн судалгааны хөгжлийн чиг хандлага ямар байна вэ?

Судалгааны арга

Уг илтгэлд баримт цуглуулах, харьцуулан жиших, задлан шинжлэх, тайлбарлах, ерөнхийлөн дүгнэх зэрэг судалгааны аргыг хэрэглэсэн болно.

Судалгааны хэрэглэгдэхүүн

Интернэт орчны монгол хэлний судалгааны хамрах хүрээ нь мэдээллийн вэб хуудсууд болон орчин үеийн хүмүүсийн хэрэглээний салшгүй хэсэг болсон нийгмийн сүлжээний төрөл бүрийн сайтуудын хэлний баримтууд судалгааны чухал эх хэрэглэгдэхүүн болно.

Интернэтийн хэлийг судлах чухал шаардлага

Интернэт хэмээх зүйл нь өнөө цагт мэдээлэл, харилцааны хүчирхэг хэрэгсэл болохынхоо хувьд нийгмийн сэтгэл зүй, хүмүүсийн харилцаа, ялангуяа хэлэнд үзүүлэх нөлөө нь багагүй болжээ. Жилээр биш сар, өдрөөр өөрчлөгдөн хувьсаж байгаа энэхүү мэдээллийн технологийн хурд дунд монгол хэлэнд үзүүлж байгаа нөлөө нь ч тун хурдтай байна. Түүнчлэн интернэтийн монгол хэлэнд үзүүлж байгаа нөлөөг дутуу үнэлэн огт анхаарахгүй өнгөрч болохгүй бөгөөд шүүмжлэхээс илүүтэйгээр орчин цагийн монгол хэлний хөгжил хувьсалд болж байгаа бодит нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрч монгол хэл шинжлэлийн судалгааны нэгэн чухал объект болгон анхааралтайгаар нарийвчлан судлах нь чухал байна.

Мэдээллийн энэ их урсгал мэдээж хэлээр дамжина. Монгол улсын төрийн албан ёсны хэл бол монгол хэл билээ. Монгол хэлээр дамжиж байгаа энэ их мэдээллийн урсгалд эх хэл маань ч тодорхой хэмжээгээр бохирдох, эвдрэх, бас нөгөө талаар өөрчлөгдөн хөгжих нэгэн хөрс суурь нь болж байна. Интернэт орчин дахь олон нийтийн монгол хэлний хэрэглээг хянах боломж муутай бөгөөд тэр хэрээрээ монгол хэлэнд нөлөөлж байгаа нөлөө нь бас хяналтгүй, судалгаа багатай, чиг баримжаагүй байна гэж хэлж болно.

Интернэтийн орчинд монгол хэл маань мөхөөд байна уу, хөгжөөд байна уу? гэдэг асуудал урган гарч байна. Мэдээж бүх зүйл хоёр талтай байдаг. Нэг талаар монгол хэлийг улам баялаг агуулгатай, хөгжил хөдөлгөөнтэй, найруулгын олон өнгө төрхтэй болгох талаасаа хөгжүүлж байгаа боловч нөгөө талаар монгол хэлийг эвдэх, бүх нийтэд буруу

үлгэр дууриал болохын хувьд мөхөөх тал нь давамгайлах хандлагатай байгааг ч мөн хүлээн зөвшөөрөх ёстой. Ийнхүү монгол хэлний энэхүү хувьсал өөрчлөлт нь хэл шинжлэлийн судлагдахуун болохоос гадна олон нийтийн дунд байгаа интернэт нь монгол хэлийг “мөхөөж” байгаа эсвэл “хөгжүүлж” байгаагийн алин болох тухай асуултад эрдэм шинжилгээний үндэслэлтэй хариулт өгөх шаардлага байгаа нь интернэт хэл шинжлэлийн судалгааны нэгэн чухал зорилт болно.

Дэлхийн интернэт хэл шинжлэлийн судалгааны товч тойм

“Интернэтийн хэл хэрэглээг судлах ажил 1980-аад оны сүүл үеэс АНУ-д эрчимтэй хөгжиж эхэлсэн. 1984 онд Наоми Барон “Харж хүлээн авдаг хэл” (Visual Language) гэх цахим сэтгүүлд “Компьютерт суурилсан харилцаа хэлний өөрчлөлтөд нөлөөлөх нь” гэх сэдвээр өгүүлэл нийтлүүлсэн нь энэ талаар гарсан судалгааны ажлын анхны бүтээл болох юм. 1990-ээд оны эхээр (CMC) computer mediated communication буюу компьютерт суурилсан харилцаа гэх нэр томъёо түгээмэл хэрэглэгдэх болж компьютерийн орчны харилцаа, түүний хэл хэрэглээг судлах ажил өрнөсөнтэй холбоотойгоор 1995 онд харилцаа холбооны томоохон цахим сэтгүүл болох “Компьютерт суурилсан харилцаа” (Journal of Computer – Mediated Communication) хэмээх сэтгүүлийн анхны дугаар хэвлэгдсэн” (Энхмаа, 2015: 10) байна.

Харин Английн хэл шинжлэлч, профессор Дэвид Кристал “Интернэт хэл шинжлэл” (Internet linguistics) хэмээх судалгааны энэхүү шинэ чиглэлийг үүсгэсэн бөгөөд “Хэл ба интернэт” (David Crystal, 2001), “Интернэт хэл шинжлэл” (David Crystal, 2011), “Интернэтийн хэлний нэр томъёоны тайлбар толь” (David Crystal, 2004) зэрэг бүтээлүүдийг туурвижээ. Өмнө нь судлаачид хэлний стандарт алдагдаж интернэт хэлний ирээдүйд муугаар нөлөөлнө гэсэн бол Дэвид Кристал харин үүнийг хэл шинжлэлд гарсан хувьсгал гээд хэлний олон хувилбар бий болж, хүний бүтээлч сэтгэлгээг нэмэгдүүлнэ хэмээн интернэтийг сайшаажээ. Тэрбээр “интернэт нь хэл хэрэглээг нэг талаар асар ихээр өөрчлөхийн зэрэгцээ нөгөө талаар хөгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж байна... ..ярианы хэл, бичгийн хэлний шинж чанарыг тус тус гарган үзүүлж интернэтийн хэл нь ярианы хэл, бичгийн хэлний шинжийг зарим талаар зэрэг хадгалсан байдаг ч өөрийн өвөрмөц онцлогтой байдаг учир түүний давуу тал, хэлний хөгжилд нөлөөлөх нөлөө өндөр болохыг өгүүлсэн. Тухайлбал интернэтийн харилцаа нь чөлөөтэй, албадлагын бус шинжтэй, харилцан идэвхтэй, заавал хэл зүйн болон бусад дүрэмд захирагдах албагүй, баялаг

шинжтэй байдаг” (Энхмаа, 2015: 13) гэжээ.

Хамгийн түгээмэл хэл болохын хувьд англи хэлээр өрнөж буй цахим орчны хэлний хувьсал хөгжлийн асуудлаар судлаач Дэвид Кристалаас гадна Наоми Бэрон (Naomi S Baron, 2008), Сюзан Херринг (Computer mediated communication linguistics, Social and cross-cultural perspectives, 1996), Рой Петер Кларк (Roy Peter Clark, 2009), Шерри Төркл (Sherry Turkle, 1995) зэрэг маш олон судлаачид интернэт хэл шинжлэлийн судалгааг хөгжүүлжээ. “Өрнө дахины эрдэмтэд интернэт харилцааг доорх байдлаар өргөн хүрээнээс нарийсган авч үзэн судалж байна.

- Интернэт (Internet) – харилцааны өргөн хүрээтэй орчин, орон зай
- Компьютерт суурилсан харилцаа (CMC) – Интернэтийн орчинд компьютер болон бусад хэрэгслээр харилцах харилцаа
- Компьютерт суурилсан дискурс (CMD) – Интернэтийн орчинд цахим хэрэгслээр дамжин бичвэрийн тусламжтай явагдах харилцаа
- Компьютерт суурилсан харилцан яриа (CMCs) – Интернэтээр явагдах харилцан ярианд нийгэм, сэтгэл зүй, хэлшинжлэлийн үүднээс дүгнэлт хийх. Энэ яриа нь интернэтийн орчны шинж чанар, харилцааны хэлбэрээс хамаарна.
- Нэг цагт зэрэг харилцах эсвэл ижил бус цагт харилцах текстэн харилцаа (synchronous and asynchronous discourse)” (Энхмаа, 2015: 20).

Интернэт хэл шинжлэлийн дээрх судалгаануудыг анзаарахад ихэвчлэн цахим орчин дахь хүмүүсийн харилцааны текстэд дүн шинжилгээ хийсэн, гарч буй хувирал хөгжлийг нь нээн илрүүлсэн буюу хэлний талаас нь анхаарсан прагматик судалгаа байна. Энэ мэтчилэн интернэтийн орчны хэлний өнөөгийн хөгжлийн байдал нь цахим харилцаанд идэвхтэй оролцож байгаа улс орон болгоны л хэлэнд тохиолдож байгаа асуудал учраас өөр олон улс орнуудад энэ талаарх судалгаа өргөн цар хүрээтэй хийгджээ. Тухайлбал, Орос улсад л гэхэд энэ талаар сүүлийн хэдэн жил олон арван эрдэм шинжилгээний бүтээлийг туурвин гаргажээ. “Тэдгээр бүтээлд ихэнхдээ интернэтийн хэлний үйл ажиллагааны онцлог, интернэтээр ижилсэх байдал үүсэх, хувь хүний бодит бус ертөнцийг сүлжээгээр дамжуулан илтгэх арга, интернэт дэх хэлэхүйн үйл ажиллагааны явц зэргийн талаар судалсан. Орос улсын интернэтийн хэлний судалгаа нь ихэвчлэн онолын үүднээс интернэтийн харилцааг тайлбарлахад чиглэгдсэн бөгөөд өрнө дахины судалгааны байдлыгтайлбарлан, интернэт хэлшинжлэлийн нэр томьёо, ухагдахууныг орос хэл рүү орчуулан тайлбарлахад чиглэгдэж байна” (Энхмаа, 2015: 20). Интернэт хэл шинжлэлийн чиглэлээр Е.И.Горошко, Е.Н.Галичкина, М.С.Рыжков, Л.А.Шестак, О.В.Лутвинова,

Т.Н.Колокольцева, Б.Я.Шарифуллин, Е.Б.Штукарева зэрэг Оросын эрдэмтэд судалжээ. Мөн түүнчлэн интернэтийн хэлний талаарх судалгаа ханз үсэг хэрэглэдэг Япон, Хятад зэрэг улсуудад ч идэвхтэй өрнөж байгаа бөгөөд интернэт хэл бичигт нь нөлөөлж байгааг хүлээн зөвшөөрч судалсаар байна.

Тухайлбал, интернэт нь хятад хэлэнд хэрхэн нөлөөлж байгаа тухайд жишээлбэл: 1. Хятад хэлэнд олон нутгийн аялгуу байдаг учраас интернэтийн орчин нь хүмүүст өөр өөрийн нутгийн аялгуугаар ярих боломж олгодог байна. 2. Англи хэлний нөлөөгөөр хятад хэлний интернэтийн хэлэнд англи хэлний үг хэллэг хэрэглэх, англи хэлний авиаг дуурайж хятад дүрс үсгээр орлуулж хэрэглэдэг байна. (cool-ku) 3. Латин үсгээр хятад хэлний ханз үсгийг товчилж эхний үсгээр бичих (gg-gege залуу) болон англи хэлний үгийг товчилж хэрэглэх (gf-girlfriend, cu-see you) 4. Тооны дуудлагыг ашиглах (8147-bu yao sheng qi-уурлах хэрэггүй) гэх мэт байна. Мөн Wechat хэмээх олон нийтийн сүлжээгээр өвөрмонголчууд монгол хэлээр латин үсгээр галиглан бичин харилцах нь элбэг болсон бөгөөд галиглахдаа монгол бичгийн хэлний онцлогтой бчидэг нь харагддаг. (sain yabuju iregsen u? Abu chini sain u?)

Монгол дахь интернэт хэл шинжлэлийн судалгааны товч тойм

Монголд 2010 оноос интернэт хэл шинжлэлийн чиглэлээр анхны өгүүлэл, илтгэлүүд гарч эхэлснээр энэ чиглэлийн дагнасан судалгаа хөгжиж эхэлжээ. Өөрөөр хэлбэл энэ харилцааны орчинг судлах хангалттай судалгааны хэрэглэгдэхүүн бий болж эхэлсэн тул хэл найруулга, үгийн сан, хэл зүй, зөв бичих зүй зэрэг олон талаас нь судалж байна.

Монгол хэлэнд өрнөөд байгаа энэ асуудлыг нэг хэсэг “блогийн хэл”, “интернэтийн хэл” гэх мэтээр муушаан ярих төдий л байлаа. Хэлийг бохирдуулж байгаа талаас нь шүүмжлэхээс биш шинжлэх ухаанчаар судлах талаар хараахан учир дутагдалтай байсан гэж хэлж болно. Гэвч техник технологийн дэвшил, хөгжлөөр дэлхий нийттэй үргэлж хөл нийлүүлэн алхаж байдгийн хувьд монголчуудын дунд цахим хэрэглээ нэвтэрсэн тэр үеэс л монгол хэлэнд тохиолдох болсон цахим орчны монгол хэлний хэрэглээний талаарх судалгаа бусад улс орнуудтай харьцуулахад хожуу ч гэлээ анхлан хийгдэж эхэлсэн байдаг. Энэ талаар доктор Б.Энхмаа “2011 онд ШУА-ийн ХЗХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Боролзой “Интернэт монгол хэлний аюулгүй байдалд нөлөөлөх нь” хэмээх эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн нь энэ талаар хийгдсэн судалгааны ажлын эхлэл гэж үзэж болно. Тус өгүүлэлд интернэт хэрэглээний давуу тал болоод дутагдалтай талыг монгол

хэлний аюулгүй байдалтай холбон тайлбарлаж, улмаар интернэтийн орчин дахь монгол хэлний асуудлыг судлах нь монгол хэлшинжлэлийн хувьд шинэлэг хандлага болохыг дурьдаад энэ талаар өөрийн ажиглалт судалгааг хийж, тодорхой дүгнэлтийг гаргасан байна. Тэрээр тус судалгаандаа интернэт гар утасны мессеж, цахим шуудан, чат, компьютерийн орчин, вэб сайтуудаар дамжин монгол хэлэнд нөлөөлж байгааг дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд: Гадаад хэл болон бичгийн нөлөө, гадаад үг үгийн санд нэвтэрч нөлөөлөх, үг зүйн талаар нөлөөлөх (намайг-нааг г.м.), хэл найруулгын талаас нөлөөлөх гэх мэтээр тус бүрд нь авч үзэж, тодорхой жишээ баримтуудыг харуулжээ” (Энхмаа, 2015: 28) хэмээн бичжээ. Зохиогч дээрх өгүүллийг 2011 онд бус 2010 онд “Хэл зохиол судлал” сэтгүүлд нийтлүүлсэн бөгөөд энэхүү өгүүллийн санаагаар анх “Хүрэлтогоот-2010” эрдэм шинжилгээний бага хуралд “Интернэтийн орчин дахь монгол хэлний байдал” (2010.10.30) сэдэвтэй илтгэл хэлэлцүүлж байсныг ташрамд дурдъя.

Харин “*интернэт хэл шинжлэл*” (internet linguistics) хэмээх хэлшинжлэлийн энэхүү шинэ чиглэлийн далбаан доор яг тухайлан судлаагүй боловч зарим нэг судлаачид цахим орчны монгол хэлэнд тохиолдоод байгаа энэхүү үзэгдэлд анхаарал хандуулж байсан байдаг. Тухайлбал, доктор О.Самбуудорж “Одоо үед бичиг үсэг хэрэглэж буй монгол хэлт ард түмний бичгийн хэлний шинэ маягийн соёлын холбооны бас нэг онцлог бол, латин үсэг хэрэглэн интернэтээр харилцах байдал нэлээд бий болсон байна. Гэхдээ тэдний хэн нь ч латин үсгийг уншин, латин үсгээр тодорхой зүйл бичиж чадах боловч, нэгдсэн дүрэм хараахан үгүй тул, өөр өөрийн бичгийн хэлний дүрмийг баримтлах, эсвэл Монгол улсын кирил үсгийн дүрмийг баримталж бичих байдал нэлээд ажиглагдаж байгаа болно” (Самбуудорж, 2005: 39) гэсэн байна.

Доктор Г.Гэрэлмаа “Хэрэглээний хэл шинжлэл” хэмээх нэгэн сэдэвт бүтээлийг 2012 онд хэвлүүлжээ. Уг бүтээлдээ интернэтийн хэлийг сүүлийн үед хэрэглээний хэл шинжлэлийн нэг тусгай салбар болгон үзэж байгааг дурдаад интернэтийн орчин дахь монгол хэлийг хэрэглэгчдийн байдлыг дараах хоёр бүлэгт хуваан үзжээ. Энэ нь нэгдүгээрт, монгол хэлээр мэдээлэл цацагчдын үг хэл, хоёрдугаарт, санал буюу *comment* (тайлбар, сэтгэгдэл) бичигчдийн үг хэл г.м. Нэгдүгээр бүлэгт багтагсдын хэл найруулгын алдаа хоёрдугаар бүлгийнхнээс харьцангуй боловсронгуй /зарим сайтыг эс тооцвол/ хэлний хэм хэмжээнд нийцүүлэн мэдээллээ тавьдаг. Харин хоёрдугаар бүлгийнхэн бол хэлний хэм хэмжээ гэдгийг гол төлөв мартагсад бөгөөд тэд өөрийн хэлж болох боломжтой бүх бүдүүлэг үг хэллэгийг ашиглахыг хичээдэг” (Гэрэлмаа, 2012: 117) гээд “интернэтийн хэл, хэрэглээний үүргээ гүйцэтгэж буй боловч хэлний хэм хэмжээнд нийцэхгүй эх хэлний ариун байдалд сөргөөр нөлөөлж болох тул сайт болон блог ажиллуулагчид /admin/ мэдээллээ хэлний хэм

хэмжээнд нийцүүлэн үлгэр жишээ болохуйцаар хийх, санал бичигчдийн этгээд үг хэллэгтэй саналыг хүлээн авахгүй байх зохион байгуулалт хийвэл эерэг нөлөөтэй” (Гэрэлмаа, 2012: 118) хэмээн өөрийн саналыг дэвшүүлжээ.

Доктор Б.Энхмаа “Интернэтийн хэл шинжлэл” хэмээх нэгэн сэдэвт бүтээлийг 2015 онд хэвлүүлсэн байна. Уг бүтээл нь интернэт хэл шинжлэлийн судалгааны талаар Монголд анх удаа гарсан нэгэн сэдэвт бүтээл бөгөөд интернэтийн хэлийг голдуу нийгэм хэл шинжлэлийн буюу хэлний хэрэглээний талаас нь судалсан тухайгаа “...судлаачид интернетийг шинжлэх ухааны гайхамшигт нээлт гэхээсээ илүү нийгмийн үзэгдэл, нийгмийн харилцааны орчин гэж үздэг бөгөөд интернетийн орчны хэл хэрэглээтэй холбоотой асуудлыг нийгэм хэлшинжлэлийн ухаантай холбон авч судалдаг. Өөрөөр хэлбэл интернетийг нийгмийн үзэгдэл болохын хувьд нийгэм хэлшинжлэлийн үүднээс авч үзэж болох ба, хүмүүсийн хоорондох харилцааны нарийн үйл явц учир сэтгэц хэлшинжлэлийн үүднээс ч судалж үздэг байна” (Энхмаа, 2015: 9) гэжээ. Тус бүтээл нь гурван бүлэгтэй бөгөөд нэгдүгээр бүлэгт интернэт хэл шинжлэлийн үүсэл хөгжлөөс эхлээд Англи, Орос, Хятад, Япон зэрэг улсын интернэтийн хэлний судалгааны өнөөгийн байдлыг тоймлон өгүүлэхийн хамт энэ талаарх үзэл баримтлал, онцлог шинжийн талаар дэлгэрэнгүй өгүүлжээ. Хоёрдугаар бүлэгтээ Монгол улсын интернэтийн хэлний онцлог болох олон нийтийн цахим харилцааны хэлбэрүүд, латин үсгийн хэрэглээ гэх мэтээр хэрэглээний талаас нь авч үзсэн бол гуравдугаар бүлэгт монгол хэл ба Монгол улсын интернэтийн хэлний өнөөгийн нөхцөл байдал, түүнд нөлөөлөх нийгмийн хүчин зүйлсүүдийн талаар жишээ баримт татан судалсан шинэхэн байгаа энэ чиглэлийн судалгааны даацтай бүтээл болжээ.

Интернэтийн монгол хэлэнд нөлөөлж байгаа орчнууд

Интернэтийн орчинд болж буй монгол хэлний хувьсал хөгжлийг судлахдаа дан ганц “интернэт орчин” гэлгүй “цахим орчин” хэмээн нэрлэх нь энэхүү гар утасны мессежийн харилцаанд интернэт орчинд тохиолдож буйтай мөн адилхан асуудал өрнөөд буйг нь хэлсэн хэрэг юм. Өөрөөр хэлбэл энэ нь интернэтээс гадна компьютерт суурилсан харилцаа (computer mediated communication) хэмээх бас нэгэн өөр харилцааг хэлж буй хэрэг юм. Интернэт нь дэлхий нийтийг хамарсан хэрэглээ болж түгэхээс өмнө буюу 1990-ээд оны эхээр компьютерт суурилсан харилцаа хэмээх нэр томьёо бий болж, энэ талаарх судалгаа хийгдэж иржээ. Тэгэхээр интернэтээс ч өмнө буюу компьютерийн хэрэглээгээр, мөн гар

утсаар мессеж бичиж харилцах болсноор цахим орчны хэлний хувьсал хөгжлийн асуудал эхэлсэн юм.

1) Гар утас, компьютерийн орчин

Интернэтийн хамгийн хүчтэй хэрэгсэл болох нийгмийн сүлжээ хүчээ авахаас өмнө компьютерийн хэрэглээ, гар утасны мессежээр хэлэнд бий болоод байгаа өнөө цагийн “зовлон бэрхшээл” болох цахим орчны монгол хэлний хувьсал хөгжлийн асуудал бий болж эхэлжээ.

Интернэтэд шууд холбогдох боломжтой болтлоо хөгжсөн өнөөгийн ухаалаг утас бий болохоос өмнөх утсаар ярихаас гадна хоорондоо харилцах боломжийг олгодог байсан үйлчилгээ бол мессежийн үйлчилгээ юм. Өнөөгийн цахим орчинд өрнөөд буй монгол хэлний хөгжил, хувьслын эхэн үеийн тодорхой жишээг харуулах орчин бол гар утасны мессежийн хэрэглээний орчин юм. Мессеж гэдэг нь аливаа хүн бусдад хүргэх мэдээллээ 90-160 тэмдэгтэд багтаан текстэн хэлбэрээр бичиж илгээдэг бөгөөд энэхүү хязгаарлагдмал хэмжээнээс нь болоод мөн л богино хэмжээнд аль болох олон утга санаа, мэдээлэл буюу үгийг дамжуулах хэрэгцээ үүсэн бий болдог. Богино хэмжээнээс гадна хурдан шуурхай бичих хэрэгцээ шаардлага байдаг нь мессежийн хэрэглээнд утга санаа, сэтгэл хөдлөлөө илэрхийлэхдээ үгийг товчлох, хураах, дүрс ашиглах зэрэг хэрэгцээг бий болгодог байна.

Монголчуудын гар утсаарх мессежийн бичгийн харилцаанд гадаад үгийг хэрэглэх нь түгээмэл байдаг. Ж: hi, bye, lol г.м. Мөн байнга идэвхтэй давтан хэрэглэдэг үгсийг товчлох /бну-байна уу/, /снү-сайн уу/ г.м. Тэрчлэн сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх /кк-инээж байгааг илэрхийлэх/. Мессежийн хэрэглээнд кирилээр бичих технологийн боломжийг бүрэн шийдээгүйгээс латин үсгийг ашиглан бичих нь одоо ч түгээмэл байна.

2) Цахим сэтгүүл зүйн орчин

Аливаа шинэ зүйл бий болохдоо дэвшилтэт зүйлийг авчрахын хамтаар бас өөрийн шинэ зовлон бэрхшээлийг үүсгэх нь бий. Үүний нэгэн тодорхой жишээ бол цахим сэтгүүл зүй юм. Цахим сэтгүүл зүйн (Online journalism) орчинд монгол хэлний эвдрэл, басхүү хөгжил хувьсалд нөлөөлөх зүйл арвин тохиолдож байна. Мэдээллийн технологийн хувьсгалаас шалтгаалан анхлан радио, тэгээд сонин, сүүлдээ телевизүүд голлох үүрэгтэй мэдээллийн хэрэгслүүд байсан бол сүүлийн үед цахим сэтгүүл зүй улам эрч хүчээ аван илүү олныг хамарч байна.

Нэг талаас мэдээллийг хүлээн авах, нөгөө талаас түүнд оролцох боломж олгодгоороо цахим мэдээллийн хэрэгсэл бусдаасаа ялгардаг. Энэ нь мэдээллийн хэрэгсэл талаас мэдээ

мэдээллийг нийтлэх, хүлээн авагч буюу уншигч талаас “comment” буюу “сэтгэгдэл” бичих маягаар оролцож байна гэсэн үг юм. Ийм учраас олон нийтийн хэлний боловсролд хүчтэй нөлөөлж байдгийн хувьд цахим орчинд хэвлэн нийтлэх нь яг л бичмэл, хэвлэмэл ном хэвлэл нь бичгийн хэлний ямар хэм хэмжээг баримтлах ёстой байна, түүнийг баримтлах ёстой байдаг. Өөрөөр хэлбэл албан ёсны харилцаа болохын хувьд хэвлэлийн редакциуд үүнд хариуцлагатай хандах ёстой. Харин цахим орчинд энэ талын асуудлыг үл тоосон, хариуцлагагүй ханддагаас болж зөв бичгийн дүрмийн алдааг баримтлахгүй бичих, бичгийн хэлний хэм хэмжээг сахихгүй байх, гадаад үгийг замбараагүй хэрэглэх явдал элбэг байна. Олон нийтэд мэдээлэл түгээдэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болохын хувьд цахим сэтгүүл, хэвлэмэл сонин сэтгүүл ч яг адилхан монгол хэлний бичгийн хэлний хэм хэмжээг ягштал баримтлах үүрэгтэй билээ.

УИХ-аас шинээр батлан гаргаж 2015 оны 7 сарын 1-нээс хэрэгжиж эхэлж буй “Монгол хэлний тухай хууль”-д ч энэ талын харилцааг зохицуулсан заалт байдаг. Тухайлбал, уг хуулийн 19-р зүйлийн 1-д “Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага дараах үүрэг хүлээнэ” гээд 19.1.1-д “монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээг чанд баримтлах”, 19.1.2-т “сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны мэргэжлийн ур чадварын шалгалтад монгол хэл, бичгийн мэдлэгийн шалгуур тогтоосон байх” гэсэн байна.

Мэдээллийн нь сайтуудын тухайд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болохынхоо хувьд тодорхой дэг журамтай, хуульд захирагддаг, монгол хэлний бичгийн хэлний хэм хэмжээг баримтлах ёстой “албан ёсны харилцаа” явагддаг орчин байдаг бол харин сайтад сэтгэгдэл бичих, нийгмийн сүлжээнд хүмүүс хоорондоо харилцах нь харьцангуй хувийн шинж чанартай, бичгийн хэлний хэм хэмжээг заавал чанд баримтлах шаардлагагүй “хувийн харилцаа”-ны орчин юм. Тийм учраас албан ёсны харилцааг зохицуулах, удирдах боломжтой бол хувийн харилцааг удирдах боломж болоод шаардлага аль аль нь байхгүй.

3) Нийгмийн сүлжээний орчин

Хэдийгээр мэдээлэл түгээдэг ч гэлээ олон нийтийн мэдээллийн хэрэгслээс ялгаатай хувийн харилцааны орчин бол “соошл нэтворк” (social network, social media) буюу “нийгмийн сүлжээ” юм. Ердөө арваадхан жилийн өмнө бид өдөр тутмын мэдээллээ радио, телевиз, өдөр тутмын сонин, сэтгүүлээс авч байсан бол харин өнөөдөр нийгмийн сүлжээ нь мэдээлэл, харилцааны хамгийн хамгийн том сүлжээ болон өргөжин хөгжиж, дэлхийн хэмжээнд хамгийн олон хүнийг хамарсан харилцаа холбоо, мэдээ мэдээллийн хэрэгсэл

болон хувирчээ. Нийгмийн сүлжээ нь үнэхээр богино хугацаанд олныг хамарч чадсан байдаг. Тухайлбал, нийгмийн сүлжээ нь 50 сая хэрэглэгчидтэй болохын тулд ердөө 4 жилийг зарцуулсан бол энэ хэмжээний хэрэглэгчтэй болохын тулд радио 38 жил, телевиз 13 жилийг зарцуулжээ.

Нийгмийн сүлжээний вэб сайтуудад агуулагдаж буй мэдээ мэдээллүүд нь зүгээр нэг “амьгүй харилцаа” биш эсрэгээрээ хүмүүсийн хоорондын идэвхтэй “амьд харилцаа”-гаар үүсдэг харилцаа холбооны шинэ үзэгдэл юм. Мөн хуучны мэдээ мэдээллийн хэрэгслийг (телевиз, радио, сонин, сэтгүүл) нэг дор нэгтгэсэн учир нэг дор олон хэрэглэгчдэд хүрч массад нөлөөлөх боломжтойгоороо мэдээллийн хүчтэй хэрэгсэл юм. Энэ хэрээрээ ч өнөө цагт нийгмийн сэтгэл зүйд, хэлний хувьсал хөгжилд шууд нөлөөлж байна. Тухайлбал, телевиз болон сонины мэдээг үзсэн тухайн уншигч, үзэгчид нь л хардаг бол нийгмийн сүлжээ буюу жишээ нь, Фэйсбүүк, Твиттерт хэдий хэмжээний хэрэглэгчид хүрээлж байна тэр бүрт мэдээллээ бусадтай хуваалцаж түгээж чаддаг. Ингэснээр хэрэглэгчдийг өөрсдийг нь мэдээллийн сүлжээнд идэвхтэй оролцуулж байна гэсэн үг юм.

Монголчууд ч гэсэн нийгмийн сүлжээний энэхүү хурдтай хөгжлөөс хоцроогүйгээр барахгүй хэдийн идэвхтэй оролцогчид болсон билээ. Өнөөдөр Монгол улсад нийгмийн сүлжээг идэвхтэй ашиглах явдал улам нэмэгдсээр байгаа бөгөөд хувь хүмүүсээс гадна төрийн бус байгууллагууд, улс төр, боловсрол гэх мэт салбарын төрийн байгууллагууд, бизнесийн салбарынхан түлхүү ашигласаар байна. Улс төрийн салбарынхан ихэвчлэн твиттерийг, бизнесийнхэн фэйсбүүкийг түлхүү хэрэглэж байгаа бол телевизээр гарсан мэдээлэл, сонинд гарсан нийтлэлүүд ч цахим хувилбарт шилжиж нийгмийн сүлжээний хэрэгслүүдээр олон мянган хүнд хүрч байна. Орон зай, цаг хугацааны хувьд нийгмийн сүлжээнд хүн бүр өөрийн хүссэн мэдээллээ хурдан шуурхай түгээх боломжтой хэдий ч мэдээлэллийн үнэн зөв, алдаатай эсэхэд нь хяналт тавих ямар ч боломжгүй байдаг нь түүний сул тал болно. Тийм учраас хяналт багатай энэ орчинд монгол хэлний эвдрэлд нөлөөлөх муу нөлөө нь харьцангуй их байна.

Интернэт монгол хэлний хэм хэмжээнд нөлөөлж байгаа тухайд

1) Зөв бичих зүй

“Аливаа авианы бичиг дэх зөв бичих дүрмийн нийлбэр цогцыг зөв бичихзүй гэнэ” (Орчин цагийн монгол хэл, 2008: 85). Харин зөв бичих дүрэм гэдэг нь олон нийтийн хувьд заавал даган мөрдөж байх ёстой хэм хэмжээ билээ. Бүх нийтээр мөрдөх зөв

бичгийн дүрэм, баримтлах бичгийн хэлний хэм хэмжээ байдаг боловч интернэтийн орчны монгол хэлний хэрэглээнд тэр хэм хэмжээг мөрдөхгүй, баримтлахгүй байх нь элбэг билээ. Эдгээр асуудлыг энгийн олон нийт шүүмжлэн хэлэлцдэг боловч хэрхэн засаж залруулах, цаашид хэрхэх талаар оновчтой шийдэлд хүрэлгүй өнөөг хүрэв.

Гэхдээ энэхүү интернэтийн орчинд буй “эх хэлний доройтол”-ыг нийгмийн эмх журамгүй байдал, олон нийтийн эх хэлний боловсролтой шууд холбон буруутгах боломжгүй. Учир нь интернэт орчны харилцаа бол өөрийн гэсэн онцлогтой, өвөрмөц хэрэгцээ шаардлагатай байдаг учраас өөрийн гэсэн “зөв бичгийн дүрэмтэй” бөгөөд үүнийг нь басхүү шууд буруутгаж болохгүй юм. Энэ онцлогийн талаар доктор О.Самбуудорж “Интернэт орчин бол биднээс мэдээллийг хурдан шуурхай бичиж, богино хугацаанд дамжуулахыг шаарддаг. Үүнээс үүдэн яарч буруу бичих, товчлон буруу бичих, эх хэлний боловсролын тааруугаас буруу бичих байдал бий болж байна. Хувь хүмүүсийн хооронд янз бүрийн товчлох арга байж болдог. Жишээ нь, байна > бна, тийн > тн, сайн уу > сн уу гэх мэт. Гэхдээ утгын болон нэгдмэл зарчмыг нь алдагдуулахгүй бичиж байх нь чухал байгаа юм” (Самбуудорж, 2013: 8) хэмээсэн байна.

Гэхдээ цахим орчинд л бол нийтээрээ зөв бичгийн дүрмийн алдаатай бичдэг, алдаатай байх ёстой мэтээр ойлгодог нь ташаа ойлголт юм. Цахим орчны харилцааг ерөнхийд нь хоёр хэсэгт хуваан авч үзэж байгаа билээ. Энэ нь нэгдүгээрт мэдээллийн нь сайт, хоёрдугаарт нийгмийн сүлжээ болно. Мэдээллийн сайтууд нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болохынхоо хувьд тодорхой дэг журамтай, хуульд захирагддаг, монгол хэлний бичгийн хэлний хэм хэмжээ, зөв бичгийн дүрэм баримтлах ёстой “албан ёсны харилцаа”-ны орчин байдаг бол харин сайтад сэтгэгдэл бичих, нийгмийн сүлжээнд хүмүүс хоорондоо харилцах нь харьцангуй хувийн шинж чанартай байдаг учраас дээрх шаардлагуудыг төдийлөн хангахгүй байх нь бий.

2) Интернэт орчин ба кирил бичиг

Монголд үндсэндээ одоо кирил бичиг, латин бичиг, монгол бичиг гэсэн гурван бичгийг хэрэглэж байна гэж хэлж болно. Гар утасны мессежийн хэрэглээг үл тооцон цахим орчинд монголчуудын голлон хэрэглэж байгаа бичиг бол кирил юм. Хэдийгээр гар утасны мессежийн хэрэглээнд кирил үсгээр бичих техникийн боломжтой болсон боловч анх хэрэглэж дадсанаараа латинаар галиглан бичих нь түгээмэл байсан хэвээр байна. Энэ орчинд хэрэглэгч хувь хүн болгон тогтсон стандарт дүрэм баримтлахгүй өөрийн гэсэн латин “хэллэгээр” галиглан бичдэгээс олон янзын буруу гажуу бичлэг үүсэх, энэ нь цаашлаад бүх нийтийн эх хэлний боловсролд сөргөөр нөлөөлөх шалтгаан болж байна.

Харин Монголд анх интернэт нэвтэрснээс хойших монголчуудын цахим орчны бичгийн харилцаанд латин үсгийн хэрэглээ өндөр байлаа. Цахим орчинд кирилээр бичих технологийн боломж сайжирснаар кирилээр бичих хэрэглэгчид нэмэгдсээр байна. Үүнд техник технологийн боломж сайжирснаас гадна хэрэглэгчдийн хандлага өөрчлөгдсөнөөс шалтгаалж байна гэж ойлгож болно. Эх монгол хэлээрээ зөв сайхан бичих хүмүүсийн идэвх зүтгэл нэмэгдсэнээс гадна кирилээр бичих нь уншигчдад төвөггүй, амар хялбар байдагтай холбоотой байна. Эдүгээ кирилээр бичих техникийн боломжгүй гадаадад байгаа хэрэглэгчдээс бусад нь бараг зуун хувь кирилээр бичихийг эрмэлзэх болсон нааштай хандлага сүүлийн үед цахим орчинд ажиглагдах нь их боллоо.

Цахим орчинд бичгийн хэлний хэм хэмжээг баримтлахыг уриалсан, дэмжсэн нааштай хандлагууд байгаа боловч кирилээр бичихдээ зөв бичгийн дүрмийн алдаатай бичих нь харин элбэг хэвээр байна. Үүнийг нэгдүгээрт, үнэхээр олон нийтийн монгол хэлний боловсрол дутуу болон техникийн боломжоос шалтгаалж гаргадаг “санаандгүй алдаа” (Зарим төхөөрөмжид Ө, Ү үсэг байдаггүйгээс эдгээр үсгийг О, У үсгээр орлуулан бичдэг. Ж: өлөн-олон, сусэг-сүсэг, хун-хүн г.м.), хоёрдугаарт, хэрэглэгчдийн албаар гаргадаг “санаатай алдаа” хэмээн хоёр ангилж болно. Тухайлбал, санаатай алдааны жишээнд ярианы хэлний өнгө аяс илэрхийлсэн олон үгийг нийлүүлэн бичих алдааг нэрлэж болно. Ж: явжийна-явж байна, янзлаал-янзлаад, унтсийн-унтсан юм г.м. Гэхдээ дээрх жишээнүүд нь нийгмийн сүлжээн дэх олон нийтийн бичгийн хэлний хэрэглээний байдал бөгөөд сайт буюу хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дээрх нийгмийн сүлжээнүүдийн хэл хэрэглээний байдал нь сөргөөр нөлөөлөх хандлага элбэг байгааг үгүйсгэж болохгүй юм. Албан ёсны сайт гэдэг бол цаасан сонины нэгэн адил хэлний хэмжээг чанд мөрдөх ёстой билээ. Жишээлбэл, www.factnews.mn сайтын нэгэн мэдээний гарчиг нь “Их аварга Д.Дагвадорж ресторанд торгуулынхан мөнгийг төлж тамхи татжээ”¹⁾ гэж байх бөгөөд “торгуулынх нь” гэхийг “торгуулынх” нь хэмээн албан ёсны сайтад хувийн харилцааны орчинд буй хандсан энэ мэт жишээ олон бий.

3) Интернэт орчин ба латин бичиг

Цахим орчны харилцаанд монголчуудын хамгийн өргөнөөр хэрэглэдэг бичиг бол латин галиг юм. Латин галиг үсгийг монгол хэлэнд ашиглах тухайд төрийн зүгээс хэд хэдэн бодлого, баримт бичгүүдийг гаргажээ. Тухайлбал, Монгол Улсын Их хурлаас 2003 онд “Латин үсгийн үндэсний хөтөлбөр”-ийг баталсан байдаг. Уг латин үсгийн хөтөлбөрийн гол зорилго нь мэдээллийн технологийн эрин үед дэлхий нийтээрээ хэрэглэх болсон латин

1) <http://factnews.mn/c02>

үсгээр монгол үгийг тэмдэглэх боломж бүрдүүлж орчин үеийн мэдээлэл, харилцааны технологийн ололтыг ашиглан монгол кирил үсгийг латин үсэгтэй хослуулан хэрэглэх, хооронд нь хөрвүүлэх орчин нөхцөлийг хангахад оршиж байжээ. Өөрөөр хэлбэл монголчуудын амьдралд латин үсгийг хэрэглэх бодит шаардлага үүссэнээс уг хөтөлбөрийг баталжээ.

Латин үсгийн хэрэглээний талаар гаргасан дараагийн нэг чухал ажил бол дээр дурдсан “Баримт бичиг: Монгол кирил цагаан толгойн үсгүүдийг романчлах” MNS 5217:2003 стандарт юм. Үүнийг Стандарт, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2003 оны 12 сарын 25-ны өдрийн 70 тоот тогтоолоор баталж 2004 оны 1 сарын 1-нээс өдрөөс эхлэн мөрдөхөөр тогтжээ.

Латин үсэг дэлхий дахинд улам түгэн дэлгэрсээр байгаа энэ цаг үед монгол үгийг латинаар тэмдэглэх тухайд элдэв маргаан, үл ойлголцолгүй нэгэн мөр хамгийн эвтэйхэн хувилбараар шийдвэл тун чухал билээ. Гэвч нэгдсэн стандарттай байсан ч түүнийгээ даган хэвшүүлэх соёл монголчуудад тун дутмаг байдаг. Гэхдээ албан ёсоор даган мөрдөх учиртай латин стандартад дутагдалтай талууд ч байдаг нь үүнд нөлөөлдөг биз ээ.

Монгол кирил үсгийг латинчилахад тулгардаг, хэрэглэгчдийн дунд олон янзаар бичдэг, маргалддаг, олон нийтийг үл ойлголцоход хүргэдэг цөөхөн хэдэн үсэг байдаг нь ө, ү, х, в, ц үсгүүдийг латинаар хэрхэн бичих вэ гэдэг асуудал юм. Дээрх 2003 оны стандартад дараах үсгүүдийг:

ө – o’

ү – u’

х – x, kh

в – v

ц – c гэж тэмдэглэхээр тогтоосон байдаг.

Энэ бол төрийн зүгээс баталж өгсөн стандарт албан ёсны стандарт юм. Гэвч хэрэглээ бол арай өөр байсаар өнөөг хүрсэн бөгөөд цахим орчинд дээрхийг хэрэглэгчид маш олон янзаар бичсээр байна. Тухайлбал, ө > o, u хэмээн 2 янзаар (Ж: өлөн > olon, ulun, өнөөдөр > onoodor, unuudur), ү > u хэмээн (Ж: үргээлэг > urgeeleg), х > x, kh, h хэмээн 3 янзаар (Ж: ходоод > xodood, хулан > khulan, хугацаа > hugatsaa), в > v, w хэмээн 2 янзаар (Ж: овоо > ovoo, ваар > waar), ц > c, ts хэмээн 2 янзаар (цэцэг > cecceg, цэцэрлэг > tsetserleg) тус тус тэмдэглэсээр ирэв.

Дээрх галигийн дутагдалтай тал нь хэрэглээнд ovoo гэвэл овоо юм уу, өвөө юм уу,

өлөн гэхийг *ulun*, *olon* гэж бичих үү, аль эсвэл *х* үсгийг латины *х* (икс) нь зөв юм уу, *kh* (хоёр үсгийн нийлбэр) нь зөв юм уу гэх мэтээр олон янзын үл ойлголцол маргаан дагуулах нь бий. Ийнхүү хэл шинжлэлийн эрдэмтдийн болон болон зарим иргэдийн боловсруулсан латин галигууд нийтэд хэвшээгүй, албан ёсны болоогүй учраас дур дураар бичсэн хэвээр л байлаа. Энэхүү дур дураар бичсэнийг нь бусад хүмүүс ч төвөггүй ойлгодог учраас ямар нэгэн төвөгшөөх асуудал гардаггүй нь энэхүү эмх цэгцгүй байдлыг улам дэврээсээр байсан гэж хэлж болно.

Латинаар галиглах стандартыг мөрдөхгүй байгаагаас зарим нь бүр нэг үсгийг хоёр гурван янзаар тэмдэглэх, үгийг бол бүүр олон янзаар бичиж байгаа нь яавч зөвтгөх зүйл биш билээ. Жишээ нь, Мөнхөө гэсэн хүний нэрийг зургаан янзаар (*Monhoo*, *Munhuu*, *Munkhuu*, *Monkhoo*, *Monxoo*, *Munxuu*), Чингис хааныхаа нэрийг доод тал нь дөрвөн янзаар (*Chinggis*, *Chingges*, *Genghis*, *Qingis*) бичиж байгааг иргэн А.Баярхүү анзааран бичжээ. Энэ нь гадны улс орон, хүмүүстэй харьцахад төвөг удахаас гадна эхийг компьютерт таниулах гэх мэтэд хүндрэл учруулдаг юм.

Монгол кирил үсгийг латинчлахад дээрх мэт олон маргаантай асуудал байсан учраас 2003 оны стандартыг сайжруулах үүднээс шинээр дахин нэг стандарт 2012 онд баталсан нь одоогоор албан ёсны байгаа болно. Энэ бол Стандартчиллын үндэсний зөвлөлийн хурлаар баталсан “Монгол кирил үсгийн латин хөрвүүлэг MNS 5217:2012” стандарт юм. Үүгээр 2003 оны стандартыг сайжруулахыг оролдсоныг өмнө авсан жишээтэй харьцуулан харвал:

2003 он	2012 он
ө – о’	ө – ö
ү – u’	ү – ü
х – х, kh	х – kh
в – v	в – v
ц – c	ц – ts

Дээрх харьцуулалтаас харвал ө болон ү үсгийг галиглахдаа өмнөх шиг’ гэсэн нэмэлт тэмдэглэгээгүйгээр шууд герман хэлний “умлаут”-тай үсэг буюу дээрээ нэмэлт тэмдэглэгээтэй ö, ü галигаар, ц үсгийг ts-гээр, х үсгийг нэгэн мөр kh-ээр шийдсэн нь өмнөхөөсөө сайжирсан гэж үзэж болох болно.

Дээрх албан ёсны латин галигийн стандартаас гадна сэтгүүлч Ч.Мөнхбаярын 1999 онд зохиогчийн эрх авсан “Монгол латин үсэг” гэж байдаг бөгөөд энэ нь “албан ёсны хувилбараас ялгаатай нь, давхар үсгээс (лигатур) гадна, тэмдэгт (диакрит) үсгийг санал

болгосон, олон хувилбар дэвшүүлсэн, лигатураар бичигддэг авиаг нэг янзаар бичих зарчмыг гаргаж ирсэн” (Мөнхбаяр) зэрэг онцлогтой ажээ. Мөн нийтлэлч Баабарын энгийн олон нийтэд санал болгосон “Латин үсгийн монгол галиг” (Баабар) гэж бий. Энэ нь:

A-A, Б-B, В-W, Г-G, Д-D, Е-Ye, Ё-Yo, Ж-J, З-Z, И-I, Й-I, К-K, Л-L, М-M, Н-N, О-O, Ө-Q, П-P, Р-R, С-S, Т-T, У-U, Y-V, Ф-F, Ы-Yi, Ъ-, Ь-, X-X, Ц-Ts, Ч-Ch, Ш-Sh, Ш-Shch, Э-E, Ю-Yu, Я-Ya

гэсэн санал бөгөөд латин q үсгээр монгол хэлний ө-г, v үсгээр ү үсгүүдийг орлуулах санал нь элдэв нэмэлт тэмдэг тэмдэглэгээг хэрэглэхгүйгээр шийдсэн нь хэрэглэхэд илүү хялбар, энгийн байх гэсэн онцлог давуу талуудтай байна.

Кирил үсэг		Латин үсэг		Хөрвүүлэх жишээ	
Том	Жижиг	Том	Жижиг	Латин үсгээр	Кирил үсгээр
А	а	A	a	Avarga, khalbaga, aav	Аварга, халбага, аав
Б	б	B	b	Baga, sambar	Бага, самбар
В	в	V	v	Avarga, vagon, sav	Аварга, вагон, сав
Г	г	G	g	Gazar, geree, khereg	Газар, гэрээ, хэрэг
Д	д	D	d	Dadlaga, akhmad	Дадлага, ахмад
Е	е	Ye	ye	Yeeven, yerööl	Еэвэн, ерөөл
Ё	ё	Yo	yo	yorool, oyodol	Ёроол, оёдол
Ж	ж	J	j	Juulchin, ajil, Jon	Жуулчин, ажил, Жон
З	з	Z	z	Zam, azarga, baaz	Зам, азарга, бааз
К	к	K	k	Kino, kilometr, akademi	Кино, километр, академи
И	и	I	i	Ishig, bichig, khani	Ишиг, бичиг, хань
Й	й	I	i	lim, eejin	Ийм, ээжийн
Л	л	L	l	Lam, alag, mal	Лам, алаг, мал
М	м	M	m	Mal, khamar, nam	Мал, хамар, нам
Н	н	N	n	Nar, khana, ünen	Нар, хана, үнэн
О	о	O	o	Oron, bolovsrol, toono	Орон, боловсрол, тооно
Ө	ө	Ö	ö	Ödör, öndödör, ööröösöö	Өдөр, өнөөдөр, өөрөөсөө
П	п	P	p	Puujin, aparat	Пуужин, аппарат
Р	р	R	r	rashaan, radio, sar	Рашаан, радио, сар
С	с	S	s	Sar, asar, etses	Сар, асар, эцэс
Т	т	T	t	Tamga, tatlaga	Тамга, татлага
У	у	U	u	Uran, nuruu	Уран, нуруу
Ү	ү	Ü	ü	Ünen, türgen, tergüün	Үнэн, түргэн, тэргүүн
Ф	ф	F	f	Foto, fond	Фото, фонд
Х	х	Kh	kh	khavar, nökhör, ekh	Хавар, нөхөр, эх
Ц	ц	Ts	ts	Tsatsag, tsetseg	Цацаг, цэцэг
Ч	ч	Ch	ch	Chimeg, chadal, ach	Чимэг, чадал, ач
Ш	ш	Sh	sh	Shashin, aash	Шашин, ааш
Щ	щ	Sh	sh	Shedrin, Shors,	Щедрин, щорс
Ъ	ъ	I	i	Oriyo, suriya, gariya,	Орьё, суръя, гаръя
Ы	ы	Y	y	Khaany, akhyn	Хааны, ахын
Ь	ь	I	i	Khari, bari	Харь, барь
Э	э	E	e	Ezen, ene, emeel	Эзэн, энэ, эмээл
Ю	ю	Yu	yu	Yum, yuüden	Юм, юүдэн
Я	я	Ya	ya	Yamar, yaduu, aya	Ямар, ядуу, ая

“Монгол кирил үсгийн латин хөрвүүлэг MNS 5217: 2012” стандарт

Ийнхүү монголчууд бидний 1930-аад оноос эхлэн танилцсан латин үсэг нь цахим орчны өнөөгийн харилцаанд маш өргөн хэрэглээтэй байсан хэвээр байна. Монгол улсад англи хэл нь залуучуудын хамгийн их сурдаг гадаад хэл билээ. Үүнийг дагаад залуучууд бүгд латин үсгийг эзэмшсэнээс гадна компьютер, гар утас зэрэг дэвшил нь тэднийг монгол үгийг латин галигаар бичихийг өөрийн эрхгүй шаардаж байна. Латин галигийн ач холбогдлын талаар доктор О.Самбуудорж “Энэ нь бичгийн хэл бүхий одоо үеийн монгол хэлт ард түмний хувьд, зөвхөн тухайн нэг аялгууны бичгийн хэлэнд төдийгүй, нийт монгол хэлт ард түмэнд интернэтээр харьцах зэрэгт хэрэглэвэл зохих латин үсэгт суурилсан нэгдсэн дүрэм хэрэгтэй байгааг харуулж байгаа юм. Ийм байдал нь монгол хэлт ард түмний бичгийн хэлний соёлын холбоонд эерэг нөлөө үзүүлэх нь эргэлзээгүй билээ” (Самбуудорж, 2005: 39) гэсэн байдаг. Дэлхий даяаршихын хамтаар монгол хэлний хэрэглээнд ч цаашид чухал үүрэгтэй байж өсөн нэмэгдэх хэрэгцээ бол латин үсгийн хэрэглээ гэдэг нь маргаангүй билээ.

Интернэт орчны зөв бичгийн түгээмэл алдаа

Интернэт гэдэг зүйл үнэхээр хүчтэй, далайцтай, нөлөөтэй хэрэгсэл гэдэгтэй эдүгээ хэн ч маргахгүй болжээ. Энэ хүчтэй хэрэгсэл сайн дэвшилтэт зүйл дагуулахын хамтаар хор уршиг тарихдаа ч хүчтэй юм. Ийм учраас интернэт дэх мэдээллийн байгууллагууд болон нийгмийн сүлжээний хэрэгслүүд нь олон нийтийн бичиг үсгийн боловсрол, хэлний хэм хэмжээ зөрчигдөхөд, монгол хэлний аюулгүй байдалд томоохон нөлөө үзүүлэгч хэрэгслүүд болжээ.

Өнөөгийн дэлхий ертөнцийн дэг жаягаар бүх зүйл даяаршиж байгаа боловч бидний эх хэл маань л дангааршиж үлдэх ёстой биз ээ. Интернэт гэдэг зүйлийг бид эх хэлээ эвдэх биш цэвэр ариун орчин байлгах нь зүйтэй байна. Нөгөө талаар интернэтийг бүх нийтийн эх хэлний боловсролд муугаар биш харин сайнаар нөлөөлөхөд нь ашиглавал их хэрэгтэй юм. Энэ бол интернэт монгол хэлэнд сайнаар нөлөөлөх давуу тал болно. Гэвч цахим орчинд зөв бичгийн дүрмийн хэм хэмжээг сахихгүй байх нь түгээмэл байна. Ердөө цахим орчинд мэт боловч олон хэрэглэгчтэйн хувьд буруу үлгэрийг нийгэмд үзүүлж байгаа нь харин түүний сөрөг тал нь юм. Эдгээрийг ерөнхийд нь 1. Албан ёсны мэдээллийн хэрэгслийн санамсаргүй гаргадаг алдаа болон 2. Албан ёсны бус харилцаан дахь санаатай гаргадаг алдаа гэж ангилж болох юм. Энэ нь:

Албан ёсны мэдээллийн хэрэгслүүдийн санамсаргүй гаргадаг алдаа:

Орчин үед албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоонд мэдээллийн сайтууд зүй

ёсоор орох болжээ. Учир нь мэдээллийн сайтууд гэдэг нь өөрийн гэсэн сурвалжлагч, редакторуудтай бүхэл бүтэн редакци байдаг бөгөөд цаасан дээр хэвлэгддэггүй л болохоос сонин сэтгүүлийн газартай яг адилхан олон нийт, хуулийн өмнө үүрэг хүлээж ажилладаг аж ахуйн нэгж гэсэн үг юм. Бүр сонин сэтгүүлээс ч илүү олон давуу талыг өөртөө агуулж байдаг гэж хэлж болно. Энэ нь нэгдүгээрт сонин сэтгүүлийг нэг удаа л худалдаж аваад түүнийгээ цуглуулахгүй л бол мэдээллийг нь дахин үзэх боломжгүй байдаг бол интернэт орчинд нийтлэгдэж буй мэдээлэл нь хэзээ ч үзэж болохоор нээлттэйгээр архивлагдан хадгалагдаж байдгаараа давуу бол хоёрдугаарт аливаа мэдээллийг үзэх унших хүний тоогоор мэдээллийн вэб сайтууд хамаагүй давуу талтай байдаг. Хамгийн энгийн жишээ авахад л өдөр тутмын Монголын хамгийн том сонины нэг “Өнөөдөр” сонины улирлын захиалгын тоо 7000 орчим байдаг. Худалдан авалт буюу шууд борлуулалтаар 1000~1500 орчим” (Нандинтүшиг) сонин борлогддог бол “Монголын шилдэг нийтлэлчдийн клуб” (www.baabar.mn)-ын нэг нийтлэлчийн нийтлүүлсэн зүйл 7000 хандалтыг ердөө ганцхан цагийн дотор авч чадаж байгаагаар орчин үеийн мэдээллийн хэрэгслийн олон давуу талын ердөө ганцхан давуу байдал нь ийм байгаагаар хичнээн хүчирхэг болох нь харагдана.

Харамсалтай нь, ийм нөлөө бүхий хүчтэй мэдээллийн хэрэгсэл атлаа Монголын мэдээллийн сайтуудын олонхи редакциуд маш хариуцлагагүй, бүдүүлэг алдаанууд гаргасаар байна.

Энэ нь: 1. Сонины редакцийг бодвол илүү хариуцлагагүй, 2. Боловсон хүчний чадавхи тааруу, мэргэжлийн сэтгүүлчид ажилладаггүй зэрэг олон шалтгаануудтай холбоотой.

Жишээлбэл, мэдээнийхээ гарчгийг гэхэд л дараах байдлаар алдаатай бичсэн нь тааралдана.

“Их аварга Д.Дагвадорж ресторанд торгуулыхан мөнгийг төлж тамхи татжээ”²⁾ (Албан ёсны сайтад ярианы хэлээр бичсэн)

“Ц.Элбэгдорж and Си Зиньпин”³⁾ (Англи болон монгол үгийг хольж бичсэн)

Албан ёсны бус харилцаан дахь санаатай гаргадаг алдаа:

Энэ хэсэгт ихэвчлэн нийгмийн сүлжээ хэмээх хүмүүсийн хувийн харилцааны орчинд нийтлэг тохиолдож буй зөв бичгийн дүрмийн алдаа, гажуудлуудын талаар өгүүлэхийг зорив. Зүй нь нийгмийн сүлжээний орчин нь хянах шаардлагагүй олон нийтийн хувийн харилцааны орчин боловч бүх нийтийн эх хэлний хандлагад маш ихээр нөлөөлж байгаа учраас орхиж болохгүй сэдэв юм. Дараах төрлийн “алдаанууд” их төлөв тохиолдоно:

2) <http://factnews.mn/c02>


3) <http://zaluu.com/news/index.php?url=http://www.24tsag.mn/content/62245.shtml>

1. Балархай эгшгийг гээхгүй бичих. Ж: намын, хаварын, тараган
2. Техникийн боломжоос шалтгаалсан. Ж: гоя гэж зарим төхөөрөмжид ё үсэг байдаггүйгээс үүнийг я-гаар орлуулж их бичдэг бөгөөд иймэрхүү үгүүдийг ингэж бичиж хэвших, цаашид ингэж дуудаж хэвших гэх мэтээр зөв дуудах хэм хэмжээг ч зөрчихөд хүргэж байна.
ИТХ ын дарга нь т@л@гчидд@а ээлж дараалан шанаа @гч зодуулсан хvmvc хорссондоо нийлж бгаад унагаж элгийн юм ч болох юм даа #дорнод
3. Эггээд хэв маяг илэрхийлэх зорилгоор нэг болон түүнээс дээш тоотой үгийг хооронд нь нийлүүлж бичих. Ж: таоёр > та хоёр, нийлжийгаад > нийлж байгаад, нэг их > нээх
4. Нутгийн аялгаар эггээд хэв маягийг илэрхийлэх. Ж. больчкээч > больчихооч
5. Зай талбай, цаг хэмнэхээс үүдсэн ямар ч тогтолцоогүй товчлох байдал. Ж: бсна > байснаа
6. Нөхцөл, дагаврыг буруу хэрэглэх. Ж: хайр л, хайрл > хайрла

Дээр байгаа жишээнүүдээр мэдээж чөлөөтэй, эрх дураараа монгол хэлээ нийгмийн сүлжээнд хэрэглэж болохыг харуулав. Гэхдээ аливаа зүйл тун хэмжээнээсээ хэтрээд ирэхээрээ бас сөрөг талуудыг үүсгэх нь бий. Өөрөөр хэлбэл хувийн харилцаа, албан харилцаагаа ялгаж салгахаа больсноос үүдэн эх хэлний ядуурал доройтол, эмх замбараагүй байдал газар авч хожим засахад ч бэрх аюул болох вий гэдэг үүднээс үл тоон өнгөрч болохгүй зүйл юм. Дараах энгийн нэгэн жишээнээс харахад л нийгмийн сүлжээ гэдэг хувийн харилцаа албаны харилцааны хэлэнд хэрхэн нөлөөлж болохыг харуулна.

Данс эзэмшигчийн нэр/Account Name:	
ХАТАГТАЙ НЯМСҮРЭН НАМУУН	
Гүйлгээний код/Transaction Code:	
1010 ОРЛОГО БЭЛНЭЭР	
Гүйлгээний утга/Description:	
ЗУЭЭР Л ОРЛОГО	
Гүйлгээний хураамж/Transaction Fee:	Дансны дугаар/Account No:

Энд “Зүгээр л орлого” гэхийг “Зуээр л орлого” хэмээн залуусын өөрсдийн харилцааны хэлний этгээд хэв маягаар бичсэн байна.



“Нөөц” гэдэг үгийг латинаар оновчгүй галигласнаас энэ үгийг “нууц” хэмээн уншсанаар буруу утгаар ойлгогдож байгаа жишээ юм.

Монгол хэл маань зөв бичгийн дүрмийн хүрээнд сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлж ч чадах, хурдан бичиж ч болох, ярианы найруулгаар бичсэн ч болох, хэлээ эвдэхгүйгээр бусдад өвөрмөц харагдаж ч болох хангалттай боломжтой баялаг хэл, бичиг билээ. Гэхдээ эндээс интернэтийн орчинд монгол хэл маань мөхөөд байна уу, хөгжөөд байна уу? гэдэг асуудал урган гарч байна. Мэдээж бүх зүйл хоёр талтай байдаг. Нэг талаар монгол хэлийг улам баялаг агуулгатай болгох, найруулгын олон өнгө төрхтэй болгох талаасаа хөгжүүлж байгаа боловч нөгөө талаар монгол хэлийг эвдэх, бүх нийтэд буруу үлгэр дууриал болохын хувьд мөхөөх тал нь давамгайлах хандлагатай гэж дүгнэж болохоор байна. Учир нь интернэт олон нийтэд нөлөөлөх маш хүчтэй хэрэгсэл юм. Цаашдаа улам илүү хүчтэй болох нь гарцаагүй.

Интернэт ба зөв дуудах хэм хэмжээ

Ухаант хүмүүн өөрийн эх хэлээрээ яруу төгөлдөр зөв сайхан ярьж чаддаг байх нь эх хэлний боловсролтой нь шууд холбоотой гэдэг. Тиймээс “аман ярианы хэлэнд хамаарах хамгийн чухал хэм хэмжээ нь дуудлагын хэм хэмжээ юм. Хэлний хэм хэмжээнд таарч тохирсон зөв дуудлага нь зөв бичлэгийн нэгэн адил онцгой ач холбогдолтой. Хүний ой ухаанд юуны түрүүд өртөгддөг зүйл бол үгийн дуудлага гэж судлаачид үздэг” (Пүрэвжав, 1996: 21) байна.

“Үгийн зөв дуудахуй бол хэлэнд нэгэнт хэвшин тогтсон, нийтээрээ хүлээн зөвшөөрсөн дуудлага” (Самбуудорж, 2011: 4) юм. Хэдийгээр үгийг зөв дуудах нь албан харилцаа, нийтэд зориулсан илтгэл тавих, уран илтгэхэд маш чухал боловч буруу дуудлага нь

явсаар бичгийн хэлэндээ нөлөөлөх нь бий. Тухайлбал, энэ талаар доктор Э.Пүрэвжав “Ярианы хэл, бичгийн хэл хоёрыг сайтар ялган салгаж ойлговол зохино. Үүнтэй холбогдуулж хэлэхэд монгол ярианы хэлэнд “хэн мэдэхэв”, “яахав”, “яахан” гэсэн маягтай дуудагддаг үгсийг бичгийн хэлэнд “хэн мэдэх вэ”, “яах вэ”, “яах нь” зэргээр бичих хэрэгтэй байна. Алдаа мадагтай дуудлага нь мэдээллийг буруу ойлгуулах, хэлж ярих гэсэн зүйлээ бусдад хүргэж чадахгүй байх гэх мэтэчлэн олон талын муу үр дагавартай” (Пүрэвжав, 1996: 27) гэжээ. Энэ мэтээр сүүлийн үед олон нийтийн дунд үг хэллэгийг буруу хазгай дуудах, дуудлагаараа бичих зэрэг тохиолдол их болжээ.

Интернэт орчинд үгийг ярианы дуудлагаараа бичих явдал их болсон билээ. Харин цахим орчны харилцаанд үгийг этгээд, буруу бичсэнийгээ эргээд яриандаа хэрэглэхдээ буруу дуудах хэв маяг газар авч буйг анхаарахгүй өнгөрч боломгүй. Энэ нь ялангуяа залуус хоорондын аман харилцаанд түгээмэл тохиолдож байгаа нь анзаарагдах болов. Өөрөөр хэлбэл бичлэг нь дуудлагадаа нөлөөлөх байдал ажиглагдаж байна гэсэн үг юм. Энэ нь залуучууд хэл яриандаа нийгмийн сүлжээнд бичгээр харилцдаг шигээ яриагаа хэт чамин болгох, этгээд хэв маяг үзүүлэхээс нь шалтгаалж байна.

Тухайлбал, залуус, тэр дундаа охидын хэл ярианд “гоё” гэдгийг “гоя” (гар утас гэх мэт төхөөрөмж дээр ё үсэг байдаггүй байснаас ё үсгийг я-гаар орлуулан бичдэг байснаас) гэж, “сайн уу” гэхийг “сээнүү” (цахим орчинд сээнүү, seenuu гэх мэтээр бичдэг) гэж, “яадаг юм бэ” гэхийг “аадийн” (Цахим орчинд энэ мэтээр жижиг хүүхдийн ярианы хэлээр бичих нь түгээмэл) гэж дуудах үзэгдэл цөөн биш байгаа нь анзаарагддаг.

“Хэл яриа бол хүн өөрөө юм” гэсэн үг байдагчлан аливаа хүнийг ямар маягийн дуудлагаар ярьж буйгаар нь боловсрол, соёлынх нь хэмжээг тодорхойлж болно гэж үздэг. Ярианы хэлэнд ерөнхийдөө эрхэмсэг, энгийн, хар ярианы гэсэн гурван дуудлагын хэлбэр байдаг бөгөөд “Эрхэмсэг дуудлага бол үг, үеийг бүрэн бүтэн дуудаж, санаагаа төгс илэрхийлэх зорилготой байдаг бол энгийн дуудлага нь бидний өдөр тутмын харилцаанд үүрэгтэй, хэлний тогтсон хэм хэмжээний дагуу хэвийн ярьж хэлэх дуудлага байдаг. Хар ярианы дуудлага бол хэлний тогтсон хэм хэмжээг анхаарахгүй хааш яаш хэлэх дуудлага” (Самбуудорж, 2013: 6) юм.

Энд өгүүлэн буй дээрх жишээ нь интернэт орчны бичгийн харилцааны өнөөгийн хэв маяг, байдал нь залуучуудын яриа, дуудлагад сөргөөр нөлөөлж байгааг харуулж байна. Хэдийгээр цөөн тааралдах жишээ гэж хэлж болох боловч цаашдаа монгол хэлний зөв дуудах хэм хэмжээнд сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрэхийг үгүйсгэж боломгүй. Аливаа хэлэнд зөв дуудах хэм хэмжээг заавал даган биелүүлж байх ёстой. Үүнийг доктор О.Самбуудорж хэлний сахилга бат, хэлний засаг гээд хэрвээ хэлний сахилга батаа гэвээс

“бид аман болон бичгийн хэлний хувьд харилцаж чадахгүйд хүрч, улмаар соёл, боловсролын хувьд доройтох аюултай байдаг” (Самбуудорж, 2014) хэмээсэн байдаг.

Дүгнэлт

Нийгмийн шинжлэх ухааны салбарт хамаардаг томоохон судалгааны чиглэл бол хэл шинжлэл юм. Хүмүүний хэлийг судалдаг шинжлэх ухаан бий болсноос хойш олон олон үзэл баримтлал бий болон нарийсан хөгжсөөр иржээ. Хэл шинжлэл нь орчин үед “Онолын хэл шинжлэл” (Theoretical linguistics), “Тодорхойлох хэл шинжлэл” (Descriptive linguistics), “Хавсарга хэл шинжлэл” (Applied linguistics) гэсэн гурван чиглэлээр хөгжиж байна. Дэлхийн хэл шинжлэлд үүсэн бий болоод удаагүй байгаа нэгэн шинэхэн салбар болох “интернэт хэл шинжлэл” нь хавсарга хэл шинжлийн чиглэлд хамаардаг билээ.

Эдүгээ дэлхийн олон оронд интернэтийн хэл шинжлэлийн судалгааны төвшин мэдээж өндөр байна. Харин Монголд хийгдсэн энэ чиглэлийн судалгаа тооны хувьд цөөн, басхүү шинэ тутам хэвээр байгаа боловч тодорхой амжилтад хүрсэн гэж үзэж болохоор болжээ. Учир нь интернэт орчны хэлний асуудалд монгол хэл шинжээчид анхаарлаа нэгэнт хандуулж эхэлсэн бөгөөд энэ талаар эрдэм шинжилгээний өгүүллүүд цөөнгүй хэвлэгдэж, мөн нэгэн сэдэвт судалгааны бүтээл гарсны хамт дагнасан судлаачидтай ч болсон нь олзуурхууштай байна.

Монгол хэл байнга хувьсан өөрчлөгдөж байдаг хэлний хөгжлийн түүхэн үйл явцыг тойрч биш дайрч өнгөрсөөр өнөөг хүрлээ. Энэ үйл явц өнөөдөр ч өрнөж байна. Харин энэ үйл явц өрнөх нэгэн хөрс нь интернэт орчин болжээ. Монголд интернэтийн хэлний судалгаа амжилттай хөгжиж байна.

Ном зүй

Баабар, Б. Монгол бичигт латин галиг ингэж хэрэглэе.

<http://baabar.niitlelch.mn/content/3794.shtml>

Латин үсгийн үндэсний хөтөлбөр. <http://www.legalinfo.mn/annex/details/3073?lawid=6108>.

Бат-Ирээдүй, Ж. 2011. Твиттер ба монгол твиттерчид.

<http://iregedui.blogspot.com/search/label/Твиттерийн%20тэмдэглэл>

Болд, Л. 2012. *Монгол хэл шинжлэлийн түүхийн асуудлууд*. Уб.

Болд-Эрдэнэ, Б. 2009. *Интернэт сэтгүүл зүй*. Уб.

Интернэт. 2006. Бүрэн хэмжээний гарын авлага. Уб.

Лувсанвандан, Ш. Крилл үсэг авсны учир.

Монгол улсын өрсөлдөх чадварын тайлан 2014. 2015. Уб.

Мөнхбаяр, Ч. Латин үсэг Монгол ба дэлхий дахинд.

http://moenhbayar.blogspot.com/2011/01/blog-post_9324.html

Нандингүшиг, Б. “Хэвлэл мэдээлэл мөнгөнд автагдаж буруу зүйл хийж болохгүй их эмзэг салбар” ярилцлага. <http://www.iikon.mn/lr/omt>

“Орос үсэг дээр үндэслэсэн монгол шинэ үсэг батлах тухай” Ардын Сайд нарын зөвлөл, МАХН-ын Төв хорооны тэргүүлэгчдийн 1941 оны 5-р сарын 9-ний хамтарсан хурлын тогтоол.

Орчин цагийн монгол хэл. 2008. редактор Өнөрбаян Ц, Цог-Очир А, Ариунболд Ү. Уб.

Пүрэжав, Э. 1996. Монгол хэлний хэм хэмжээ. Уб.

Самбуудорж, О. Зөв бичих нь үүрэг хариуцлага мөн.

<http://www.khelzokhiol.mn/news.php?nid=27>

Самбуудорж, О. 2010. Нийтийн эх хэлний боловсролын асуудалд. “Хэл зохиол судлал” ЭШБ. Боть VI (38). Уб.

Самбуудорж, О. 2005. Тод монгол үсгийн бичгийн хэлний тойм, Осака.

Томтогтох, Г. 2009. *Хэл шинжлэлийн удиртгал*. Уб.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мониторингийн судалгаа. 2013. Монголын хэвлэлийн хүрээлэн. Уб.

Цагаан ном. 2014. *Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын хөгжил*. Уб.

Шинэбаяр, О. Монгол хэлний хэрэглээ, найруулга, уран сайхны эхийн шинжлэл, Уб.

Шинэ латин үсэг батлах тухай МАХН-ын Төв хороо, Сайд нарын Зөвлөлийн 1941. 02.21-ний өдрийн хамтарсан тогтоол.

Энхбат, Д. 2008. Монголд интернэт нэвтрүүлсэн түүх.

<http://www.enkhbat.mn/2008/10/монголд-интернэт-нэвтрүүлсэн-түүх.html>

Энхмаа, Б. 2015. *Интернетийн хэл шинжлэл*. Уб., Соёмбо принтинг ХХК. 161 х.

Эх сурвалж: Монгол улсын өрсөлдөх чадварын тайлан 2014. 2015. Уб.

World Internet Users and 2015 Population Stats. 2015.

<http://www.internetworldstats.com/stats.htm>

https://en.wikipedia.org/wiki/List_of_virtual_communities_with_more_than_100_million_active_users

<http://www.statisticbrain.com/twitter-statistics/>

Талархал

Уг хуралд оролцож илтгэл тавих бололцоо олгосон “Монгол хэлнүүдийн стандартчилал, нормчлол, мэдээлэлжүүлэлт, олон улсын нийтлэг хандлага” монгол хэл шинжлэлийн олон улсын эрдэм шинжилгээний гуравдугаар хурлын зохион байгуулах хороонд талархал илэрхийлье.

논 문 투 고 일 : 2018년 10월 30일
논 문 심 사 일 : 2018년 11월 15일
논문게재결정일 : 2018년 11월 30일

Phonetic Evolving Patterns of Mongolian Language Family^{*}

Jin Shuanglong^{**}

Abstract

Phonetic Evolving Patterns of Mongolian Language Family

Jin Shuanglong^{**}

This paper explains the phonetic evolution of Mongolian language by taking the phonetic phenomenon of Mongolian language as the object. The phonetic evolution of the Mongolian language follows the directional development law of the system, the mutual constraint law of the factors in the system, the visibility of the system development process, and the nonlinear evolution of the factors in the system, which produces the unique evolution of the Mongolian language.

Keywords : directional evolution; constraint evolution; gradual evolution; distributed evolution

There are particular regularities in the phonetic evolving process of the Mongolian languages. After making an analysis on the special phonetic evolvement phenomenon of the Mongolian languages, the thesis gets the following conclusion: directional evolvement, controlling evolvement, gradual evolvement, distributing evolvement and Implication of phonemic loan.

I . Directional evolvement: higher evolvement of bilabial vowels


The past the phonetic study of Mongolian language family usually focused on phonemic description. Accurate phonemic description is the basis of studying a phoneme, which, however,

* Staged achievements of national social science fund project titled *Typology Research of the Mongolian Language* / tjinshuanglong@163.com

** Chifeng University

can not make a clear illustration if we study a language from the perspective of historical linguistics. Hence, we should make a clear description of the allophones, which not only helps us to further understand and study Mongolian phonetic history, but reasonably interpret the important role of the developing and evolving process and regularities of Mongolian in the Mongolian languages.

Just as the variant /ɔ/ of the two monophthongs /u/ and /o/, the appearance of phonemic variants in the evolving process of phonemes shows the following two phenomena: one happens in the initial phase of phonemic evolution when one vowel was differentiated into diverse phonemes in different conditions, another is the residual phenomenon of phonemic merger, that is, although several phonemes have been merged into one phoneme because of various external factors, these phonemes would still remain in some dialects before the merger. The free variants /ɔ/ and /ʊ/ for the two vowels phonemes /u/ and /o/ of the Dongxiang language mentioned above belong to the latter phenomenon, which is not an accidental, but an inevitable result of the evolution of Mongolian in the Dongxiang language. However, scholars have different opinions on the number of vowel phonemes in Middle Mongolian. The divergence is between five or seven vowels in Middle Mongolian. In the works *Weiwo Styled Mongolian and Mongolian Phonemes* by Irinchin, *A comparison of the Basic Vowels of Mongolian Language Family* by Hugjilertoo and *A Study of Ancient Mongolian* by Shuangfu, they state that there are five vowels a, e, i, o, u. While his books titled *A Study of Mongolian Phonemic History*, Mengheboyin thinks there are seven vowels a, e, i, o, u, ö and ü in Middle Mongolian. Therefore, the divergence seems to focus on the four bilabials o, u, ö and ü. In my opinion, there are seven Mongolian vowels which are in the evolving phase, whose evolving trace can be found from the languages of the Mongolian languages as well as their dialects. The two bilabial vowels /o/, /u/ are the merging results of the two Ancient Mongolian vowels o[ɔ] and u[ʊ] with the two vowels o[ɔ] and u[ʊ]. The higher directional evolution of the bilabial vowel system in the Dongxiang language results the merger of o[ɔ] and u[ʊ] into [o] and [u]. The existing free variant [ɔ] and [ʊ] of the two vowels /o/ and /u/ are a residual phenomenon. The specific evolving process is showed in the following pic. 1.21.



Pic.1.21 The evolution of the bilabial vowels in the Dongxiang language

In her doctoral thesis *A Study of the Contact between the Mongolian Language and the Dongxiang Language*, Bosarina proposes it is the break-up of the controlling system that causes the harmoniously weakening phenomenon of the vowels in the Dongxiang language. If analyzing from the changing of the bilabial vowels of the Dongxiang language, we found her opinion above is true. The following shows some distinctive features of Mongolian rounded vowels.

Picture 1.24 Distinctive features of Mongolian rounded vowels

	Positive	Negative	Rounded	Unrounded	Higher	Lower
ɔ	+	-	+	-	-	+
ʊ	+	-	+	-	-	+
o	-	+	+	-	-	+
u	-	+	+	-	-	+

The above picture shows that the four vowels ɔ, ʊ, u, o are polymerized from the perspective of “rounded” and “unrounded”, while the four vowels are opposite from the perspective of “positive” and “negative”. In the Dongxiang and Baoan languages etc, as ɔ, ʊ have been merged with u, o, the places of ɔ, ʊ become empty. Therefore, the harmoniously weakening of the positive vowels system causes the weakening of the vowel harmony.

II. Controlling evolvement — controlling pattern of head vowels originating from vowels

Өдөр тутмын сонины үгийн давтамжийн судалгааг найруулга зүйч, профессор Ц.Сүхбаатар (“Монгол хэлний найруулгын төрөл” гэдэг хамтын бүтээлийн “Сонины хэл найруулга”) багш хийсэн байдаг. Тэрбээр 1920 оны 11-р сарын 10-ны өдрийн “Монголын үнэн” (анхдугаар) сонины үгийн давтамж 637 гэж тооцоолжээ.

Мөн доктор Л.Балдан үүнийг улам хөгжүүлэн 1920-иод оноос 2000 он хүртэлх хугацааны өдөр тутмын сонины үгийн сан хэр баяжив гэдгийг судлан гаргасан байдаг. Тэрбээр энэ асуултад хариулах зорилгоор 1975 оны 12-р сарын 16-ны өдрийн “Үнэн” сонины үгийн давтамжийг тооцоолж үзээд “дан үг нь 10332, давтамж нь 2109 байгаа нь 1920-иод оноос 1970-аад он хүртэлх 50 гаруй жилийн дотор дөрвөн нүүр бүхий сонины үгийн сан 7000 гаруй үгээр нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл 1920~1975 он хүртэл 50-иад жилийн дотор сонины багтаамж нь их болж, үгийн тоо өссөн байна. Түүнчлэн 2000 оны 1-р сарын 25-ны өдрийн 016 дугаар сонины үг 10606, давтамж нь 2311 байгаа нь сонины үгийн сан улам бүр нэмэгдэж (Л.Балдан. Хэлний соёлын тулгамдсан асуудлууд, №1 Сонины хэл найруулга, Уб., 2002) байгааг харуулж байна хэмээн тэмдэглэжээ.

“Өдрийн сонин”, “Үнэн” сониныг харьцуулж үзвэл:

№		“Үнэн” сонин	“Өдрийн сонин”	Зөрүү
1	Үгийн сангийн хэмжээ	25521	35638	10117
2	Давтамж	2684	5117	2433

Үүнээс үзвэл хоёр сонины үгийн давтамж нь 30 жилийн хугацаанд 2433 үгээр нэмэгдэж үгийн хэрэглээ өссөн нь харагдаж байна. Мөн сүүлийн үед эх хэлнийхээ аюулгүй дархан байдалд санаа зовж, хамгийн их шүүмжлэн хэлэлцдэг сэдвийн нэг бол гадаад үгийн замбараагүй хэрэглээ юм. “Өдрийн сонин”-ы нийт үгийн 4,9 хувь нь гадаад үг байгаа бол “Үнэн” сонин 6,3 хувьтай байгаа нь гадаад үгийн хэрэглээ харин ч өмнөхөөсөө ихэссэн биш багассан байна. Өөрөөр хэлбэл, өнөөгийн өдөр тутмын сонины хувьд гадаад үгийн хэрэглээ тэгтлээ аюултай төвшинд очсон гэж харагдахгүй байна. Учир нь сүүлийн жилүүдэд сонины хэл найруулгад уншигч олон шүүмжлэлтэй хандах болсноос үүдэн сонины редакцын зүгээс сониныхоо хэл найруулгад тодорхой шатны хяналт хийж гадаад үгийн хэрэглээг хязгаарлах бодлого баримтлах болсон байж ч болно.

Түүнчлэн хамгийн их давтамжтай 10 үгсэд байх, болох, гарах, орох, авах, явах гэх мэт

үйл үг орж байгаа нь эдгээр үгс ямар ч цаг үед монгол хэлний идэвхтэй үг байсаар байгааг илтгэж байна. Мөн 2017 оны дугаарт “хууль (258)” гэдэг үг хамгийн их давтамжтай 10 үгэнд орсон байхад “Үнэн” сонинд ерөөсөө байсангүй. Энэ нь ардчилсан нийгмийн үндсэн зарчмуудын нэг болох хуулиа ил тод хэлэлцэх, сурталчлах, хуулиа зөв тогтоож хэрэгжүүлэх зорилготой холбоотойгоор энэ үгийн хэрэглээ, давтамж мэдэгдэхүйц өссөн байна. Мөн “Үнэн”, “Өдрийн сонин”-ны эхний 100 үгийн давтамжийг харьцуулахад аль алинд нь нэр үг давамгайлж байгаа нь тун харагдаж байна.

Судалгааны асуултууд

Бид уг судалгааны өгүүллээр дараах асуултад хариулт өгөх зорилготой байна. Үүнд:

1. Өнөө цагийн өдөр тутмын сонины нийт үгийн тоо хэд байна вэ?
2. Өдөр тутмын сонины үгийн тоо 30 жилийн өмнө хэд байсан бэ?
3. Өдөр тутмын сонины үгийн тоо хэмжээний хувьд ихэссэн үү, багассан уу?
4. Бидний өдөр тутмын хэрэглээнд, тухайлбал гадаад үгийн хувьд хэрэглээ нь ихэссэн бол бодит тоо нь хэд вэ?

Судалгааны арга

Энэхүү өгүүллэд баримт цуглуулах, тооцоолох, задлан шинжлэх, тайлбарлах зэрэг судалгааны арга хэрэглэв.

Дүгнэлт

Монгол хэлний үгийн сан түүн дотроо сонины үгийн санг судлах ажил үе үеийн монголч эрдэмтдийн хүчин чармайлтаар хийгдсээр иржээ. Үүнийг өмнө дурдсан судлаачдын судалгааны үр дүнг баталж байна. Бидний судалгаандаа эш татсан болон өөрсдийн эх хэрэглэгдэхүүн болгож авсан сонины үгийн сангийн хэмжээг харьцуулж үзвэл:

1920 оны 11 сарын 10-ны “Монголын үнэн” 2563, давтамж 637

1975 оны 12 сарын 16-ны “Үнэн” сонин 10332, давтамж 2109

1987 оны 04 сарын 28-ны “Үнэн” сонин 12626, давтамж 2684

2017 оны 04 сарын 28-ны “Өдрийн сонин” 35638, давтамж 5117

Үүнээс үзвэл сонины үгийн сангийн хэмжээ байнга өсөн нэмэгдсээр ирснийг харж болох бөгөөд бид үүнийг нийгмийн өөрчлөлт, хэрэгцээ шаардлагатай холбоотой хэмээн үзэж байна. Жишээ нь: “Өдрийн сонин”-ы бараг 4 нүүр орчим нь зар сурталчилгаанд зориулсан байх бөгөөд үүнийгээ дагаад ажил, байр, газар, худалдах гэх мэт үгийн хэрэглээ, давтамж өссөн байдал ажиглагдаж байна. 1987 оны “Үнэн” сонин нь олон жижиг мэдээ, мэдээллийг багтаасан бол өдрийн сонин нь том том ярилцлага олонтой байна.

Үгийн сангийн хувьд 1987 онд техник, район, фонд, завод, коммунист, үйлдвэр, хөдөлмөр, байгууллага, нам гэх мэт үг өргөн хэрэглэгдэж байсан бол “Өдрийн сонин” приус, гибрид, иммун актив, чингис бонд, жиргээчид, сошиал, парламент, фракц, санхүүгийн дериватив, хейджийн орлого, лебраль бодлого, таун хаус, топ, фэйсбүүк, дендорлогич гэх мэт олон шинэ үгээр үгийн сан нь баяжсан байна. Аливаа сонины үг хэллэг бол тухайн цагийн нийгмийн толь болсон үгийн сангийн хэрэглээний өнгө төрхийг илэрхийлэгч гол баримт болж өгдөг.

АШИГЛАСАН НОМ

1. **Балдан Л.** Сонины хэл найруулгын бүтэц, тогтолцооны асуудалд, Хэлний соёлын тулгамдсан асуудлууд, №1 Сонины хэл найруулга, Уб., 2002.
2. **Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь.** 2008. Уб.
3. **Монгол хэлний их тайлбар толь.** 2016. www.mongoltoli.mn
4. **Монгол хэлний найруулгын төрөл.** 1990. Уб.
5. **Ринчен, Б.** 1991. Марк Твений минь махы нь идэж дээ. Уб.
6. **Цэвэл, Я.** 1966. Монгол хэлний товч тайлбар толь. Уб.
7. **Чимэгбаатар, Ч.** 2016. Монгол хэл хэдэн үгтэй юм бол?
<https://chimed-chimegbaatar.themedia.jp/posts/1184977>
8. **Шинэбаяр, О.** 2016. “Үгийн эрдэнэсийн шинжээч”, Ш.Одонтог. Судлал ба дурсамж. III боть. Уб.

논 문 투 고 일 : 2018년 10월 30일
 논 문 심 사 일 : 2018년 11월 15일
 논문게재결정일 : 2018년 11월 30일

Монголын латин үсгийн хэрэглээ ба стандарт (Фэйсбүүкийн орчин дахь латин үсгийн хэрэглээ)

Гэрэлмаа Гөрөөчин^{*}

Abstract

The Usages and Standard of Latin Script (In the FB frame)

Gerelmaa, Guruuchin^{*}

On February 1, 1941, The Mongolian People's Republic officially used the Latin scripts, but two months later, the decision was abolished. In 2003, the "Latin Script National Program" was created and subsequently adopted a Latin-standard usage standard and was revised in 2012. We used social linguistics in Latinscript as we age 16~26, age 27~40, and 40~55. The users of latin 16~26 years with 26 to 28 percent Latin, and the use of Latin and Cyrillic alphabets is about 30 percent, with Latinos 26~40 years old with 52 percent Latin, mixing with Latin chrysanthemum 8-10 percent, The age of 55 is about 10 percent Latin, and Latin and Cyrillic are mixed with 20 percent. Facebook users use different fonts for Latin fonts differently. For example, ö- / u / o is usually in / ochig /, at the beginning of the word / enoodor /, ü- / μ / to u-aar, b, v as b, / c / to w, and / or // not only by i, yu / yu and so on.

Keywords : Latin script, FB, users, standart of latin script, apply to latin script

Удиртгал

Монголд нийгэм, эдийн засгийн өөрчлөлт гаргасан 1921 оны ардын хувьсгал хүрэхэд монголчууд уйгаржин монгол бичгээ хэрэглэж байв. Монгол бичгийг хоцрогдсон

^{*} ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн / g_mgl2003@yahoo.com
(Institute of Language and Literature Mongolian Academy of Sciences)

феодалын үеийн бичиг хэмээн үзэх үзэл, шинэ бичиг үсэгтэй болох гэсэн цаг үеийн шаардлагаар 1930-аад оноос латин үсэгт шилжих болсон. Нөгөө талаар орчин үеийн шинжлэх ухааны технологийн дэвшлийн нөлөөгөөр албан бус хэрэгцээнд латин үсгийг эргэн хэрэглэж буй үйл явц үүнийг хэрэглээний орчинд нийгэм хэл шинжлэлийн аргаар судлахыг зорив.

1. Латин үсгийг хэрэглэсэн нөхцөл байдал

Ардын хувьсгал ялсны дараагаар хуучин нийгмийн олон зүйлийг халж, шинэ нийгмийн ёс журмыг тогтоож байсан агаад үүний нөлөөнд бас үсэг бичиг ч багтсан тухай эрдэмтэн Ц.Шагдарсүрэнгийн бичсэн *“1930 оны 2-р сард болсон Намын 8-р Их хурлын заалтын 7-р хэсэгт:”...мөн хуучны хүнд суртлын үлдэгдлийн нэгэн салбар бөгөөд шинэ соёл боловсролын хөгжилтөд дөхөмгүй болох монгол үсгийг халж боловсон соёлыг дэлгэрүүлэхэд дөхөмтэйг нийт дээр дэлгэрэх туршилтыг олсон латин үсгийг өөрийн монгол хэлэн дээр зохилдуулан үндсэн хэлний үсэг болгон хэрэглэх явдлыг богино хугацааны дотор гүйцэлдүүлж нийт соёл боловсролын ба санхүүд боогдол саатал бүхий байдлыг устгахыг чухалчлах...*” (Шагдарсүрэн 2001: 181) гэсэн баримтаас харж болох юм. Энэ мэт шийдвэр тогтоолоос үндэслэн латин үсгийг авах хөдөлгөөн эрчимжиж эхэлсэн байна.

Улмаар 1931 оны 1 дүгээр сард Москва хотноо бичиг үсгийг латинчлах асуудлаар тусгай зөвлөгөөн зохион байгуулахад түүнд Буриад монгол, Халимагийн төлөөлөгчдөөс гадна БНМАУ-ын төлөөлөгчид оролцжээ. Зөвлөгөөнөөр монгол бичгийг халах тухай хэлэлцэж “Монгол бичиг бол эдүгээ нэгэн цагийн хөгжлөөс хоцрогдсон” хэмээн шүүмжлээд түүний оронд *“ард түмний сурах, танихад хялбар дөхөм бөгөөд дүрс зурам нь орчин цагийн дэлхийн олон улс аймаг нийтээр хэрэглэж буй интернационалын чанар бүхий латин үсгийг авах”* (Чулуунбаатар 2002: 200) шийдвэр гаргасан нь нийт монголчуудад монгол бичгийг халах нөхцлийг бүрдүүлсэн юм.

Бичиг үсгийн шинэчлэл хийх, бүх нийтийг бичигт сургах тэр үйлсэд их зохиолч Д.Нацагдорж оролцож, латин үсгийг монгол хэлний хууль ёсонд хэрхэн нийцүүлж авах талаар саналаа боловсруулж, “гурван бүлэг, жар орчим зүйлтэй” латин бичгийн монгол хэлний зүй зохиосон байна. Анх 1930 онд “Залуучуудын үнэн” сонинд байхдаа, латин үсгийн цагаан толгой зохиож, дараа нь Шинжлэх ухааны хүрээлэнд шилжин ирээд 1931~1936 онд түүнийгээ “Монгол хэлний ба латинчлалын дүрэм” (УТТА.Ф.23, Д.2,

ХН.50) болгон өргөтгөсөн”(Очир, Дашням 1996: 122) нь сонирхолтой.

Нацагдорж латин үсгийг авахдаа нэгдүгээрт, түүнийг өөр үсэгтэй хольж хэрэглэхийг аль болох цээрлэхийн хамт сурах, бичих, хэвлэхэд дөхөмтэй болгох, хоёрдугаарт монгол хэлний нэг авиа сонгодог бичгийн хэлний нэг үсгийг латины давхар үсэг, нэмэлт тэмдэгтэй үсгээр тэмдэглэхээс аль болох зайлсхийх, хэмнэлтийн зарчмыг баримтлах, гуравдугаарт оноож тэмдэглэх, дөрөвдүгээрт, урт эгшгийг тэмдэглэхдээ хоёр эгшгийг давхарлан бичихгүй н мэт тусгай үсгийг нэг эгшгийн дараа бичиж тэмдэглэх, тавдугаарт, монгол сонгодог бичгийн хэлэнд тусад нь бичдэг дагавруудыг урдах үгэнд нь залган бичдэг байх, зургадугаарт, монгол хэлний зөв бичих зүйн толийг зохион гаргаж, ард нийтээр дагаж мөрдөн, зөв бичих ёсыг тогтоож өгөх шаардлагатай хэмээн үзэж бай (Очир, Дашням 1996: 125)-сан нь латин үсэг зохиох зарчмыг тогтоож байсны нэгэн жишээ болно.

Энэ ажлыг нэлээд шахаж байсныг 1931 оны “Үнэн сонин”-д Албан хаагчдыг 22 дугаар оны 5 сар гэхэд латин үсэгт шилжүүлэх” тухай шийдвэр хүртэл гарч байв (Үнэн 1931: 233).

Монгол бичгийн үсгээ латин үсгээр солих комисс байгуулагдан ажиллаж 1940 оны 1 сард сүүлийн хуралдаанаараа ийнхүү латин үсгийн цагаан толгойг баталж байжээ.

Aa	Bb	Cc	Ch	Dd	Ee	Ff	Gg	Hh	Ii
Jj	Kk	Ll	Mm	Nn	Oo	Pp	Qq	Rr	
Ss	Sh	Tt	Uu	Vv	Xx	Yy	Zz	Zh	

14/1/1940

Латин үсгийг авах үйл явц өрнөж 1941 оны 2 сарын 1-нд Бүгд Найрамдах Монгол Ард Улс латин үсгийг албан ёсныхоо бичгээ болгосон боловч хоёрхон сарын дараа буюу 3 сарын 25-нд энэ шийдвэрээ буцаажээ. Албан ёсоор бол Монгол хэлний бүх дуу авиаг тэмдэглэж чадахгүй байсан тул больсон гэдэг хэдий ч дараахан нь ЗХУ-ын бүрэлдэхүүний улсуудтай бараг нэгэн зэрэг Монгол улс кирилл үсгийг албан ёсны болгосон тул энэ нь улс төрийн бодлого байсан байж болох юм. Энэ үеийг хожмын судлаачид “1930 онд монгол хэлийг латинжуулсан боловч мөн л олон нийтэд тархаж чадсангүй ганц нэг сонин, зурагт хуудасны гарчгаас хэтрээгүй” (Баабар 2001: 236) хэмээн үзсэн нь ортой юм. (Хавсралт №2 –оос үзнэ үү)

Монголч эрдэмтэн Х. Этвуд Латин үсэг, монгол бичиг хоёрыг чадах хэрээр зохицуулсан латин үсгээр монгол хэлний үгийг бичих шинэ арга зарчмыг боловсруулсан өгүүлэлдээ.

1. Латин үсгээр кирил үсгийг орлуулж хэрэглэх
2. Нэмэлт тэмдэг латин бус үсэг хэрэглэхгүй байх
3. Орчин цагийн авианы зарчмыг чадах хэрээр монгол бичгийн зарчимтай нийцүүлэх
4. Энэ латин үсэгт эгшгийг, эхэнд хэрхэн тэмдэглэх хос, уртыг хэрхэн бичихийн нарийн зааж өгөхдөө гол төлөв хоёр тэмдэгтээр “ө”-г гэхэд oi, “ү”-г ui, урт эгшгийг хоёроор aa, oo, iii, юлүүр uiuluur гэж бичиж буй бол хос гийгүүлэгчийг ш-ci, ц-c, ч-ši, з-j, ж-ji, ш-sch (2004: 324) гэх мэтээр тэмдэглэсэн байдаг нь хэрэглэхэд тийм ч хялбар биш байдалтай харагдаж байна.

Орчин үеийн техник технологийн дэвшил, интернет орчны нөлөөгөөр латин үсгийн хэрэглээ идэвхжихтэй холбогдуулан монголчууд 2003 онд латин үсгийн Үндэсний хөтөлбөрийг баталж УИХ-аас 1-р тогтоолоор баталж, “Баримт бичиг: Монгол кирилл цагаан толгойн үсгүүдийг романчлах” стандарт батлагдаж 2003 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөж эхэллээ. Уг хөтөлбөрийн зорилго нь интернетийн орчинд мэдээ мэдээлэл солилцоход саадгүй байх, кирил үсгийг янз бүрийн латин үсгээр солин хэрэглэж буйг нэг мөр болгох агаад 2003~2006 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлж, албан болон албан бус сургалтаар бүх нийтэд заан сургахаар болсон байна. Үүний үр дүнд 2003 онд Монгол кирилл цагаан толгойн үсгүүдийг романчлах стандарт (MNS 5217: 2003)-ыг бий болгон мөрдөж эхэлсэн байна.

Үүнээс хойш 2012 онд уг стандартыг Стандартчиллын Үндэсний Зөвлөлийн хурлаар Монгол кирил үсгийн латин хөрвүүлэг MNS 5217: 2012 стандарт болгон шинэчлэн батласан.

Энэ стандартын төслийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны саналыг үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухааны Шинжлэх ухаан, технологийн газрын дарга

Ө.Сүхбаатар, Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал академич, (Sc.Dr) Д.Төмөртоогоо, Төрийн хэлний зөвлөлийн ажлын албаны дарга Б.Магсаржав, Монгол улсын боловсролын их сургуулийн Монгол судлалын сургуулийн захирал, профессор Ц.Өнөрбаян, Монгол улсын их сургуулийн Монгол хэл, соёлын сургуулийн багш, профессор Ж.Бат-Ирээдүй, Стандартчилал хэмжил зүйн газрын Стандартчилал, техникийн зохицуулалтын хэлтсийн дарга Б.Гэрэл, Монгол улсын их сургуулийн Компьютер менежментийн сургуулийн багш Д.Бямбажав, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Мэдээлэл, холбоо, технологийн сургуулийн багш, профессор Б.Сүхбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын газрын мэргэжилтэн Т.Чимэдлхам, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн газрын ахлах мэргэжилтэн М.Дэлэгмаа, Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ш.Оюунцэцэг нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгээс боловсруулсан байна.

Энэхүү стандарт нь кирил үсгийг латинаар хөрвүүлэх зорилготой агаад үүний тулд латин үсгээр зөв бичүүлж хэвшүүлэх зорилготой юм.

2. Латин үсгийн Фэйсбүүк орчны хэрэглээ, стандартын харьцаа

Мэдээллийн цахим эх сурвалжийн нэг болсон Фэйсбүүкийн орчныг ажиглахад латин болон кирил бичгийг хольж хэрэглэх, аль нэгийг хэрэглэх, товчлох, буруу бичих гэх зэрэг бичиг үсгийн хэрэглээний орчинд судалмаар зүйл цөөнгүй байгааг ажиглаад энэ талаар нийгэм хэл шинжлэлийн бичил судалгааг хийсэн юм. Техник технологийн шаардлага хэрэгцээнд хэлийг тохируулан хэрэглэх нь хэрэглээний хэл шинжлэлийн нэг судлагдахуун байдаг.

Нийгэм хэл шинжлэлийн судалгааг хийхийн тулд Фэйсбүүк хэрэглэгчдийн насыг 1-26, 27-40, 41-55 нас хэмээн 3 бүлэгт хуваан үзэж судалгаа хийв.

16-26 насны латин үсгээр бичдэг Фэйсбүүк хэрэглэгч 30 хүнээс асуулгын аргаар судалгаа авахад:

Амархан-23 (69%) хүн хариулснаас Яагаад амархан бэ гэхэд

- Цөөн үсэгтэй- 7 - 16,1%
- Бичихэд хурдан-4- 9.2%
- Үсгийн дүрэм шаардахгүй-3 6.9%

Латин үсэг хэрэглэдэг шалтгаан нь

- Цаг хэмнэдэг-0

- Товчилоход амар-0
- Мэргэжилдээ хэрэглэдэг-0
- Утасны товчлуур латин үсгээрх -3 **6.9%**

27-40 насны латин үсгээр бичдэг Фэйсбүүк хэрэглэгч 29 +1 (Фэйсбүүк гэж мэдэхгүй) хүнээс асуулгын аргаар судалгаа авахад:

Амархан-15 (**43.5%**) хүн хариулснаас Яагаад амархан бэ?

- Цөөн үсэгтэй-4 (**11.6%**)
- Бичихэд хурдан-5 (**7.5%**)
- Үсгийн дүрэм шаардахгүй-6 (**9%**)
- Латин үсэг хэрэглэдэг шалтгаан нь
- Мэргэжилдээ хэрэглэдэг, ажлын шаардлага-4 (**6%**)
- Утасны товчлуур латин үсгээрх-3 (**4.5%**)
- Компьютер дээр монголоор бичдэггүй-2 (**3%**)
- Байнга гар утас, компьютерт-2 (**3%**)
- Латинаар бичээд сурчихсан-1 (**1.5%**)

41-55 насны латин үсгээр бичдэг Фэйсбүүк хэрэглэгч 15 хүнээс асуулгын аргаар судалгаа авахад:

Амархан-10 хүн хариулснаас Яагаад амархан бэ гэхэд

- Бичихэд хурдан-3 (**45%**)
- Үсгийн дүрэм шаардахгүй-3 (**45%**)
- Латин үсэг хэрэглэдэг шалтгаан нь
- Цаг хэмнэдэг
- Товчилоход амар
- Мэргэжилдээ хэрэглэдэг
- Утасны товчлуур латин үсгээрх-3 (**45%**)

Бусад ямар шалтгаанаар латин үсэг хэрэглэдэг вэ?

- Мессэж бичдэг
- Майл бичдэг
- Өөр зүйлд хэрэглэдэггүй

Нийт хэрэглэгчдийн латин үсэг хэрэглэж буй шалтгааныг тооцоолон үзвэл бичихэд хурдан байдаг хэмээн үзсэн нь **61,7%** тай байгаа бол үүний цаана компьютер болон гар

утасны хэл латин үсгээр байгаагаас шалтгаалан бичдэг **56,4%** байхад бичихэд зөв бичих дүрэм шаардахгүй гэсэн хариулт нь **60,9 %** -тай байна.

Нийт судалгаанд хамрагдсан 74 хүнээс авсан

Латин үсгийн стандартыг баримталдаг уу?

- Мэдэхгүй **85%**

- Мэднэ **15%**

Хэрэглэдэг **10%**

Хэрэглэдэггүй **5%** хэмээн хариулснаас үзвэл латин үсгийг өөрсдийн дураар хэрэглэж буй нь харагдаж байна.

Латин үсгийн хэрэглээ, стандарттай хэрхэн харьцаж буй байдлыг ялгаатай бичиж буй үсгүүдээр харьцуулан үзвэл:

В-г V, W	гэсэн хоёр хэлбэрээр (avarga, awarga)	
Ө-г U, О	гэсэн хоёр хэлбэрээр (undur, ondor)	Ö ö
Е-г Е	үсгээр гадаад хэлбэрээр нь дуурайлгах (ueiin)	Ye ye
Х-г Н, Х, Kh	-ээр хольж бичдэг (baixavdee, hunii)	Kh
П-г Р, R-ээр	хольж бичдэг	
Ү-г V, U	гэсэн хоёр хэлбэрээр (huuhed, shuu)	Ü ü

Хос эгшгийг ое, оу, оі гэх мэтээр тус тус (Жишээг Хавсралт №3 –аас үзнэ үү) латин үсгийг хэрэглэж байна.

Үр дүн: Фэйсбүүкийн орчны 16~26 насны хэрэглэгчийн 26~28% нь латин үсгийг дагнаж хэрэглэдэг бол 30% нь латин болон кирилл үсгийг хольж хэрэглэсэн бол 26~40 насныханы 52% нь латин үсгээр бичиж, 8~10% нь латин болон кирилл үсгийг хольж хэрэглэдэг, 55-аас дээш насны хэрэглэгчдийн 10% нь латин үсгээр, 20% нь латин болон кирилл үсгийг хольж хэрэглэж байна. Мөн түүнчлэн Фэйсбүүкийн орчинд өөрийн овог болон нэрээ латин үсгээр бичих нь түгээмэл байна.

Дүгнэлт:

- Латин үсгийг хэрэглэх үндсэн шатгаан нь компьютер болон гар утасны гараас хамааралтай.
- Латин үсгийн стандартын зарим үсэг хэрэглэхэд хялбар биш байгаа тул хэрэглэгдэггүй тул цаашид засаж боловсруулах.

- Стандарт шаардахгүйгээр бичих үндэс нь англи бичгийн хэлний нөлөөлөл байна.
- Сүлжээ болон гар утсанд буруу бичихэд зөв болгодог программыг монгол хэлээр латин үсгээр бий болгох шаардалгатай. Мөн тогтсон загвараар энэ орчинд үг товчилдог болох нь зүйтэй байна

Ашигласан бүтээл



- Баабар** Монгол бичигт латин галиг ингэж хэрэглээ. “Өдрийн сонин” 2001, №236 (797), х.7.
- Бондалетов.В.Д.**, Социальная лингвистика.М., 1987, -160с.
- Догсүрэн.Ч.**, Монгол газар усны нэр тэмдэглэх болзмол латин цагаан толгой. – “Э.Пүрэвжав. Монгол хэл бичгийн судлал. IX, Уб., 2006, х.82-90”.
- Латинчлах тухай.** Үнэн сонин.1931 оны 10 сарын. 4. №233(433).
- Монголчуудын түүх, соёлын атлас.** Латин үсэг. Уб., 2004, х.339.
- МУ.УТА, КГЗДАБА** Сургууль боловсролын багц. К-7247.
- МУУТА, УТНОНББА,** Х4, Д9, ХН10, х.19.
- Одонтог.Ш.**, Монгол латин үсгийн хөгжлийн нэгэн түлхүүр.Уб., 2016, -“Монгол судлал: 1990-ээд оны шинэ хандлага” х.124-127.
- Одонтог. Ш.**, Латин үсэг хөгжилд хөтөлнө. Уб., 2016, -“Монгол судлал: 1990-ээд оны шинэ хандлага” х.141-144.
- Очир.А., Дашням.Г.**, Д.Нацагдорж: нийгэм, улс төр, эрдэм судлалын үйлс, амьдрал. Уб., 1996, 190х. Х.121.
- Пүрэвжав. Э.**, Монгол латин үсгийн хэрэглээ. –Монгол судлалын өгүүллийн түүвэр”. Уб., 2006, х.62-63.
- Чулуунбаатар.Л.**, Нүүдэлчин монголчуудын бичиг үсгийн соёл. Уб., 2002,-МУИС-ын хэвлэх үйлдвэр. 251х.
- Шагдарсүрэн.Ц.**, Монголчуудын үсэг бичигийн товчоон. Уб., 2001., -Урлах эрдэм хэвлэл. 300х.
- Этвуд.Х.**, Орчин цагийн монгол хэлэнд хэрэглэж болох монгол бичгийн зарчмыг өвлөх латин үсгийн шинэ тогтолцоо. –“Mongolica”. vol.14, Уб., 2004, х.321-337.

ХАВСРАЛТ №1**(Монгол улсад хэрэглэсэн латин үсгийн цагаан толгойн харьцуулсан хүснэгт)**

Цагаан Толгой	1940 оны латин үсэг	Ч.Догсүрэн. Монгол газар усны нэр тэмдэглэх болзмол латин цагаан толгой. 1979	Баабар 2001 он	Монгол хэлний кирил цагаан толгойн үндсэн үсгийг романчлах стандарт. 2003	Монгол кирил үсгийн латин хөрвүүлэг стандарт. 2012
А а	A	A	A	A a	A a
Б б	B	B	B	B b	Bb
В в	W	V	W	V v	V v
Г г	G	G	G	Gg	Gg
Д д	D	D	D	D d	D d
Е е	Ye	Ye	Ye	Ye	Ye ye
Ё ё	Yo	Yo	Yo	Yo	Yo yo
Ж ж	J	J	J	J j	J j
З з	Z	Ž	Z	Z z	Z z
И и	I	I	I	I i	I i
Й й	I	J	I	I i	I i
К к	K	K	K	K k	K k
Л л	L	L	L	L l	L l
М м	M	M	M	M m	M m
Н н	N	N	N	N n	N n
О о	O	O	O	O o	O o
Ө ө	Ө ө	Ö	Q	O' (o)	Ö ö
П п	P	P	P	P p	P p
Р р	R	R	R	R r	R r
С с	S	S	S	S s	S s
Т т	T	T	T	T t	T t
У у	U	U	U	U u	U u
Ү ү	Ü	Ü	V	U' (u)	Ü ü
Ф ф	F	F	F	F f	F f
Х х	X	X	X	X x (Kh kh)	Kh kh
Ц ц		C	Cs	C c	Ts ts
Ч ч	Ç	Č	Ch	Ch ch	Ch ch
Ш ш	Ş	Š	Sh	Sh sh	Sh sh
Щ щ		Šč	Shch	Shc shc	Sh sh
Ъ		‘	-	- tomyoo (томьёо)	I
Ы		Y	Yi	Y y	Y
Ь		‘	-	I	I
Э э	E	E	E	E	E e
Ю ю	Yu	Yu	Yu	Yu	Yu yu
Я я	Ya	Ya	Ya	Ya	Ya ya

ХАВСРАЛТ №2

(Латин үсгээр хэвлэж байсан ном болон сонины толгой)



ХАВСРАЛТ №3

Насны ангилал	Латин үсэг	Кирил үсэг	Латин, кирил хольж хэрэглэсэн
16-26 насны хэрэглэгч	hicheeld ywmaargv bna shd Gehde hun chuhai hunda zav garagadg Odoonoos l hicheehgvin bol Daraan gej baihgvi. o Ataархаад bgmu xaashiin хха 	Энэ хөзөрнөөс болж нэг юм болноо ххэ тоглохоо л болихоос, о, кармай хоосон ч надад эрх чөлөө байна. Хамгийн гол нь би залуу байна. Үнсэхэд үрдэг байсан тэр ширүүн сахал нь үүрдийн гэмээр гижигддэг байсан.. Аав 	Love is a verb, not a noun гэдэг үг байдаг даа. Шууд утгаар нь орчуулбал хайр бол хайрлахыг хэлдэг үйл үг болохоос нэрлээд өнгөрдөг нэр үг бишээ гэж. Justin ingej miarad bhad jigee chi bol araggui ym bnoo хамтдаа үнэхээр их дурсамж бүтээсэн нэгэн миний хувьд хамгийн best найз маань ямарч үед хамт байж найз байдагт баярлалаа амжилт хооё love шүү ххэ          Б' Мөнхжин ын хэлсэнээр: Авсан дуучин: Michael Buble Таалагддаг у?: Ayguu ih taalagddag
27-40 нас	tstesteg shug hoorkhon Tsetsgee duudee Bagaa ni khairei shuu torson odroo saikhan temdegleerei eruul enkhiiг husye Sar shiniin mend hurgie Sonshoor zvrh shimshreed bdiin bvr neg setgeleesee duulj bgama neg taaraldval tevreed vnseh yumsaan hair hvrem yumaa	Гэхдээ удахгүй манай залуучууд, бизнесмэнүүд, ерөөс хэн хүнгүй том гоё машинд суух нь тийм ч чухал биш гэдгийг ойлгож, энгийн зүйлсийг хэрэглээ болгож эхлэх байх. Аливаа зүйлийн тэнцвэрийг олж, тунг нь олсон зүйлд бүх сэтгэлээ зориулдаг.	Some people learn to earn well, but they haven't learned to live well. Зарим хүмүүс орлого олохдоо маш сайн, гэхдээ сайхан амьдрахдаа маш муу байдаг. Stop calling it a dream. Start calling it your plan. Мөрөөдөл гэж нэрлэхээ болиод төлөвлөгөө гэж ярьж эхлэх ёстой. #ОнчМэргэнҮгс I hear and I forget. I see and I remember. I do and I understand. - Confucius Сонсоод мартана. Үзээд санана. Хийгээд ойлгоно. - Күнз #Би_байгальд_хог_хаяхгүй_энэ_Challenge-d Oyuka Oyukaa -н хүслтээр нэгдлээ.

но н 문 투 고 일 : 2018년 10월 30일
 논 문 심 사 일 : 2018년 11월 15일
 논문게재결정일 : 2018년 11월 30일

СТАНДАРТЫН НЭР ТОМЬЁО, ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛД

O.Shinebayar*

Abstract

Terms for Standards and Their Use

O.Shinebayar*

In this article author analyzed terms in 6213 standards by the Mongolian agency for Standardization and Metrology government regulatory agencies. This organization was named as Bureau of Weights and Measures the Government regulatory agency for Standardization and Metrology in 1923.

He mainly focuses on standards of the term translation, definitions and their styles. Every word and term in standards is important for formalating terms, according to international standard and implementing in domestic fields. Studying terms and professional words are beneficial for creating next qualified standard terms and significant for social language use. Furthermore, well-formulated terms, professional words can be motivation to translate and localize new international standards of and to broaden national standards as well.

Moreover, it includes issues such as international law, rule related to standards and obey and implement those legal document. Present article include and analysis of foreign, nature, archaic, new word, basic meaning transferred meaning words by classifying in to 3 domain fields natural, technique technological, social fields. There have been no research on terms and in expressions in national standards so far. Thus the present study significant in terminology studies.

Keywords : standard, term, **Terminology** Creating terms, Harmonizing terms, Habituating terms

* Institute of Language and Literature of the Academy of Sciences of Mongolia / och.shinee@yahoo.com

Стандартын тухайд

Ард олны амьдрал, улс орны түүхэнд урьд өмнө байгаагүй юм уу, тодорхой илрээгүй байсан олон юм үзэгдэл тэдгээрийн талаарх ухагдахуун, ойлголтыг нэрлэх шаардлага нь шинэ үг хэллэг, нэр томъёог бий болгож байдаг бөгөөд үг хэллэг нэр томъёогоор баяжих бүр эрэмбэлэн цэгцлэх асуудал зүй ёсоор тавигддаг байна.

Ийм учраас хэлний зохистой хэрэглээнд үндэслэн хэлний хэм хэмжээ, нэр томъёоны стандартыг тогтоодог. Стандарт /Standart/ гэсэн энэ үг нь 1. Жишиг, төвшин 2. Хэм хэмжээ норм 3. Шалгуур үзүүлэлт гэсэн утгатай талаар олон хэлний толь бичсэн байдаг. Гэхдээ “Norm”, “Standart” гэсэн энэ хоёр үг үгчилбэл хэм хэмжээ гэсэн утгаар орох тал байвч монгол хэлний хэрэглээний үүргийн хувьд ялгаатай хэрэглэж байгаа нь “Norm”-хэлний хэм хэмжээ, “Standart”-жишиг буюу стандарт гэдгээр оноосон нь харагддаг. Орос хэлнээ “Стандартзация- 1. Ямар нэгэн зүйлийн зайлшгүй байх нэгдмэл загвар 2. Хувийн онцлог шинжгүй нэгдмэл загвар” Стандарт-чанар болон хэлбэр хэмжээгээрээ хангах ёстой хэв шинжийн загвар /Академия наук СССР институт русского языка. Словарь русского языка. II. 1983.247/

Стандарт бол хатуу тогтсон зайлшгүй мөрдөх хэм хэмжээ.¹⁾

Энэ нь аливаа ажил үйлийн үр дүн, бүтээгдэхүүний хэм хэмжээг хуульчлан баталсан байдгаараа хэн нэгэн хувь хүний хийж бүтээсэн зүйлийн дурын үр дүнгээс ялгаатай. Бараа бүтээгдэхүүний стандартаас гадна бичиг үсгийн хувьд ч нийтээр даган мөрддөг стандарт бий. Жишээ нь: Латин үсгийн стандартыг үүнд нэрлэж болно.

Ер нь *бидний амьдралд стандарт аль хэдийнээ орж салжгүй нэгэн хэсэг болсныг дараах жишээ харуулна. Үүнд:*

- *Бидний өдөр тутамдаа хэрэглэдэг асаах, унтраах зориулалт бүхий “унтраалга” нь дэлхий дахинд үйлдлээ илэрхийлсэн нэг л нэр үгээр нэрлэгдэх төдийгүй*

1) А.Эрдэнэцэцэг. Бидний сонголт – аюулгүй байдал. 2011. 2 Бид юмсын “стандартыг бүтээх” эринээс “юмсыг хийх стандартын” эрин рүү улам их ойртож байна. Стандарт бол хүн төрөлхтний үйлдвэржилтийн гурван том хувьсгалын нэг юм. Бараа бүтээгдэхүүнийг бөөнөөр үйлдвэрлэх боломж олгосон анхны алхам нь стандартжуулах явдал байсан бол түүний дараа механикжуулах систем үйлдвэрлэлд нэвтэрсэн байна. Харин 1900-аад оны үед Хенри Фордын нэвтрүүлсэн угсрах шугам гэж нэрлэгддэг орчин үеийн автомат үйлдвэрлэлийн суурь болох хөдөлмөрийн хуваарийн зарчим нь гутгаар том ололт нь болжээ. Өнөөдөр дэлхийд стандарт хэрэглэдэггүй, стандартын байгууллагагүй зах зээлийн харилцаагаар хөгжиж байгаа улс орон гэж нэг ч үгүй билээ. Зах зээлийн харилцааны нөхцөлд хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагыг хангахгүйгээр өөрөөр хэлбэл, стандарт хэрэглэхгүйгээр ямар ч үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэх боломжгүй.

хэрэглээний үзүүлэлт нь ч нэг зарчмаар явдаг билээ.

- *улаан гэрэл ямар ч үед анхааруулах тэмдэг байх буюу замын хөдөлгөөнд зогсох тэмдэг болдог. Тэгвэл ногоон гэрэл нь нээлттэй буюу хөдөлгөөнөө үргэлжлүүлэхэд аюулгүй байдлыг илэрхийлдэг.*
- *Энд та бидний хэрэглэдэг эмээлийг нэрлэж болно. Эмээл нь үеийн үед хэлбэр хийцээ хадгалж ирсэн-стандарт бүтээгдэхүүн юм. Тухайлбал археологийн малталтаар Эртний Хүннү нарын хэрэглэж байсан эмээл олджээ. Уг эмээлийн ерөнхий хэмжээ, хэсгүүдийн харьцаа, хэлбэрийн хувьд харьцангуй том боловч өнөөгийн хэрэглэж буй эмээлээс онцгой ялгарах зүйлгүй. Эмээлийн хэмжээ том, дизайн, ур хийц, эд ангиуд зөв харьцаатай маш оновчтой байгаа нь хэрэглээний явцад стандарт бий болдгийг харуулж байна. Стандартгүй дэлхий ертөнцийг төсөөлсүгй. Орчин үед дэлхийн маш олон хүчин зүйлүүд стандартаас хамаарч байна. [А.Эрдэнэцэцэг./2011.5]*

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль” / 2017/ –ийн 4.1.2 –т зааснаар стандарт” гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг ойлгоно” гэж тодорхойлжээ.

Одоо Монгол улсад 6010 гаруй стандарт байна. Стандарт нь шинжлэх ухаан, технологи, практик туршлагын нэгдмэл үр дүнд үндэслэсэн бөгөөд нийгэмд зохимжтой ашиг тус өгөхөд чиглэсэн байвал зохино. Стандартыг дотор нь Монгол Улсын / “үндэсний”/ стандарт, байгууллагын стандарт, олон улсын болон бүс нутгийн стандарт, удирдамж, зөвлөмж, түүнд нийцүүлэн гаргасан гадаад улсын стандарт гэж ангилдаг. ISO, IEC, EN зэрэг олон улс, европын стандартуудыг нутагшуулан үндэсний стандартаар баталдаг. Өнөөдөр нийт үндэсний стандарт дотор олон улсын стандартын тоо 32.1 хувийг эзэлж 1932 стандартын нэгж байна.

“Монгол улсын стандарт” гэсэн үгийн товчилсон үсгийг латинаар “MNS” гэж тэмдэглэдэг бол “Олон улсын стандарт” гэсэн үгийн товчилсон үсгийг латинаар “ISO” гэж тэмдэглэдэг. ISO буюу Олон улсын Стандартчиллын байгууллага нь дэлхийн 160 гаруй орны гишүүнчлэлээс бүрдсэн, стандарт боловсруулагч, түгээгч дэлхийн хамгийн том байгууллага. ОУСБ нь оролцогч талуудын (НҮБ түүний дэд байгууллага, WHO, WTO, IEC гэх мэт) хүсэлт хэрэгцээнд үндэслэн дэлхийн хөгжилд чухал шаардлагатай байгаа стандартуудыг боловсруулан гаргадаг.

Тус байгууллага нь 1947 онд Швейцарь улсад байгуулагдсан байдаг. Жишээ болговол: ISO 9001 стандарт нь дэлхий нийтэд хамгийн өргөн хэрэглэгддэг бөгөөд бүтээгдэхүүн,

ажил үйлчилгээний чанарыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлж, сайжруулан удирдах удирдлагын арга зүй бөгөөд чанарын байнгын сайжруулалтын үйл явцын хөдөлгөх түлхүүр болдог.

Энэхүү стандартын шаардлага нь нийтлэг шинжтэй бөгөөд гаргах бүтээгдэхүүнээс мөн байгууллагын хэмжээ, төрөл, салбараас үл хамааран ямар ч аж ахуйн нэгж, байгууллагад авч хэрэгжүүлж болдог. Стандартууд бол үйл ажиллагааны бүтээмж болон үр дүнг сайжруулах батлагдсан ба шалгарсан арга юм.



Нэр томъёоны стандарт

Хэлний хэрэглээтэй холбоотой толь бичиг, судалгааны бүтээлд стандарт хэл /standard language/ гэсэн нэр томъёо тохиолддог. Тухайн улсын олон үндэстэн, ястнуудын голлон ярих тэр л хэл аялгууг стандарт хэл гэдгээр / Standard English, Standard Chinese Standard Arabic/ гэх мэтээр тодорхойлж ерөнхийлөн бичсэн нь хэлний өөрийнх нь зүй тогтлыг стандартжуулахаас ялгаатай зүйл юм.

Хэлний хувьд хэм хэмжээ гэдэг нэр томъёог түгээмэл хэрэглэх нь зохистой. Хэрвээ хэлний стандарт гэдгийг хэрэглэе гэвэл хэлний зөв бичих дүрэм, хэлзүйн дүрэм, албан бичгийн стандарт, латин үсгийн стандарт, нэр томъёоны стандарт гэх зэрэг ойлголтын



хүрээнд авч үзэх болно. Харин нэр томьёо судлалд хэм хэмжээ гэхээсээ нэр томьёоны шаардлага, зарчим, нэр томьёоны стандарт гэж түгээмэл хэрэглэх нь зохистой. Нэр томьёо нь хэлний бааз суурь дээр хөгжиж өөрийн жишиг буюу стандарттай онцлог салбар. Нэр томьёоны стандарт бол хэм хэмжээтэй харьцуулахад тогтсон мэт атлаа хөдөлшгүй тогтолцоо бас биш юм. Хэлний хэм хэмжээний адил нийгэм, цаг үеийн аясаар алгуур өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг үзэгдэл юм.

Оросын хэл шинжлэлч Г.Рондо нэр томьёонд мөрдөх 10 шаардлагыг гаргаж түүндээ “стандарт бол үндсэн шаардлага, эцсийн зорилго, мэдээллийн харилцааг хамгийн оновчтойгоор оноон тогтоож хөнгөвчлөх гэх мэт нь ч зорилго болно” гэжээ. [12.196-197] Тэрээр нэр томьёо нь орчин үеийнхээ түвшинтэй зохицож, их нарийн боловсруулагдан хөгжиж байх ёстой. Нэр томьёо амжилттай, үр дүнтэй байхын тулд нөлөө бүхий байгууллагаас хийсэн байх, жигдрүүлэх, хэвшүүлэх үйл ажиллагаанд албадлагын маягтай хүчин зүйлүүдийг ашиглах ёстой гэжээ. [А.В.Суперанская. 197] Эндээс харвал нэр томьёог нэгдсэн нэгэн бодлогоор жигдлэн хэвшүүлэх буюу “албадах” бас нэгэн шаардлага гарч байна. Учир нь аливаа нэгэн үзэгдэл, юмсыг олон талаас нэрлэх бололцоо байдаг шиг нэр томьёог олон янзаар хүн хүн өөр өөрөөр хэрэглэх нь нэр томьёог тогтолцоот талаас нь стандартчилах үүргийн мөн чанарыг алдуулж байна.

Доктор Ц. Өнөрбаян “Шинжлэх ухаан, техник технологийн хөгжил дэвшил улам бүр эрч хүчтэй болохыг дагалдан тодорхой шинжлэх ухааны нэр томьёог зөв оновчтой тогтоох, стандартчилах, загварчлах асуудал чухал болж байна. Нэр томьёог зөв оновчтой тогтоох, стандартчилах, загварчлах гэдэг нь шинжлэх ухааны салбаруудын ижил төрлийн ойлголтыг адил загварт бүтцээр болон хэмнэлттэй товч тэмдэглэх, өөрөөр хэлбэл нэр томьёог интеграцчилах ойлгож болно. Энэ нь шинжлэх ухааны мэдээллийг боловсруулах, жишиг хэмжүүртэй болгоход практик ач холбогдолтой юм. ... Өнөөдөр манай улсад шинжлэх ухааны ихэнх салбар нэр томьёоны баялаг сантай болсон боловч нэг ухагдахууныг өөр өөр үгээр тэмдэглэх, өөр өөр ухагдахууныг нэг үгээр илэрхийлэх, оновчтой нэг үгээр тэмдэглэх ухагдахууныг олон үгтэй тайлбар нэрээр оноох зэрэг

дутагдал түгээмэл байгаа юм. Иймээс шинжлэх ухааны нэр томьёог тухайн нэг салбар ухааны хүрээнд төдийгүй хэд хэдэн салбарын төвшинд стандартчилан цэгцлэх шаардлагатай болж байна. /Нэр томьёо судлал.2005.№7. 86/” гэж тэмдэглэжээ.

Дээр дурдсан Монгол улсын 6010 гаруй стандартын нэр, тодорхойлолт нь бүгд мөрдөн дагаж хэрэглэх нэр томьёо, түүний тайлбар болно. Өөрөөр хэлбэл “01 дугаарын стандарт буюу Нийтлэг зүйл, нэр томьёо, стандартчилал, баримт бичиг” гэсэн стандартын агуулгын хүрээн дэх стандартын нэр томьёоноос гадна бүх стандартын нэр дагаж мөрдвөл зохих нэр томьёо билээ. Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний стандартчиллын тогтолцоо” Mongolian State national standardization system. Part 2: Rules for the structure and drafting of standards / MNS 1-2 : 2006/ -нд стандартын нэр томьёоны хамрах хүрээ, нэр томьёоны оноолт, тодорхойлолт, олон улсын стандартыг орчуулахад хэрэглэх зарчмыг бичсэн байна. Энэ стандарт нь стандартын болон техникийн зохицуулалтын төсөл боловсруулах, олон улсын ба бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартыг үндэсний болгон хэрэглэх, улсын стандартад үзлэг хийх, өөрчлөлт оруулах, хянахтай холбогдсон боловсруулалт, бичлэгийн талаар нэгдмэл арга зүйг тогтооно. Тус стандарт нь үндэсний болон байгууллагын стандартад аль алинд нь хамаардаг байна.

Энэхүү стандартад **стандарт гэж** бүтээгдэхүүний үзүүлэлт, шаардлагын хэм хэмжээг зохих журмын дагуу сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж, эрх бүхий байгууллагаас баталсан норматив- техникийн баримт бичиг. Стандарт нь шинжлэх ухаан, технологийн ололт, туршлагын нэгдмэл үр дүнд үндэслэсэн, нийгэмд зохистой ашиг тус өгөхөд чиглэсэн байна. [“Стандартчилал тохирлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, 2003 он, 3 дугаар зүйл, 3.1.2] гэсэн байна. Харин “**Олон улсын стандарт**”-ыг тодорхойлохдоо “олон улсын стандартчилагч/ стандартын байгууллагаас сайшаан батлаж, өргөн олон нийтэд хүртээлтэй болгосон стандарт”[MNS ISO/IEC GUIDE 2:2005, тодорхойлолт 3.2.1.1] гэжээ.

Стандарт дахь нэр томьёоны оноолт:

Стандартын нэр томьёонууд нь үгийн сангийн бүрэлдэхүүний хувьд авч үзэхэд

1. Үндэсний сэтгэлгээтэй холбоотой үг хэллэгийг сонгож хэрэглэсэн.
2. Хуулбар орчуулгын үг
3. Дүйлгэн орчуулсан үг

4. Гадаад үг гэсэн онцлогтой байна.

Үндэсний сэтгэлгээтэй холбоотой үг хэллэгийг сонгож хэрэглэсэн

Монгол түмний зан заншил, шашин шүтлэг, эрхлэх ахуй, орчин нөхцөлтэй холбоотойгоор үүссэн уламжлалт үг хэллэг хэлний хэрэглээнд хэвшин тогтож баяжин хөгжиж иржээ. Энэхүү онцлогийг нэр томьёонд тусгаж хэрэглэж байна.

Тухайлбал: Ахрын ноос-шерсть осенней стрижки- “Бүдүүн бүдүүвтэр ноост хониноос намрын улиралд дэлгэмэл бус байдлаар хярган авсан дэлгээс биш байдалтай ноос” гэж бичжээ. Монгол хэлний цахим тайлбар тольд : Намар хяргасан хонь, малын охор, богино үс” гэж тайлбарласан байдаг. Дээрх хоёр тайлбараас монгол хэлний цахим толь дахь тайлбар нь илүү ойлгомжтой бөгөөд стандартад энэхүү толиос тусгаж байвал үр дүнтэй юм.

Мөн үндэсний уламжлалт үгтэй холбоотойгоор олон нэр томьёо стандартад бий бөгөөд үүнээс цөөнийг төлөөлөн бичлээ. Жишээ нь: Ноосны зунгаг-жиропот шерсти - Малы арьсан дахь хөлсний булчирхайгаас ялгарсан хөлстэй холилдон ноосонд үлдсэн ноосны тоо / **MNS 3362 : 1982/**

Зуд- дзуд/экстремальная зимняя ситуация dzud/extreme winter conditions/ “Өвөл, хаврын улиралд цаг агаар хүндэрснээс мал сүрэг бэлчээр, усаар нэн гачигдаж, турж зутран олноор хорогдох нөхцөл бүрдэхийг хэлнэ”

Галт тэрэг Поезд Train Төмөр замын тээврийн үйл ажиллагааг гүйцэтгэхээр нэг бүлэг болгон найруулж холбосон ажиллагаатай зүтгүүр болон сүүлийн дсхитлй хөдлөх бүрэлдэхүүнүүд, тэдгээрт ажиллах төмөр замын мэргэжлийн ажилчид гэх мэт.

Хуулбар орчуулгын үг:

Олон улсын стандартын нэр томьёог шууд хуулбарлан орчуулсан нэр томьёо.

Жишээ нь:

Саарал ус – “ямар нэгэн ялгадасгүй зөвхөн ахуйн бохир ус” / **grey water** - domestic wastewater without any excreta/

Бор ус -усаар шингэлэн зайлуулсан (шээсний хольцгүй) өтгөн ялгадас / **Brown water** - mixture of faeces and flushing water but with no urine/

Хамарлах- Гребование /Талбайн гадаргууд хамар үүсгэн боловсруулах/

Дүйлгэн орчуулсан үг

Олон улсын стандарт дахь үг хэллэгийг монгол хэлний уугуул үгээр дүйлгэн харьцуулан оноосныг хэлнэ. Жишээ нь:

Автомашины жолооч - Автомашин жолоодож байгаа, зохих тохиолдолд тээвэрлэгчийн төлөөлөгч болох хувь хүн Driver of the automobile, Водитель автомобиля. Жолоо гэх үг нь морины жолоо, жолоо, цулбуур, удирдан жолоодох гэсэн утга бүхий үгээс машин техник ажиллуулах үүрэгтэй хүний нэрд шилжжээ. Үүнчлэн

Тэвш - кузов /Зорчигч, ачаа тээвэрлэхэд зориулагдсан тээврийн хэрэгслийн их биеийн хэсэг /

Тээш - Luggage -Багаж /Зорчигчийн автомашины тээшний хонгилд тээвэрлэхэд өөрийн шинж чанар, жин, хэмжээний хувьд хориглоогүй, зорчигчтой адил хугацаанд тээвэрлэхээр тээвэрлэгч хүлээн авсан зорчигчийн эд зүйл, бусад эд хөрөнгө/ гэх мэт монгол хэлний үгийн сангийн үг хэллэгтэй дүйцүүлэн оноосон байдаг.

“The Mongolian Mining Journal” гэсэн уул уурхайн сэтгүүлд “Монгол улс эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л салбартаа Евро стандартыг нутагшуулна гэж ярих болсон” гэж бичсэн байна. Үүнчлэн энэ “стандарт нутагшуулах” гэсэн үгийг ярианы хэлнээ их хэрэглэдэг. Англи хэлний “harmonization” гэсэн үгийг дүйлгэн орчуулсан үг юм.

Стандартын дүрэмд “Нэр үг хэл зүйн дүрмийн суурь хэлбэрээр, өөрөөр хэлбэл нэр үгийг ганц тоогоор, үйл үгийг үйл үгийн тодорхой бус төлөвөөр тус тус илэрхийлнэ” гэсэн нь аливаа зүйлийн нэрлэлтийг ганц тоот жинхэнэ нэрээр, хөдөлгөөн заасан үгийг үйл үгийн өөрөө үйлдэх хэв, энгийн үйлдэх байдлын нөхцөлтэй үйл үгээр тус тус хэлбэржүүлэн илэрхийлсэн байна. Гэтэл Нүүрс бүтэхүй - Мөхсөн ургамлын нүүрс болох дэс дараалалтай хувиралт, Ялзмагжих Нүүрс үүсэх үе шатны явцад үүссэн хүлэр гэх мэтчилэн үйл үгийн тодотгон холбох нөхцөлөөр хувилгасан үгээр хэлбэржүүлсэн нь дээрх шаардлагатайгаа тохирсонгүй.

Гадаад үг

Олон улсын стандарт дахь гадаад үгийг шууд зээлдэн хэрэглэхийг энэхүү ангилалд хамааруулж байна. Жишээ нь:

Микро автобус - Minibus - Микроавтобус / Жолоочийн суудлыг оролцуулан 17-оос илүүгүй хүний суудалтай нэг давхар автобус/

Вагон Вагон Wagon, coach; carriage; car Төмөр зам дээгүүр зүтгүүрийн хүчээр хөдөлдөг, ачаа болон зорчигчдыг тээвэрлэхэд зориулагдсан бүтэц, зохион байгуулалттай, систем, техник, тоног төхөөрөмжтэй хөдлөх бүрэлдэхүүний нэг нэгж

Супер маркет- хүнсний болон ахуйн барааг төрөлжсөн тасгуудаар өөртөө үйлчлэх аргаар худалдах, дундаас дээш хүчин чадалтай жижиглэн худалдааны газрыг;

аутлет (outlet) /дуудлагаар нь шууд бичсэн/ Хийц загвар нь хуучирсан, үлдэгдэл нөөц ихтэй барааг зах зээлийн дундажаас доогуур үнээр худалдах, дундаас доош хүчин чадалтай жижиглэн худалдааны газрыг;

бутик -Чамин загварын хязгаарлагдмал эрэлттэй барааг худалдан борлуулах дундаас доош хүчин чадалтай тансаг жижиглэн худалдааны газрыг;

Шинэ үг үүсгэх, буруу хэлбэржилттэй, тохироогүй үг:

Утга зохиолын хэм хэмжээнд нийцэмгүй үг хэллэгийг үүсгэж стандартад оруулсан нь бий. Үүнээс гадна нийт олны мэдэхгүй шинэ үг үүсгэх тохиолдол байна. Жишээ нь:

Шинэ өргөө хорооллын зар сурталчилгаа болгож “А3 стандарт гэж юу вэ? – Орчин үеийн барилгажилтад А3 гэж стандарт орж ирсэн. Энэ нь Агаар, Амар, Амгалан гэсэн гурван шаардлагыг дээд зэргээр хангасан цогцолбор хорооллыг хэлж байгаа юм” хэмээн телевизийн сувгуудаар сурталчилж байгаа нь стандартын талаарх олон түмэнд буруу зөрүү ойлголт өгөх үр дагавартай үйл ажиллагаа юм.

Үүнээс гадна Эртний уринш - Ранний пар - /Гуурстай нь өнжүүлээд дараажилийн хавар эхлэж боловсруулсан цулгуй уринш / гэсэн үг байна. Доктор Ш.Гаадамба “Шинжлэх ухаан амьдрал” сэтгүүлийн 1977 оны дөрөвдүгээрт нийтлүүлсэн “Нэр томьёог зөв тогтоох талаар анхаарцгаая” өгүүлэлд “...Нэрээс үйл үг үүсгэхэд хэрэглэдэг –ш дагаврыг ашиглан “цэвдэгш”, “уринш” гэх мэт нэр томьёо үүсгэн “цэвдэгшийг хагалах”, “уриншийг хагалах” зэрэг нийлэмжүүдийг буй болгосон нь “хазаарыг эвхэх” гэдэгтэй ижил утга учиргүй холбоо үг үүссэнийг тэмдэглэжээ.

Өсвөр мод Подрост Young tree Ойн дээд ташингын өндрийн дөрөвний нэгээс намхан бөгөөд яваандаа өсөж тэр ой модыг халах 2 ба түүнээс дээш насны зулзган мод. Үүнд төгөл,эсвэл залуу ой гэдгээр нэрлэвэл зохистой байж болох юм.

Фрезрдах - Фрезерование почвы Хөрсийг боловсруулж байгаа үе давхаргыг эрчимтэй бутлах, холиход чиглэгдсэн боловсруулалт. / MNS 3472 : 1983/

- Борнойдох

Боронование почвы

- Хөрсийг сийрүүлэх, солих, талбайн гадаргууг тэгшлэх, хог ургамлын соёог устгах зорилогтой хөрс бол овсруулах арга /MNS 3472 : 1983/

Тодорхойлолт

Тодорхойлолт:

Стандарт дахь нэр томьёо оновчтой, тодорхойлолтууд нь хэлний хэмнэлтийн шаардлагыг харгалзсан товч тодорхой нэгэн жигд бичлэгтэй байх нь зохистой юм. Үүнийг стандартын бүтэц ба боловсруулах дүрмийн “Жигд байдал” гэсэн хэсэгт “Стандартын бүтэц, хэв маяг, нэр үг зөвхөн ганц стандартын хүрээнд төдийгүй, мөн уялдаа холбоо бүхий стандартуудын хүрээнд нэгэн жигд байлгавал зохино” бичсэн байдаг. / стандартын бүтэц ба боловсруулах дүрэмд 4.2 **Жигд байдал** / Эдгээр шаардлага нь ялангуяа цуврал стандартын ойлгомжтой байдлыг хангахаас гадна мэдээллийг автоматаар боловсруулах буюу компьютерээр орчуулах боломжийг аль болохоор сайн ашиглахад оршино. Тиймээс нэр томьёог цахимжуулах нь нэр томьёог бүх нийтээр хэрэглэхээс гадна орчуулах, судлахад хэрэгтэй юм.

Стандартын дүрэмд стандарт боловсруулах зарчмууд тус тусгасан байна. Үүнд:

- a) Тодорхойлолт нь нэртэйгээ нэгэн ижил хэл зүйн хэлбэртэй байвал зохино: гэсэн нь тодорхойлолтын бичвэр нэгэн жигд бичлэгтэй байхыг илтгэсэн байна. Үүнчлэн
 - 1) үйл үгийг тодорхойлохын тулд үйл үгийн хэллэгийг хэрэглэнэ;
 - 2) ганц тоот нэр үгийг тодорхойлохын тулд ганц тоог хэрэглэнэ.
- b) Тодорхойлолтын зөв бүтэц нь тухайн ойлголтод хамаарах ангийг заасан суурь хэсэг болон тэр ангийн уг ойлголтыг бусдаас нь ялгаж өгсөн шинж чанаруудыг тоочсон нөгөө хэсэг болно.


Төмөр стандартын тайлбар тодорхойлолтоос харахад тодорхойлолтын өгүүлбэр нь нэр үг үндсээрээ, заах тийн ялгалтай жинхэнэ нэрээр хувилсан гэсэн хоёр өөр хэлзүйн хэлбэрээр өгүүлбэр төгсөж байгаа нь ажиглагдана. Жишээ нь:

- Төмөр замын аж ахуй нэгж байгуулага болон хөдлөх бүрэлдэхүүнд шаардлагатай хэрэгцээний усыг газар дээр нь хангах зориулалттай, зориулалтын иж бүрэн техник хэрэгсэл, тоноглолтой тусгай **галт тэрэг**.
- Зүтгүүр, вагон, түүнчлэн төмөр замаар явдаг бусад техникийг; гэх мэт.

Үүнээс гадна “Үрийн адилтгал”, “Семян выравненность”, “Improving of seeds” /Үрийн хэмжээ бусад шинжээрээ нэг төрлийн хэсэг үр бий болгох **MNS 4118:1991/** гэсэн хэлбэржилттэй тодорхойлолт бий.

Худалдааны стандартын үзүүлэлт

WORDS 1002



Худалдааны стандартын хамгийн олон тэмдэгт, үгтэй тодорхойлолт 263 тэмдэгт бүхий, 31 үгтэй. **Худалдааны газар:** Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын болон бусад стандартад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй, мэргэжлийн хүний нөөцөөр хангагдсан, худалдан авагчдын үйлчлүүлэх тав тухтай орчинг бүрдүүлсэн худалдааны байгууллага эсхүл түүний салбарыг;

Short Words (<=3 characters)	257 (26%)
Long Words (>=7 characters)	431 (43%)

Төмөр замын стандартын үзүүлэлт

WORD COUNTERWORDS 19225



Short Words (<=3 characters)	16053
Long Words (>=7 characters)	21687
Longest sentence (by number of characters)	
619 characters, 82 words: Сэргээн босгох галт тэрэг . Emergency train, wreck train Төмөр замд гарсан осол сүйрлийн үед газар дээр нь яаралтай сэргээн босгох, хөдлөх бүрэлдэхүүн замаас гарах, хөдлөх бүрэлдэхүүн зам, замын байгууламжийн эвдрэл гэмтлийг богино хугацаанд засах ажил гүйцэтгэх, галт тэрэг нь төмөр замын дагуу жигд байрлуулсан тусгай зогсоолтой, бэлэн байдалд бэлтгэгдсэн мэргэжлийн багтай, төмөр замаар явдаг их даацын өргүүр, транктор, бульдозер, татуурга, зөөврийн цахилгаан станци, сэлбэг материал, ажлын байрыг бүрэн гэрэлтүүлэх гэрэл, багаж хэрэгсэл болон шаардлагатай бусад машин механизм, техник тоног төхөөрөмж, нөөц хэрэгсэлтэй тусгай галт тэрэг	

Автомашины стандартын үзүүлэлт

7466 үг, 56320 тэмдэгт

Words	7466
Short Words (≤ 3 characters)	1662 (22%)
Long Words (≥ 7 characters)	3568 (48%)
Longest sentence (by number of characters)	
501 characters, 63 words: 2 Авто зам Highway Автомобильная дорога Тогтоосон хурд, норматив ачаалал ба овор, замын хөдөлгөөнийг тодорхойлж үйлчилж байгаа дүрэм, улсын стандарт ба дүрэм, бусад нормативын акттай тээврийн хэрэгслийн зохистой ба аюулгүй хөдөлгөөнийг хангахад зориулагдсан инженерийн байгууламжийн иж бүрдэл(зурвас газар, замын хучилт, гүүр, зам заагч, хоолой, ус зайлуулах систем, замын тэмдэг, хамгаалах төхөөрөмж, амралтын талбай, холбооны хэрэгсэл, тохижуулалтын бусад элемент, замын албаны барилга ба байгууламж)	



Стандарт дахь нэр томьёо нь стандартын агуулгыг бүрэн илэрхийлсэн, товч, тодорхой байвал зохино. Стандартын нэр нь стандартчилж байгаа зүйлийн төрөл, агуулгыг бүрэн, зөв илэрхийлсэн дараах хэсгээс бүрдэж болно.

Стандартыг орчуулахдаа тодорхой үгийг дүйцүүлэн хэрэглэхийг мөн стандартын дүрэмд зааж өгчээ. Үүнд:

Ү йл ү гийн хэлбэр	Онцгой тохиолдолд хэрэглэх ижил утгатай хэллэг (6.6.1.3-ыг үзнэ үү)
Тэгвэл зохино (тэгнэ) /shall/	тэгнэ тэгэхийг шаардана энэ нь тэгэхийг шаардаж байна тэгэх хэрэгтэй ө вхө н тэгж болно тэгэх шаардлагатай
Тэгэж болохгүй (тэгэхгүй) /shall not/	...-ийг нь зөвшөөрө хгүй (хориглоно) (ж болохгүй) байх шаардлагатай тэгэхгүйг шаардана тиймгүй байхыг шаардана

“тэгвэл зохино” гэхийн оронд “үү рэгтэй” гэдэг ү гийг хэрэглэхгүй (энэ нь гадны тогтоосон үү рэг хариуцлагыг баримт бичгийн шаардлагатай хольж хутгахаас сэргийлнэ).

Хориглосон зү илийг илэрхийлэхэд “тэгэж болохгүй”-ийн оронд “...гүй байж болно” гэж хэрэглэхгүй.

Шууд зааварчилгааг илэрхийлэхийн тулд, жишээлбэл турших аргад холбогдох ү е шатыг иш татахад англи хэлний захирах хү сэх тө лө вийг хэрэглэнэ.

ЖИШГЭЭ: “Тоглуулагчийг асаа”

Хэд хэдэн боломжоос бусдыг нь дурдахгүйгээр буюу үгүйсгэхгүйгээр аль нэгийг нь илүү тохиромжтой гэж зөвлөмжлөх, эсвэл тодорхой арга ажиллагаа нь илүү зүйтэй гэхдээ онц шаардлагатай биш, эсвэл (сөрөг хэлбэрээр) боломжит тодорхой арга ажиллагааг хориглохгүй ч гэсэн дэмжихгүй зэргийг харуулахын тулд G.2-р хүснэгтэд заасан үйл үгийн хэлбэрийг хэрэглэнэ.

Үйл үгийн хэлбэр	Онцгой тохиолдолд хэрэглэх ижил утгатай хэллэг (6.6.1.3-ыг үзнэ үү)
Хэрэгтэй / should/	... нь зүйтэй
Хэрэггүй / should not /	... байх нь зүйтэй
Үйл үгийн хэлбэр	Онцгой тохиолдолд хэрэглэх ижил утгатай хэллэг (6.6.1.3-ыг үзнэ үү)
Болно /may/	... зөвшөөрнө ... болохуйц
Шаардлага /need not/	... шаарддаггүй шаардах хэрэггүй

Энэхүү агуулгаар ”болно” гэхийн оронд ”чадна” гэж хэрэглэж болохгүй.

1- Р ТАЙЛБАР: “болно” гэсэн нь баримт бичгээр илэрхийлсэн зөвшөөрлийг заана.

Гэтэл “чадна” гэсэн илэрхийлэл нь баримт бичиг хэрэглэгчийн чадварт буюу түүнд нээлттэй боломжид хамаарна.

2- Р ТАЙЛБАР: “Чадна” франц нэр нь зөвшөөрөл ба боломжийг аль алиныг заана.

Буруу ойлголт өгөх тохиолдолд өөр үг хэллэгийг хэрэглэж байдлыг тодруулахыг зөвлөнө.

G.4 -р хүснэгт - Боломж ба чадавхи

Үйл үгийн хэлбэр	Онцгой тохиолдолд хэрэглэх ижил утгатай хэллэг (6.6.1.3-ыг үзнэ үү)
Чадах /can/	... тэгэж чадах ... бололцоотой ... тэгэх боломжтой
Чадахгүй /cannot /	... тэгэж чадахгүй ... тийм бололцоогүй ... тэгэх боломжгүй

ТАЙЛБАР: Ө.Э-р хүснэгтийн 1 ба 2-р тайлбарыг үзнэ үү.

НОМ ЗҮЙ

1. Академия наук СССР институт русского языка. Словарь русского языка. Том II. 1983.
2. А. Болд бусад. Монгол орны шувууны зүйлийн нэрийн арван хэлний толь. УБ., 2007.
3. Л.Болд. Монгол хэл шинжлэлийн асуудалд. Улаанбаатар. 2006.
4. Д.Дашдаваа, Э.Равдан Нэр томьёоны тухай. УБ., 1980.
5. Ч.Догсүрэн. Монгол нэр томьёо оноох, толилох жигдлэх асуудалд. УБ., 1988.
6. С.Дуламцэрэн “Дэлэнтийн ангилал зүй, ангилбарын монгол нэр томьёо /латин, монгол, англи, орос/. Улсын нэр томьёоны комиссын мэдээ №148.
7. Монгол улсын засгийн газрын тохируулагч агентлаг. Стандарт хэмжилзүйн газар. “Монгол улсын стандарт”. 2018.
8. Нэр томьёо судлал. УБ., 2009, № 11.
9. /Нэр томьёо судлал. УБ., 2005, №7.
10. Oxford Advanced Learner’s Dictionary of Current English.
11. /Seventh edition/ 2005.

12. Э.Пүрэвжав. Монгол хэлний хэм хэмжээ. 1996.
13. А.В.Суперанская, Н.В.Подольская. Общая терминология. Москва., 2003.
14. /Улсын нэр томъёоны комиссын мэдээ. № 113-116. УБ., 1982.
15. А.Эрдэнэцэцэг. Бидний сонголт – аюулгүй байдал. УБ., 2011.

논 문 투 고 일 : 2018년 10월 30일
논 문 심 사 일 : 2018년 11월 15일
논문게재결정일 : 2018년 11월 30일

МОНГОЛ ХЭЛЭНД ОРСОН ГАДААД ҮГИЙН ТУХАЙ

Эрдэнэ ПҮРЭВЖАВ*

Abstract

ON FOREIGN WORDS IN MONGOLIAN

Erdene PUREVJAV*

Every nation has been in constant communication with other neighboring countries for hundreds of years and thus its traces remain even in the language of the nation with “зээлдмэл үг” (loan words) from the different languages. A loan word can also be called differently as “гадаад үг” (foreign word), “ормол үг” (entered word), “зээллэг үг” (borrowing), “харь үг” (“adopted word” and “non-native word”) depending on its differences of usage and meaning in modern Mongolian. It exerts a profound impact on Mongolian vocabulary enrichment. Approximately ten percent of the total Mongolian vocabulary is loan words derived from foreign languages. Using a foreign word regardless of equivalent native Mongolian word for it can lead to misunderstanding and the language impurity. The loan words have entered the Mongolian in two ways: through oral speech and written language. The most percent of loan words in Mongolian is new terminologies of different special fields.

Keywords : Mongolian language, loan word, terminology, usage and principle

Аливаа ард түмэн олон зуун жилийн туршид хөрш зэргэлдээх бусад улс түмэнтэй үргэлжийн цагт төрөл бүрийн харилцаатай явж ирсэн бөгөөд түүний ул мөр хэлэнд нь ч гэсэн зохих хэмжээгээр уламжлан үлддэг учраас хэл бүрийн үгийн сангийнх нь үндсэн бүрэлдэхүүнд гадаад хэлнээс орсон “зээлдмэл үг” (loan words) буй. Энэхүү “зээлдмэл үг”-ийг орчин цагийн монгол хэлэнд “гадаад үг”, “ормол үг”, “зээллэг үг”, “харь үг”

* ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Монгол хэл шинжлэлийн салбар) / purvee_9@yahoo.com (Department of Mongolian Linguistics, Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences)

гэхэчлэн утга агуулгын өнгө аясын ялгамжаатай нэрлэдэг. Хэл бүрийн үгийн сан дахь гадаад үгийн хувь хэмжээ өөр өөр ажээ. Тухайн хэлний идэвхтэй үгийн санд гадаад үгийн эзлэх хувийн жин, эдлэх бүрэн эрх нь чухам хэр зэрэг байгааг анхаарч судалбал сонирхолтой гэж бодож байна.

Монгол хэлний үгийн сангийн үндсэн бүрэлдэхүүнийг арвижуулан баяжуулагч нэгэн эх сурвалж нь гадаад хэлнээс гаралтай үг мөн. Гадаад хэлнээс үг зээлдэх ёс нь улс түмнүүдийн нийгэм улс төр, соёл шинжлэх ухаан, худалдаа эдийн засгийн хэлхээ холбоо, тухайн хэлээр ярилцагч ард түмний хил залгаа орших улс орон, бусад хэлний утга зохиолыг орчуулах зэрэг бодит үзэгдлийн тусгал ажээ. Орчин цагийн шинжлэх ухааны хэл бүрэлдэн тогтоход үг зээлдэх ёс нь онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг. Шинжлэх ухаан, техникийн хөгжлийн эриний зүй ёсны үр дагавар болж, монгол хэлэнд гадаад хэлнээс нэр томьёо, мэргэжлийн үг хэллэг олноор орж иржээ. Монгол хэлэнд орж ирсэн гадаад хэлнээс гаралтай үг хэллэгийн ихэнх хувийг нь шинэ нэр томьёо эзэлдэг. Нэр томьёо тухайн мэргэжлийн утга зохиолын салбарт их хэрэглэгдэх боловч бусад мэргэжлийн хүмүүс болон нийт хүмүүст ойлгомж муутай учраас идэвхгүй үгсийн тоонд багтана. Нийгмийн хөгжлийг дагаж бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэхийн хэрээр шинэ үг хэллэг орж ирдэг нь хэл шинжлэлийн үзэгдэл билээ. Гадаад хэлнээс гаралтай нэр үгээс “данслах”, “жижүүрлэх”, “кодочлох”, “принтерлэх”, “програмчлах”, “таксидах”, “чатлах”, “шанздах”, “электронжуулах” гэх мэтэчлэн үйл үгийг шинээр үүсгэж болно. Монгол хэлийг ихэд үйл үгжсэн хэл хэмээн монгол судлаачид үздэг.

Монгол хэлний үгийн сангийн үндсэн бүрэлдэхүүнийг ажиглан үзэхэд нүүдэлчин ард түмний амьдрал ахуй, зан заншил, соёл боловсролтой уялдаа холбоотой уугуул монгол үг, нэр томьёо дийлэнх хувийг эзэлж байгаагаас гадна, евроазийн олон улс үндэстэнтэй эдийн засаг, арилжаа худалдаа, утга соёл, шинжлэх ухааны харилцаатай явж ирсний үр дүнд харь хэлний үг монгол хэлэнд цөөнгүй байдаг. Монгол хэлэнд гуравдагч хөрш хэлнүүдээс зээлдсэн асар олон үг буй. Тухайлбал, манж-тунгус, түрэг, хятад, төвд, араб, орос зэрэг олон хэлний үг байдаг. Хүн гүрний үе буюу I-II зуун, Түрэгийн үе буюу VI-VII зуун, Уйгурын үе буюу VIII зууны үед олон мянган үг зээлдсэн юм. Энэ урт хугацаанд монгол, түрэг хэл бараг л холимог хэл болсон гэж үздэг. Харин XVI-XX зуунд буддын шашны нөлөөгөөр төвөд хэлний хэдэн зуун үг монгол хэлний үгийн сангийн бүрэлдэхүүнд нэвтрэн оржээ. Зүйрлэн хэлбэл, монголчууд энэ урт хугацаанд бурхан, чөтгөрийн аль алинтай ярих чадвар эзэмшсэн [Лувсандорж 2004: 91] гэхэд болно. Нэг хэлний үг болон нэр томьёо нөгөө хэлэндээ нэвтэрч орох явдал нь хэл бүрийн түүхэн хөгжилд тохиолддог түгээмэл үзэгдэл юм.

Монгол хэлний үндсэн үгийн сангийн нийт бүрэлдэхүүний барагцаалбал арав гаруй хувь нь гадаад хэлнээс гаралтай үг байна. Монгол хэлэнд эртний дорно дахины соёл, шинжлэх ухааны “номын хэл” болсон самгарди хэлнээс “агар, адис, бадаг, боть, ганга, зандан, маргад, матар, очир, судар, цадиг, шүлэг, эрдэнэ”; уйгур хэлнээс “зул, лавай, суврага, титэм, хувраг, хурмаст, шалтаг, эрлэг”; араб хэлнээс “алмас, архи, саван, султан, цув”; түрэг хэлнээс “билиг, билүү, боз, жимс, олбог, тансаг, таяг, тэвнэ, тэрлэг, үзэм, хөрөг, хөрш”; перс хэлнээс “анар, барс, болд, болор, булгаар, бэрс, дарь, диван, зээр, тарвас, тоть, хөвөн, хүхэр, чихэр”; төвөд хэлнээс “баг, бар, бум, бурам, гантиг, гарчиг, гортиг, дацан, дом, дутан, мадаг, намтар, нандин, нярав, равжамба”; манж хэлнээс “авдар, амбан, бэйс, залан, занги, майхан, сүрэг, сэлэм, хуаран, хурандаа, цуух, эрин”; хятад хэлнээс “байцай, банз, гоймон, даавуу, ёотон, жоотуу, луужин, мужаан, мантуу, сампин, цалин, цонх, янз”; орос хэлнээс “бааз, завод, замаг, жижүүр, овьёос, отряд, пүрш, яармаг” гэх зэрэг өдий төдий үг нэвтрэн оржээ. Эдгээр гадаад үгс нь монгол албан бичиг, сонин сэтгүүл, уран зохиол болон шинжлэх ухааны зохиолын хэл найруулгад харьцангуй идэвхтэй хэрэглэгдэж байна.

Орчин цагийн монгол хэлний үг хорших ёс, үг давтах ёсонд сонин содон үзэгдэл нэлээн байдаг. Монгол хэлний уугуул нэр үгийг гадаад хэлнээс гарал бүхий нэр үгтэй хоршин хэрэглэж утгыг илүү тод тодорхой гаргаж, мэдээллийг аль болох онцолж хэлэх өнгө аяс ажиглагддаг. Монгол хэл хоршоо үгээр тун баялаг. Сонин нийтлэл, уран зохиол, эрдэм шинжилгээ, яриа, албан хэргийн гэх мэт их таван найруулгын төрөлд янз бүрийн бүтэцтэй хоршоо үг улам их түрж, хэрэглээ давтамж, найруулгын үүрэг нь тэлсээр байна. Монгол хэлний хоршоо үгийг бүтэц, хэв маяг, үгийн аймаг, үүсвэр бүрэлдэхүүн ба найруулгын талаас нь ажваас бас сонин, олон талтай. Утга ойролцоо үгийг хоршино, утга эсрэг үгийг хоршино, төсөө үгийг хоршино, утга зүйн нэг талбайн үгийг хоршино, бас толгой холбон хоршино, сүүл холбон ч хоршино. Хоёр өөр хэлний ижил утгатай, тэнцүү чанартай үгийг хорших нь бүр ч сонин. Үүнд “монгол үг + гадаад үг”, “гадаад үг + монгол үг” гэсэн хоёр загвараар хоршино. Тухайлбал: “амбан захирагч”, “гацаа тосгон”, “цэрэг цуух” гэх мэтээр монгол үгийг манж үгтэй; “ад чөтгөр”, “зай завсар”, “заль мэх”, “сэхээ самбаа” гэх мэтээр монгол үгийг санскрит үгтэй; “зүү тэвнэ”, “таар шуудай”, “той хурим”, “цал буурал” гэх мэтээр монгол үгийг түрэг үгтэй; “баг идээ”, “гүнцэг зоог”, “намтар түүх”, “орог саарал”, “үйл лай”, “эм дом” гэх мэтээр монгол үгийг төвөд үгтэй; “арга бааш”, “бай мөрий”, “ган гачиг”, “гуу жалга”, “данс хараа”, “дэн буудал”, “маапаан будлиан”, “пүүгээ дэвсгэр”, “холион бантан”, “хоол цай”, “хээ хуар” гэх мэтээр монгол үгийг хятад үгтэй; “жижүүр манаа”, “машин тэрэг”, “норм хэмжээ”, “оочир дугаар”, “орц

дооз”, “үүрэг роль”, “хаяг адрес” [Пүрэв-Очир 2009: 136] гэх мэтээр монгол үгийг орос үгтэй хорших ёс тун элбэг.

Монгол хэлэнд хятад хэлнээс гаралтай үг нэлээд эрт үеэс эхлэн нэвтэрч эхэлсэн бололтой. Профессор Б.Ринчен (1905~1977)-ий гярхай ажигласанчлан “Нягталбаас, зуугаар хэлэлцэхгүй, хэдэн мянган оноор эд соёлын харилцааны түүхийг бодох эртний соёлт монгол, нангиад хоёр угсаатны хэлний түүхийг хөөн бодоход, нангиадаас монгол хэл, түрэг хэлнээ нэвтэрсэн зүйл байх нь аргагүй. Бас монгол, түрэг хэлнээс ч нангиад хэл бичигт орсон зүйл нягтлан судалбаас гарцаагүй байх учиртай” [Ринчен 2012: 35] гэж үздэг. Дундад эртний үеийн монгол хэлний дурсгалуудад “ван”, “гүнж”, “гүүш”, “тайхуу”, “үжин”, “чинсан” гэх мэтийн хэргэм тушаалыг нэрлэн заасан үг тохиолддог. Монгол хэлэнд XVI-XX зууны үед хятад үг, нэр томьёо өргөн орж ирэхдээ гол төлөв энгийн ярианы хэлний замаар худалдаа арилжааны үйл ажиллагаатай холбогдож нэвтэрч байв.

Орчин цагийн монгол хэлэнд нэлээд тооны хятад хэлнээс гаралтай үг бий. Жишээ нь: “байцай” < 白菜 (bai cai) [цагаан ногоо], “банз”, бантан, “банш”, “буу”, “гоймон”, “гуанз”, “даавуу”, “даалимба”, “данс”, “дэнлүү”, “эзвэн”, “ёотон”, “жанжин”, “жоотуу”, “лууван”, “лянхуа”, “маапаан”, “мантуу”, “мужаан”, “наймаа”, “панз”, “пин”, “пуужин”, “пүүс”, “сампин”, “цалин”, “цонх”, “чамин”, “чийдэн”, “шаазан”, “шийгуа”, “шүүгээ”, “яндан”, “янз” гэх мэт. Монгол хэлэнд нэгэн үе элдэв төрлийн “тасалбар”-ыг “пиу” < 票, “тэрэг”-ийг “чийчаан” < 汽車 гэж хятад хэлнээс үүсэл гаралтай үгээр нэрлэн тэмдэглэдэг байснаа хожим нь “билет”, “тасалбар”; “машин”, “тэрэг” хэмээн өөрчлөн нэрлэх болжээ. Хятад хэлнээс орсон зарим үг монгол хэлэнд нэлээд ондоо утга агуулгатай болсон нь тодорхой харагддаг. Жишээлбэл: “даавуу” гэж хятад хэлээр хамгийн доод зэргийн бүдүүн ширхэгтэй бүс ёргийг хэлдэг бол монгол хэлэнд хөвөн ба ноосон нэхмэл эд барааны аль алиныг нь нэрлэн заадаг.

XXI зууны босго өнгийсөн эрин үед гадаад хэлнээс гарал бүхий үг хэллэг, нэр томьёог харьцангуй элбэг хэрэглэх өнгө аяс, чиг хандлагатай байна. Жишээ нь: “Өдрийн сонин”-ы 2008 оны II сарын 14-ний өдрийн 36 (2800) дугаарт нийтлэгдсэн сэтгүүлч Б.Цэнддоогийн бичсэн “Монгол юм” хэмээх нэгэн нийтлэлд “авто, адидас, академи, ампул, англи, ансамбль, арми, байцаа, бизнесмэн, буу, вакуум, вето, вирус, гамин, госчоом, доктор, европ, жанжин, жууцай, и-мэйл, инженер, кирил, комбинаци, компьютер, латин, лууван, маневилдуулах, манжин, марль, маск, машин, мораль, найк, пальто, панзчин, пилээтэг, программ, процесс, пуризм, пүүз, салмаандар, системчлэх, социализм, техник, технологи, тооромсог, түжүүрэк, финик, хааблл дуран, хааз, хантааз, христ, чаатлах, чийчаан, шифрлэх, шприц, шэлээп, электрон, элемент” [Цэнддоо 2008] гэсэн харь хэлний өдий

төдий олон төрлийн үг хэллэг, нэр томьёо орсон байгааг дурдалтай.

Шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний зохиол бүтээлийн гол үүрэг, үндсэн зорилго нь дэвшүүлсэн санаа оноо, таамаглалынхаа үнэн мөнийг батлахад л оршино. Тийм учраас хэлний хэрэгсэл нь шинжлэх ухааны зохиолын мэдээлэх ба нөлөөлөх гэсэн хоёр зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Шинжлэх ухааны зохиол бүтээлд хувь хүний найруулгын өнгө аяс мэдэгдэхүйц хэмжээгээр товойн илрэх учиргүй юм. Яагаад гэвэл, шинжлэх ухааны зохиолын хэл найруулга нь нийтэд бүрэн ойлгомжтой бөгөөд тов тодорхой байх зарчмыг гол болгодог. Хэл найруулга бол тухайн хүний дахин үл давтагдах нэгэн өвөрмөц шинж чанар мөн ч гэлээ шинжлэх ухааны зохиол бүтээлд зүй ёсны хэмжээ хязгаартай байвал зохино.

Орчин цагийн монгол утга зохиолын хэл бүрэлдэн тогтох явцад орос хэлээр дамжуулан эзэлдэн хэрэглэсэн “аптека” (эмийн сан), “зонтик” (шүхэр), “колбаса” (хиа), “микроб” (нян), “санитар” (асрагч), “сестра” (сувилагч), “талон” (тасалбар), “яблок” (алим) гэх мэтийн европ зүгийн хэлний үгсийг дүйж онолдох монгол үгээр нь сольж хэрэглэж байсан юм.

Монгол хэлэнд байгаа харь хэлнээс гаралтай үг нь аман яриагаар болон бичгийн хэлний замаар гэсэн хоёр янзаар орж ирсэн бололтой. Европ зүгийн хэлнүүдийн үг, нэр томьёо нь гол төлөв ном зохиолын орчуулгыг дагалдан, өөрөөр хэлбэл, бичгийн замаар дамжин монгол хэлэнд нэвтрэн орж иржээ. Тэгвэл төвд, хятад, манж, орос хэлнээс эзэлдэн авсан үгийн зарим хэсэг нь аман ярианы хэлээр дамжин монгол хэлэнд орж ирсэн байна. Аман ярианы хэлээр дамжин монгол хэлэнд нэвтэрсэн үгс дуудлагын хувьд илүү ихээр хувирч, монголжуу өнгө аястай болдог бол бичгийн хэлээр дамжин нэвтэрсэн үгс нь харь хэлнийхээ өнгө төрхийг илүүтэй хадгалдаг өвөрмөц онцлогтой ажээ.

Монгол хэлний хуучирсан үгийн багагүй хэсгийг харь хэлнээс гаралтай үг эзэлдэг юм. Энэ нь тухайн юм, үзэгдлийн талаарх ойлголт, ухагдахуун нь хуучирч хэрэглэгдэхээ больдогтой нэг талаар шууд холбоотой боловч нөгөө талаар монгол уугуул үгийн бодит хэрэглээ, эх хэлний үүрэг өссөнтэй бас хамааруулан үзэж ч болох судалгааны сонирхолтой сэдэв гэж бодож байна. Жишээлбэл: Орчин цагийн монгол хэлэнд нэлээд хэдэн жил идэвхтэй хэрэглэж байсан “витамин” (vitamin), “градус” (gradus), “курс” (course), “район” (rayon), “шприц” (spritze) зэрэг харь хэлний үгийг “амин дэм”, “хэм”, “дамжаа”, “дүүрэг”, “тариур” гэх мэт монгол үгээр солин нэрлэх боллоо.

Орчин цагийн монгол хэлний үгийн сангийн бүрэлдэхүүнд байгаа гадаад хэлнээс гаралтай үгийг хэл ярианы соёлын үндсэн шаардлага, монгол хэлний үг хэрэглээний хэм хэмжээний үүднээс хоёр хуваан үзэж болмоор санагдаж байна.

Нэгдүгээрт, урьд өмнө байгаагүй юм, үзэгдэл болон цоо шинэ ухагдахууныг нэрлэн тэмдэглэсэн гадаад хэлнээс гарал бүхий үг, нэр томьёо нь монгол хэлний үгийн санг баяжуулж байгаа нэг ёсны ашиг тустай, хэлний зайлшгүй үзэгдэл болно. Үгийн сангийн бүрэлдэхүүний хувьд богино хугацаанд баяжиж, орчин үетэйгээ хөл нийлүүлж, шинэ нэршил олноор нь үүсгэж, шинжлэх ухаан, техник технологийн үг хэллэгээр зузаарч байгаа хэл [Батбаяр 2014] бол монгол хэл. Энэ хэсэгт хамаарах харь хэлнээс гаралтай үг хэллэг, нэр томьёо нь монгол хэлний үгийн сангийн бүрэлдэхүүний үндсэн нэгж болж чадсан байна. Жишээ нь: “автобус”, “банк”, “боть”, “дэвтэр”, “ёотон”, “замаг”, “комисс”, “концерт”, “намтар”, “ном”, “саван”, “үзэм”, “хурандаа”, “яармаг”, “яндан” гэх мэт үгийг юуны өмнө дурдаж болох юм. Эдүгээ монголчууд орос “шар айраг”-ийг “пиво”, өрнийн “шар айраг”-ийг “бийр” (beer), хятад “шар айраг”-ийг “пийжүү” (啤酒) [píjiǔ] гэж утга агуулгын ялгамжаатай нэрлэж дуудах болжээ.

Хоёрдугаарт, нэрлэн зааж чадахуйц уугуул монгол нэр нь байсаар атал харь хэлний үгийг хослуулан хэрэглэвэл монгол үгийн сангийн бүрэлдэхүүнийг будлиантуулан бохирлож, хэл яриаг ойлгомжгүй болгодог муу талтай. Хэлний цэвэр байх чанарт энэ нь шууд харшилдаг.

Монгол хэл бичгийн эрдэмтэн мэргэд нэлээн дээр үеэс эхлэн монгол хэлэндээ гадаад хэлний хэрэгцээгүй үг хэллэг, буруу ташаа орчуулга нэвтрэн орохын хор хөнөөл, учир холбогдлыг сэрэмжлүүлэн сануулж байсан уламжлалтай ажээ. Хэлний зүйч эрдэмтэн Данзандагва гүүшийн “Зүрхэн толтын тайлбар”-т “Тийн атал заримууд төвд номд шүтэж, монгол номыг доромжлохуй хийгээд, заримууд монгол номыг бага сага мэдээд оморхож, төвд номыг доромжлогч нь дээд номыг тэвчсэн билээ” [Монгол 1983: 16] хэмээн тэмдэглэсэн нь буй. Үндэснийхээ монгол хэл, үсэг бичгээ доорд үзэж, харь газрын хэлийг бишрэн шүтэгч этгээдүүдийг шүүмжлэхдээ их сударч В.Инжаннаши (1837~1892) бээр “Манай энэ Зостын чуулганы баахан цэцэн оюутан олонх иргэн бичгийн утга үсэгт хичээх буй за. Ер монгол үг учиргаа хичээх үгүйн дээр ар газрын үг аясыг мэдэх мэргэд шууд үгүйн тул, ар газрын үгийн утгыг эрэн асуухуйяа маш бэрх. Харин хятад үсгийн учрыг нэхэмжлэхээс бэрхтэй болжээ. Манай газрын хянамгай үгүй ард өөрөө өөрийн монгол үг ба үсгээ туйлд хүртэл хичээн хянах үгүй бөгөөд нэгэн хоёр иргэн үсэг таниваас, даруй монгол үсгээ басамжлан, монгол үгсээр иргэний санааг бүртгэн гаргаж хэрхэн чадмуй хэмээн амны аяар чалчмуй. Тэр маш ихэд ташаарсан хэрэг болай. Хэмээх нь далайн хөвөөнд биеэ угаагаад, далайг гүехэн үзсэнээс юун өөр буй” [Инжаннаши 1957: 15] хэмээн бичсэн нь юутай үнэн, юутай сургамжтай билээ.

Их эрдэмтэн О.Жамьян (1864~1930) гүн “Урт өдрийн улиг үгний бичиг” (1925) хэмээх

бүтээлийнхээ төгсгөлд “Бас манай монгол овогтны дотор гадаад улсын хэлийг өөрийн үндсэний хэл мэт хэлэлцдэг нь олон буй. Аль буй хэмээвээс, баруун Хөхнуур зүгийн монголчууд зарим нь төвөд үгээр хэлэлцмүй. Хойд буриад зүгийн монголчууд зарим нь орос үгээр хэлэлцмүй. Зүүн Хөлөнбуйр зүгийн монголчууд зарим нь хятад ба манж үгээр хэлэлцмүй. Өмнө дотоод чуулганы монголчууд зарим нь хятад үгээр хэлэлцмүй. Энэ мэт гадаад улсын хэлэнд хуваагдан агсаар, хуучин монгол хэл бичгээ мэдэхгүй болохуйд хүрвээс, үнэхээр хайрлалтай болов уу? хэмээхийг эртхэнээс сануулья” [Жамьян 1925: 22] гэж гэрээслэн сургамжилжээ.

Академич Б.Ринчен 1936 онд бичиж хэвлүүлсэн “Монгол үсгээр оросын зэрэг гадаадын нэрсийг зөв бичих тухай” хэмээх судалгааны өгүүлэлдээ “Бид өдөр тутам, эрдэм шинжлэл, улс төрийн учир зохиох бичихүйд гадаад улсын газар ус, хот балгад, хүн ардын нэр олон улс нийтээр нэгэн адил хэрэглэх грек, латин үндсэний үг, нэр томьёо зэргийг хэрэглэх болай. Гэтэл тийнхүү гадаадын үг, нэр бичихүйд хараахан тогтсон журам үгүй тул нэгэн нэрийг элдвээр бичих нь үзэгдмүй. Зарим чингэж бичсэнийг үсэгчлэн уншваас үнэн мөнийг олохуйяа бэрхтэй” [Ринчен 1936: 188] гэж онцлон тэмдэглэсэн нь буй. Тэрбээр 1934 онд туурвиж хэвлүүлсэн “Орчуулгын чанарыг дээшлүүлэх тухай” өгүүлэлдээ “Зарим орчуулагч “үхэр” хэмээвээс зохихыг “*том эвэртэй мал*”, “*хонь ямаа*” хэмээвээс зохихыг “*жижиг эвэртэй мал*”, “*хэрэглэгдэхүүн*” хэмээвээс зохилтойг “*мидариал, мадериал, митарал, матирал, матириал*” хэмээх ба “*айл өрх*” хэмээвээс зохихыг “*аж ахуй*” хэмээх мэтээр “орчуулан” бичдэг нь манай орчуулагчдын үгийн засгаар маш буурайг гэрчилнэм бөгөөд монгол үгийн ёс зүйг бодохгүй ба мэдэх төсөөлөхийг ч хүсэхгүй, ганцхүү гадаадын хэлний үг найруулгыг “хүн хорхойчлон” дууриан хуулдгийг илтгэжээ” [Ринчен 1991: 20] хэмээсэн байна. Гадаад хэлний үг хэллэгийг монголчлон буулгахад эх хэлнийхээ гол ёс, тогтсон хэм хэмжээнд тулгуурлах ёстой.

Харь хэлний үг хэллэгийг зүй зохистой эс хэрэглэвэл шинжлэх ухааны зохиол бүтээл дэх монгол хэлний үг хэрэглээний хэм хэмжээг зөрчиж, улмаар утга зохиолын хэлний үгийн сангийн бүрэлдэхүүнийг будлиантуулахад хүргэдэг. Харь хэлний үгсийг хэл яриандаа тодорхой бодлого, онцын зорилгогүйгээр шахуу, учир начиргүй хэт чамирхан хэрэглэх нь хэлний үг хэрэглээний хэм хэмжээнд муу нөлөө үзүүлдэг. Нэгэнт хэвшсэн үг хэллэг, нэр томьёог үг хэрэглээний бодит орчноос шахан зайлуулж, түүний оронд цоо шинэ үг, шинэ нэр томьёо авч хэвшүүлэхэд асар их цаг хугацаа, басчиг чамгүй хүч хөрөнгө шаардах нь мэдээж юм.

Эх хэлний мэдлэг тааруутай хүн, мэргэжлийн болон гадаад хэлний мэдлэг гаргуун сайтай байгаад, уг юм, үзэгдэл, ойлголт хийгээд гадаад нэр томьёоны нарийн учрыг

мэдэвч, монгол бичгийн болон ярианы хэлэнд түүнтэй дүйх ямар үг байдаг, байж болохыг мөн л тэр бүр эс мэдэн, эрж сурвалжилж, олон зүйл хуучин шинэ толиос шүүрдэхийн оронд зарим үгийн утгыг ташаа ухааран дүйлгэх, үгийг буруу үүсгэн оноох, эсвэл монгол нэр томьёо нь ардын хэлэнд бэлээхэн байгаа зүйлийн гадаад нэр томьёог хэвээр хэрэглэх зэрэг эндэгдэл гаргах [Догсүрэн 1988: 47] нь цөөнгүй байдаг. Олон тооны гадаад үг монгол хэлэнд орж ирсний заримд нь утга, үүргийн хувьд бүрэн дүйхүйц уугуул монгол үг байгаа боловч тэдгээрийг эс тоомсорлон үл хэрэглэдэг нь харамсалтай. Энэхүү үзэгдлийг “хэлээ алдах” [Адьяа 2005: 58] гэх нь буй. Тухайлбал: “авлига”-ыг “коррупци” (corruption), “барьцаат зээлийн газар”-ыг “ломбард” (lombardo), “дүр төрх”-ийг “имидж” (image), “дэмжигч”-ийг “фен” (fan), “тоглолт”-ыг “шоу” (show), “удирдахуй”-г “менежмент” (management), “улсын их хурал”-ыг “парламент” (parliament), “улсын их хурлын дарга”-ыг “спикер” (speaker), “чансаа эрэмбэ”-ийг “рейтинг” (rating), “эвлүүлэг”-ийг “клип” (clip) гээд л ярьж бичээд байдаг болчихвол “хэлээ алдахын цондон” хэмээдэг. Эдүгээгийн монгол хэлэнд “галт тэрэг”, “зайдас”, “зайрмаг”, “зуслан”, “өргөст хэмх”, “төмөрлөг”, “хөдөлгүүр”, “шүхэр” гэх мэт монгол нэр томьёо (үг) нь байсаар атал хажуугаар нь зэрэгцүүлээд шинжлэх ухааны хэл найруулгад харь хэлний “поезд”, “сосиска”, “мороженое”, “лагерь”, “огурец”, “металл”, “мотор”, “зонтик” зэрэг үгийг олонтоо хэрэглэх нь ерөөсөө илүүц зүйл болно.

Одоогийн хэрэглэгчид цөмөөрөө мэдэхгүй шахуу монгол үгээ хэрэглэснээс, бүгдээрээ ерөөс мэдэхгүй гадаад хэлний үгийг хэрэглэсэн нь хавьгүй дээр гэж боддог хүмүүс ч бас байдаг бололтой. Энэ санаа нь явуур муутай гэдэг нь хэнд ч ойлгомжтой. Монгол хэлэнд социализмын үед орос хэлний үгс их хэмжээгээр нэвтэрч орж ирж байсан бол зах зээлийн өнөө үед англи хэлний үгс харьцангуй олон тоогоор хэрэглэгдэх боллоо. Том жижиг улс үндэстэн, нийгэм эдийн засгийн хөгжлийн төвшний зохих ялгаа л байдаг болохоос биш, “том жижиг хэл”, “баян ядуу хэл” гэсэн ойлголт бараг байхгүй юм. Иймээс энэ дэлхий дээр “онцгой боловсронгуй” болон “онцгой болхи хэл” гэж хаана ч байдаггүй билээ.

Орчин цагийн монгол хэлний үгийн санд шинжлэх ухаан, техникийн шинэ нэр томьёог зохиож боловсруулахдаа “хуулбар үг” (калька < calque)-ийг маш өргөнөөр хэрэглэх боллоо. Хуулбарлан орчуулах гэдэг нь үгийн утгыг зээлдэн авч буй хэрэг мөн. Өөрөөр хэлбэл, аливаа юм үзэгдэл, ухагдахууныг нэрлэсэн үг, нэр томьёог үгчлэн орчуулах ёсыг хэлнэ. Энэ арга нь харь үгээс зайлсхийх нэгэн арга зам юм. Нэрлэлт нь монгол, ухагдахуун нь харь [Өнөрбаян 2012: 127] байдаг. Үүний жишээнд монгол хэлний “бага хурал”, “гийгүүлэгч”, “номын сан”, “нэвтэрхий толь”, “хүчил төрөгч”, “хэл шинжлэл”, “хэлц үг” гэх мэтийг нэрлэж болох юм.

Сүүлийн жилүүдэд монгол хэлнээ харь хэлний үг хэллэг үерийн булингарт ус сад тавин, хүч түрэн цутгах лугаа адил эмх замбараагүй нэвчин нэвтрэх болсон нь эх хэлээ эрхэмлэгч эгэл олны анхаарлыг эрхбиш зүй ёсоор эмзэглүүлэн татах боллоо. Булингарт бохир ус лугаа адил сад тавин цутгаж буй хачин чамин, гаж этгээд, буруу зөв харь хэлний үг хэллэгийг монгол хэлний хилийн дээс давмагц нь л угтан барьж, анхнаас нь зүй зохистой журамлан цэгцэлж, оносон таарсан нэр усаар нь зөв зүйтэй, оновчтой хялбараар орчуулж хэвшүүлэх шаардлагатай юм. “Үг бол өвөг дээдсийн үе дамжуулан өмчлүүлж бидэнд үлдээсэн өнгө нь үл гандах шижир эрдэнэ. Гэтэл түүнийг зэвэрдэг, өнгө алддаг гуулиар сольсоор байгаа”-г эрдэмтэн зохиолч Л.Түдэв шүүмжилсэн нь буй.

Аялгуу сайхан монгол хэлээ хольцгүй цэвэр ариун байлгаж, үеийн үед, үрийн үрд үүрд эх хэлээрээ хэлэлцэн явахыг туйлаас эрхэмлэхийг эндэж огоорон, хогийн тантан болгосоор явбал нэг мэдэхэд л бид тийм гэх тэмдэггүй, тэр гэж тэмтэршгүй олон хэлний холимог эрлийзжиж хурлийзажсан, хүн сонсовч хүний өөрийнхийг авсаархан ялгахын аргагүй “хэлтэй” болчихсон байх вий гэхээс сэтгэл ихэд эмзэглэдэг [Ганбаатар 1996] билээ. Урд хөрш маань эх хэлэндээ харь үг оруулдаггүй хатуу чанга хаалгатай, харуул манаа олонтой бололтой. “Оноосон нэр орчуулагдахгүй” хэмээн манайхан цэцэрхэж суухад, “кока кола” (coka cola) гэдэг ундааны нэрийг дуун ижилсгэх ёсыг гол болгон 可口可乐 “kě kǒu kě lè” буюу “цангаа тайлах цэнгүүн ундаа” хэмээн нэр өгч хөрвүүлсэн байдгийг дурдахад илүүдэх юун. “Кока кола” (coka cola) хэмээх ундааг орчин үеийн хятад хэлээр 可口可乐 “kě kǒu kě lè” гэж хэлдэг. Энэ нэрийн 可 “kě” нь туслах үг бөгөөд “-ж чадах, -ж болох, зохих” гэсэндүү утгыг илэрхийлдэг аж. 口 “kǒu” нь “ам” гэсэн утгатай агаад 乐 “lè” хэмээх үг нь “баясах, цэнгэх, хөгжилтэй” гэсэн утгатай юм. Өөрөөр хэлбэл, 可口可乐 “kě kǒu kě lè” (coka cola) хэмээх нэр нь “аманд зохимжтой, баясаж чадах ундаа” гэсэн утгатай. Ийнхүү гадаад авианы дуудлага төдийгүй, илэрхийлж буй дотоод утга агуулга нь ч бас нэрээ тодотгож бүрэн чадсан байна. Энэ бол хятад хэлэнд гадаад хэлний үгийг зээлдэн авч хэрэглэх ёсны нэгэн өвөрмөц арга мөн.

Академич Ш.Лувсанвандан (1910~1983) бичиж туурвисан “Хүний хэлийг их, бага үндэстэн ярьдаг гэж ялгалгүй адилхан хөгжүүлсе” гэдэг өгүүлэл нь даяаршлын эрин үед их, бага аль ч үндэстний хэл бичиг, утга соёлын хувь заяаг хаашаа эргэх учиртай юм бол гэсэн ярвигтай асуудалд шинжлэх ухааны үндэслэлтэй хариу өгснөөрөө онолын ач холбогдолтой юм. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд “Аман хэл бүхэн авианы хэлтэй, бичгийн хэл бүхэн үсэгтэй байна. Дундын бичгийн хэл нь нутгийн бичгийн хэлний зэрэгцээгээр тэдний соёлын зэвсэг болж, нутгийн хэл нь тэдний өдөр бүрийн харьцахын хэрэглүүр болж байжээ. Тэр цагт их үндэстний хэл нь бага үндэстнийхээ хэлийг дэмжиж,

бага үндэстний хэл нь их үндэстнийхээ хэлийг дэмжиж, харилцан тусалсаар иржээ. Шинэ цагт хүрч ирэхэд франц, англи, испани, орос мэтийн хэл бүсийн хэл болсон боловч бага үндэстний хэл зэрэгцэн оршсоор иржээ. Ийм нөхцөл байдалд нэг хэл, соёлтой болгох зорилт тавивал одоогийн байгаа олон хэл, соёлыг устгах хэрэг болох юм. Харин олон хэл, соёл зэрэг хөгжих зорилго тавих нь байгаль, нийгмийн хуулинд илүү тохирч олон хэлтэн, соёлтон, арьстан хамтран ажиллах бололцоо гарч ирнэ. Хэл, соёл, арьсны хөгжил ч хэвийн байдлаар үргэлжилж, ёстой интернационалчаар хөгжих болно. Хэрэв ганц хэлтэй болбол хэл, соёл, арьсны хэвийн хөгжил эвдэрч, интернационал гэсэн үг ухагдахуун ч байхгүй болно. Хэрэв ганц хэлтэн болбол ялсан нь бахархаж, ялагдсан нь гомдох тул арьсны үзэл дэврэхэд хүрнэ. Энэ учраас бид одоо хэлийг их, бага үндэстэн ярьдаг гэж ялгалгүй адилхан хөгжүүлэх хэрэгтэй болж байна. Бага үндэстний хэл, соёл, арьсны сайн хөгжих нь их үндэстний хэл, соёл, арьс хөгжихөд тус болно. Бага үндэстний хэл, соёлыг тэдний бичгийн хэлээр дамжуулан хөгжүүлж болно. Бага үндэстний бичгийн хэлээр бага, дунд, дээд сургуулийн сурах бичгийг бүрэн орчуулж, зохиож гаргах, бусад үндэстэн хэрэглэсэн шинжлэх ухаан-техникийн утга зохиол, ерийн утга зохиолыг өргөн орчуулах, нутгийн хэлийг албан хэлэнд сайн хэрэглэх зэрэг ажил буюу нэг үгээр хэлбэл, цөөн үндэстний бичгийн соёлыг аль болохоор хөгжүүлэх хэрэгтэй болж байна. Бага үндэстний хэлийг хөгжүүлэх нь тэр үндэстний соёл, шинжлэх ухааныг хөгжүүлэх явдал болно. Улмаар бүх дэлхийн шинжлэх ухаан, техникийг хөгжүүлэхэд бага үндэстний хэл, соёлыг ашиглах гэсэн санаа болно. Аж үйлдвэрийг хөгжүүлэхэд орон нутгийн бололцоог сайн ашиглах хэрэгтэй гэдэгтэй адил нийт хүн төрөлхтөний хэл, соёлыг хөгжүүлэхэд нутаг нутгийн хэл, соёлыг бас нэг адил хөгжүүлэх хэрэгтэй байна. Ойр байгаа жижиг үндэстний хэлийг хичнээн түргэн хөгжүүлж чадсан их хэлтэн нь төчнөөн гавьяатай хэрэг үйлдсэн болно” [Лувсанвандан 2005: 243] хэмээн онцлон дурджээ. Энэ бол эдүгээгийн даяаршлын эрин үед олон хэлний харилцан нөлөөллийн нарийвчлан судлуудтай асуудлыг тоотойхон хэдэн эрдэмтний толгойд түүчээлэн явдаг судлаач хүний холч мэргэн ухаанаар урьдчилан дүгнэсэн хэл шинжлэлийн онолын томъёолол мөн.

Монгол сэтгэлгээ, монгол уламжлал, монгол ахуйг өвлүүлэн дамжуулагч монгол хэлээ цэвэр ариун байлгахад монгол хүн бүрийн идэвх чармайлт хэрэгтэй. Хэл ярианы соёлтой хүн үү, үгүй юү гэдэг нь хэн нэгэнтэй уулзаад мэндэлж байгаа байдлаас эхлээд мэдэгддэг. Иймд хүн бүр хэлэх ярих үг яриа, туурвин бичиж буй бичиг зохиолдоо үг хэллэгийг туйлын оновчтой зөв сонгон хэрэглэж сурах шаардлагатай юм. Монгол ардын дуунд “тавхан үгнээсээ танигдана” хэмээсэн байдаг. Уугуул монгол үг, монгол нэр нь байсаар атал гадаад хэлний илүүц үгийг давхардуулан авч хэрэглэвэл монгол хэлний үгийн

сангийн бүрэлдэхүүнийг бузарлан бохирдуулж, хэл яриаг ойлгомж муутай болгох нь дамжиггүй билээ.

АШИГЛАСАН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

- [Адьяа 2005] - О.Адьяа. Хэл, хэл шинжлэл, орчуулга (сурахуй, сургахуй, судлахуй) [редактор Б.Чулуундорж]. Уб., 2005. 223 х.
- [Батбаяр 2014] - Б.Батбаяр (Баабар). Киноны хэл. –“Өдрийн сонин”, № 17 (4657). 2014.I.22.
- [Ганбаатар 1996] - Я.Ганбаатар. Үгэн шижрийг өнгө алддаг гуулиар сольсоор байна. –“Улаанбаатар” сонин, № 43 (975). 1996.III.1.
- [Догсүрэн 1988] - Ч.Догсүрэн. Монгол нэр томьёо оноох, толилох, жигдлэх асуудалд (редактор Ц.Шагдарсүрэн). Уб., 1988. 104 х.
- [Жамьян 1925] - О.Жамьян. Урт өдрийн улиг үгний бичиг. Уб., 1925. 23 х.
- [Инжаннаши 1957] - В.Инжаннаши. Хөх судар, тэргүүн дэвтэр (дахин хэвлэл) [урлагийн редактор Буянхишиг]. Хөххот., 1957. 728 х.
- [Лувсанвандан 2005] - Ш.Лувсанвандан. Хүний хэлийг их, бага үндэстэн ярьдаг гэж ялгалгүй адилхан хөгжүүлэе. –“Ш.Лувсанвандан. Хэл, харьцаа, тэмдэг”, V дэвтэр (эрхэлсэн Ж.Баянсан). Уб., 2005. х.242-243.
- [Лувсандорж 2004] - J.Lubsandorji. The Phonetics of Foreignisms Coming Through Russian into Present-day Mongolian ('mongolization'). –“Mongolica Pragensia '04”. Prague., 2004. pp.91-112.
- [Монгол 1983] - Монгол хэлний шинжлэлийн дурсгал бичиг. Хөххот., 1983. 177 х.
- [Өнөрбаян 2012] - Ц.Өнөрбаян. Харь үг, түүнийг журамлах хэм хэмжээ (унгар хэлний жишээн дээр). –“Монгол хэл бичиг”, XII боть. Уб., 2012. х.126-129.
- [Пүрэвжав 2001] - Э.Пүрэвжав. Шинжлэх ухаан, техникийн монгол нэр томьёог боловсруулж ирсэн туршлага. –“Нэр томьёо судлал”, № 4. Уб., 2001. х.43-56.
- [Пүрэвжав 2006] - Э.Пүрэвжав. Шинжлэх ухааны зохиолд гадаад хэлнээс гаралтай үгийг зүй зохистой хэрэглэх асуудалд. –“Хэлний соёлын тулгамдсан асуудлууд”, № 2 (шинжлэх ухааны хэл найруулга). Уб., 2006. х.109-124.
- [Пүрэв-Очир 2009] - Б.Пүрэв-Очир. Үг, өгүүлбэрийн амьдрал араншин, эрчим энерги, соёл хэрэглээ, VII дэвтэр (ариусган хянасан Д.Нямаа). Уб., 2009. 292 х.
- [Ринчен 1936] - Б.Ринчен. Монгол үсгээр оросын зэрэг гадаадын нэрсийг зөв бичих тухай. –“Шинэ толь” сэтгүүл, № 3-4. Уб., 1936. х.188-191.
- [Ринчен 1991] - Б.Ринчен. Марк Твений минь махы нь идэж дээ! (орчуулгын тухай)

- [эмхэтгэн эрхэлсэн Г.Аким]. Уб., 1991. 230 х.
- [Ринчен 2012] - Б.Ринчен. Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган, VII боть (“Монгол бичгийн хэлний зүй”, гутгаар дэвтэр, хэлбэр судлал) [эмхэтгэн хэвлүүлсэн Э.Пүрэвжав]. Уб., 2012. 151 х.
- [Цэнддоо 2008] - Б.Цэнддоо. Монгол юм. –“Өдрийн сонин”, № 36 (2800). 2008.И.14

논 문 투 고 일 : 2018년 10월 30일
논 문 심 사 일 : 2018년 11월 15일
논문게재결정일 : 2018년 11월 30일

Дундад эртний монгол хэлний судалгаанд холбогдсон зарим асуудлын тухай өгүүлэх нь*

Боржигин Оюун**

Abstract

Some Problems in the Research of Medieval Mongolian Literature

Bao Wuyun**

The research of medieval Mongolian is mainly related to Uighur Mongolian. Phags-Pa script. The secret history of Mongolia's Chinese phonetic symbol and Arabic phonetic symbol. Beyond that it's also includes Brahmi alphabet, Qidan alphabet, Runic alphabet's literature. This paper mainly describes how to study and research the medieval Mongolian literature and give some example.

Keywords : Medieval Mongolian literature research technique

Эртний монгол хэлийг ерөнхийдөө өмнөх эртний монгол хэл хийгээд дундад эртний монгол хэл гэж хоёр үед хуваадаг. 13-16 дугаар зуун хүртэлхийг дундад эртний монгол хэл гэж, 13 дугаар зуунаас өмнөх үеийнхийг өмнөх эртний монгол хэл гэдэг. Үүнд: Дундад эртний монгол хэлний судалгаанд голдуу уйгуржин үсэг, дөрвөлжин үсэг, “Монголын нууц товчоон”-ы хятад галиг хийгээд араб галиг зэрэг үсэг бичгийн дурсгалт бичгүүд холбогдохоос гадна, киданүсэг, барахмиүсэг болон руни үсгийн дурсгалт бичиг

* Тус өгүүлэл бол улсын нийгмийн шинжлэх ухааны суурь мөнгөний төсөл болох “Торгон зам дагуу тархаж байгаа уйгуржин үсгийн дурсгалт бичгийн эмхэтгэл судлал” (зөвшөөрсөн дугаар: 16ХҮҮ017)-ийн шатч чанартай бүтээл болно.

** Өвөр монголын багшийн их сургуулийн профессор, Бээжин их сургуулийн доктор. Дундад эртний монгол хэл, монгол сурвалж бичгийн судалгаагаар голлон, “Дуньхуан агуйн уйгуржин монгол бичээсний хэлний судлал” зэрэг ном бүтээл байдаг.

Өвөр монголын багшийн их сургуулийн Монгол судлалын дээд сургууль / baowuyun2014@126.com (Inner Mongolia Normal University)

ч зохих хэмжээгээр холбогдон судалгааны хүчрийн хэмжээ ч өндөр болж иржээ.

Дундад эртний монгол хэлний судалгаанд дээр дурдсан олон зүйлийн үсэг бичгийн сурвалж бичиг холбогдож байхын тулд, дундад эртний монгол хэлний судалгаанд хандуулж, чухалчлах асуудлын талаар доорх хэдэн зүйлээс голчлон ярих болно.

Нэг. Дундад эртний монгол хэлний сурвалж бичигт холбогдсон тэгдгээрүсэг бичгийг сурч эзэмших хэрэгтэй. Энэ нь дундад эртний монгол хэлний судалгааны урьдал нөхцөл мөн. Эс тийм бол эндүү буруу зүйл гарах юм. Нэгэн жишээ дурдвал: нэгэн залуу эрдэмтнээс “Монголын нууц товчоон”-ы 94 дүгээр зүйлд гардаг “*Дай сэцэн Тэмүжинийг үзэж маш их баясаж өгүүлрүүн: Тайчууд ах дүү чиний найдмуй хэмээн мэдэж маш эрж цөхрөлгэй. Аран үзэв зэ, чамайг хэмээгээд Бөртэ Үжинийг нийлүүлээд үүсгэв*”¹⁾ гэдэг хэсэг дахь “аран” гэсэн үгийг “наран” гэж үзвэл зүйтэй гэсэн байна. Түүний үзэхээр, уйгуржин үсэгт гийгүүлэгч n нь өмнөө дусалтай болон дусалгүй хоёр хэлбэрээр бичигддэг болохоор “аран” гэдэг нь одоох монгол бичгийн “наран” байвал зохистой гэсэн баримтыг дурдсан байдаг.

Тус үзэлт нь хэдийгээр уйгуржин үсгийн бичлэг онцлогоос гардан ёс баримттай ярьсан боловч, гол нэгэн асуудал гэвэл манай үед олдсон хамгийн анхны “Монголын нууц товчоон”-ы дэвтэр нь хятад галигаар монгол хэлийг тэмдэглэсэн байхыгумартан, хятад галиг дээр чухам ямар үгээр бичигдэж байх бий гэсэн асуудлыг оmtгойлсон явдал болно.

Дээрх дурдагдсан хэсэг жишээний “Монголын нууц товчоон” дахь хятад уул галигийг нь үзүүлбэл доорх мэт:

德薛禅 帖木只泥 兀者周 馬石 也客 巴牙思抽 鳴訖列^ᠰ論 泰亦赤兀^楊 阿^中合 迭兀 赤訥
乃塔木 客延 篋迭周 馬石 赫^ᠰ魯周 噉可列埃 阿^ᠰ闌 兀者罷 者 赤馬宜 客額^楊 孛兒帖
兀只泥 捏亦列兀列額^楊 額兀思格罷 (§94)

“аран” гэдэг үгийг “Монголын нууц товчоон”-ы хятад галигт “阿^ᠰ闌” хэмээн бичиж байхаас нь үзвэл агап (аран) гэдэг нь маш тодорхой байдаг. Яасан ч нагап (наран) болох боломжгүй юм. “Аран” гэдэг үг нь “турк хэлэнд агап аран хэмээх нь дөнгөж, арай царай, арай чамай (“турк нутаг” бодь I, 252). Дагуур хэлэнд арайг агап хэмээмүй. “Хорин нэгт тайлбар” шинэ хэвлэл, нүүрт 38, В-д аливаа өчүүхэн хүрсэнгүйгарай хэмээмүй. Арай гүйцэтсэнгүй, арай саадхийв хэмээх зэргийн үгэнд хэрэглэмүй. “аран үзэв зэ” хэмээвээс арай учралдаж, чамайг олж үзэв гэсэн болой”²⁾ гэх утгатай байдаг.

1) Элдэнтэй, Ардажав: “Монголын нууц товчоон — сийрүүлэл тайлбар”, Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1986 оны 12 сар, 215 дугаар нүүр.

Дээр ярьснаар “Монголын нууц товчоон” дахь “аран” гэх үгийн хятад галиг 阿^舌蘭-г сайн сурч таньсан юм бол түүнийг “наран” (納^舌蘭) гэж үзвэл зохистой гэдэг үзэлтэй болох боломж байхгүй юм. Учир нь, “Монголын нууц товчоон”-ы хятад галигт “а”-г阿 гэх үсгээр, “на”-г納 гэдэг маш тодорхой ялгаа зөрөөтэй үсгээр тэмдэглэсэн байдаг.

“Монголын нууц товчоон” бол дундад эртний монгол хэлний маш чухал дурсгалт бичиг болох тул түүний үлдэгдэж ирсэн хятад галигийг заавал сайтар сурч эзэмших бол дундад эртний монгол хэлний судалгаан хийгээд “Монголын нууц товчоон”-ы тус биеийнхэн судалгааны хамгийн урьдал нөхцөл мөн байх ёстой. Эс тийм бол эндүү буруу зүйл гарч л мэднэ.

Хоёр. Дундад эртний монгол хэлний судалгаанд холбогдох тэдгээр үсэг бичгийг сайн сурч эзэмшсэнийхээ суурин дээр, бодитой сурвалж бичгийг заавал гүнзгий уншин тайлбарлах хэрэгтэй, энэ бол дундад эртний монгол хэлний судалгааны үндсэн шаардлага мөн.

Үүний тухай монгол улсын тайхар чулуун дээрх уйгуржин монгол үсгийн бичээсэнд илэрсэн “-Дай гүрү” гэх үгийг уншин тайлбарлахаар жишээлье.

“Дай” гэдэг үгийг “том” гэдэг утгатай. “Гүрү” гэдэг үг нь “чулуу” гэх утгатай. Нийлээд “Том чулуу” гэсэн утгатай гэж Гарди профессор тайлбарлаж өнгөрсөн байдаг. Үүнийг цаашдаа гүнзгий тайлбар хийвэл, “-дай” гэдэг үг нь дөрвөлжин үсгийн дурсгалт бичигт “dai du”³⁾ (хятад хэлэнд 大都 гэдэг) гэдэг үгэнд илэрч өнгөрсөн бөгөөд “Том” гэдэг утгатай юм. “Гүрү” гэдэг үг “Монголын нууц товчоон”-д илэрсэн бодтой жишээг доор сийрүүлбэл:

巴撒^中合兒抽 阿亦速恢突兒 石恢因 阿馬撒^舌刺^中豁失里^中浑 帖堆 察^中罕 古^舌魯
阿馬撒^舌刺 孛^克連 兀納主兀 (§80)

Ийнхүү “Монголын нууц товчоон”-д “古^舌魯” гэдэг үг нь хажуугийн орчуулаад нь “石” хэмээн, “чулуу” гэсэн утгатай байсан нь тодорхой мэдэгдэнэ.

Дээрх мэтээр дундад эртний монгол хэлэнд холбогдсон олон зүйлийн үсэг бичгээр байгаа дурсгалт бичгийг нарийн гүнзгий уншин тайлбарлах бол маш чухал байдаг.

Гурав. Дундад эртний монгол хэлийг тэмдэглэсэн адил бусын үсэг бичгийн сурвалж бичгийг хооронд нь харилцан уялдуулан харьцуулах хэрэгтэй. Энэ нь судалгааны чанар

2) Элдэнтэй, Ардажав: “Монголын нууц товчоон — сийрүүлэл тайлбар”, Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1986 оны 12 сар, 217 дугаар нүүр.

3) Хөгжилт, Саруул: “Дөрвөлжин үсгийн монгол хэлний дурсгалт бичгийн эмхэтгэл”, Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 2004 оны 8 сар, 349 дүгээр нүүр.

чансааг дээшлүүлж, судалгааны өндөр түвшинд хүрэхийн баталгаа гэж хэлж болох юм.

Дундад эртний монгол хэлний үгийн эхний шүргэх гийгүүлэгч h-аар жишээлбэл, гагц уйгуржин үсгээс үгийн эхэнд шүргэх гийгүүлэгч байх эсэхийг тодорхой үзэж гарахгүй байдаг. Дундад эртний монгол хэлний бусад үсэг бичгийн дурсгалт бичгээс тухайлбал дөрвөлжин үсэг хийгээд хятад галиг, араб галигтай харьцуулж үзвэл, маш тодорхой дүн олдог.Хэдэн үгээр Жишээлбэл:

уйгуржин үсэг	дөрвөлжин үсэг	хятад галиг	араб галиг
arban	harban	harban	harban
aran	haran	haran	haran
üker	hüker	hüker	
on	hon	hon	hon

Энэ хэдэн жишээ үгийг харвал, адил нэгэн үг “арван”-ы үгийн эхэнд шүргэх гийгүүлэгч байсан гэдгийг дөрвөлжин үсэг, хятад галиг болон араб галигт “harban” гэж илэрч байхаас тодорхой олж харах юм. Хэрвээ олон зүйлийн үсэг бичгийн дурсгалт бичгийг ингэж хооронд нь уялдуулан харьцуулахгүй юм болзарим зүйлийг тодорхой олж харахгүй болно.

Дөрөв. Дундад эртний монгол хэлэнд холбогдох шинэ сурвалж бичгийг идэвхтэйгээр эрин цуглуулах хэрэгтэй. Энэ бол судалгааны амьжралын хүчний баталгаа мөн. Тухайлбал: Дээр зууны наяд оны үед, Өвөр монголын багшийн их сургуулийн Хас-Эрдэнэ, Гарди зэрэг эрдэмтдээс Дуньхуан агуйн уйгуржин монгол бичээсийг хайн шинжиж, шинээр илрүүлсэн явдал нь тухайн үеийн дундад эртний монгол хэлний судалгаанд цоо шинэ материалыг хангаж, монгол түүх сурвалж бичиг судалгаан, дуньхуаны судалгаан, тэрчлэн Ази европыг сундалсан торгоны замын судалгаан зэрэг хамаа бүхий судалгаанд шинэ уур амьсгалыг авчирч өглөө.Ойрын жилүүдэд Гарди зэрэг эрдэмтдээс Өвөр монголын хянган аймаг, шулуун хөх хошуу зэрэг газар орноос бас уйгуржин үсгийн хадан бичээс, дөрвөлжин үсгийн хөшөөний бичиг зэргийг шинээр илрүүлэн судалж байгаа нь дундад эртний монгол хэлний судалгаандамьжралынхүчнийг авчирч өгч байлаа. Миний бие ч Франц, Монгол улс хийгээд Өвөр монгол зэрэг орноос дундад эртний монгол хэлэнд холбогдох дурсгалт бичгийг шинээр хайн илрүүлэх ажилд идэвхтэй оролцож, зохих амжилт олж байхдаа маш урамтай байна.

Ерөнхийд нь үзвэл дундад эртний монгол хэлний судалгаанд уйгуржин үсэг, дөрвөлжин үсэг, хятад галиг, араб галиг хийгээд бас барахмиүсэг, руни үсэг, киданүсэг зэрэг олон

үсэг бичиг холбогдож, судалгааны хүчирддэгийн хэмжээ нэлээд өндөр байдаг юм. Иймийн тул бид энд дурдсан хэдэн талыг чангатгаж, судалгааны дунд оршиж байгаа зарим асуудалд хандуулан, зохистой шийдвэрлэх арга хэмжээ бодогдсоноо энд хичээнгүйлэн дурдсан байна.

Ном зүй :

额尔登泰、乌云达赉：《〈蒙古秘史〉校勘本》，内蒙古人民出版社，1991年7月二次版。

ИхмянгадайИрэнчэн, “Монголын нууц товчоон”-ы уйгуржин үсгийн сэргээлт, 1987 оны 8 сар.

乌兰：《元朝秘史》校勘本，中华书局，2012年7月。

Баяр, “Монголын нууц товчоон”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1981 оны 1 сар.

保朝鲁：《穆卡迪玛特蒙古语词典》，内蒙古大学出版社，2002年7月。

包乌云：《敦煌石窟回鹘式蒙古文题记的语言研究》，内蒙古教育出版社，2014年4月。

胡格吉勒图、萨如拉：《八思巴蒙古语文献汇编》，内蒙古教育出版社，2004年8月。

嘎日迪：《中古蒙古语研究》，辽宁民族出版社，2006年12月。

Дов, “Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичгүүд”, Үндэстний хэвлэлийн хороо, 1983 оны 6 сар.

Шонхор, “Монголын нууц товчоон”-ы сэргээлт, 2001 оны 1 сар.

논 문 투 고 일 : 2018년 10월 30일
논 문 심 사 일 : 2018년 11월 15일
논문게재결정일 : 2018년 11월 30일

Синтаксическая роль нефинитных глагольных форм МОНГОЛЬСКОГО И ТУРЕЦКОГО ЯЗЫКОВ

Жолт Тот*

Abstract

Syntactic Functions of Non-Finite Verb Forms in Mongolian and Turkish

Zsolt Tóth*

Making comparative analyses of Altaic languages would be expedient to pay more attention to syntactic analyses, because exactly the syntactic structure of these languages has changed least. One of the typical features of the Altaic languages is the vast number of non-finite verb forms, which play an important role in the formation of subordinative constructions. The quantity of Indo-European-type complex sentences in Turkish and in Mongolian is insignificant. The main method for the expression of subordinated relations at syntactic level is the application of participial and gerundial phrases, and in Turkish also the application of infinitival phrases. By their syntactical function the infinite phrases of both languages can be the attributive, adverbial, objective, subjective and predicative ones. The most productive method is the formation of the attributive constructions, and the most diversified one is the formation of the adverbial constructions, first of all the temporal ones. The most widespread constructional elements of the Mongolian and the Turkish constructions are identical, and often the principle of formation of constructions is the same. Exist constructions, which ones coincide totally, e. g. antecedent construction *after that*, which in Mongolian is **-с(А)нАас хойш**, and in Turkish is **-DiktAn sonra**, and their structure in both languages is a perfective participle with ablative case suffix plus a postposition with meaning *after*. In both languages the sentences involving an infinite construction can be same-subject or different-subject ones; the separate subject of a construction is usually formed by a non-nominative case suffix, in Mongolian primarily by accusative case suffix, and in Turkish by genitive case suffix. Usage of case suffixes in Mongolian is less consistent than in Turkish, especially in the spoken language.

Keywords : subordination, Mongolian syntax, Turkish syntax, participial and converbial construction, non-finite verb forms

* Университет им. Этвеша Лоранда, Будапешт / zsolt680828@freemail.hu
(Eötvös Loránd University, Budapest)

При сравнительных исследованиях алтайских языков следует обращать больше внимание на синтаксические анализы, так как именно синтаксический строй этих языков изменился в наименьшей мере. Для алтайских языков характерны мощные системы нефинитных форм глагола, которые играют важнейшую роль в образовании подчинительных конструкций. Число сложно-подчинённых предложений “индоевропейского типа” то есть с помощью союзных слов в турецком и монгольском языках совсем незначительно. Основным методом подчинения на синтаксическом уровне является использование причастных и деепричастных оборотов, а в турецком ещё и инфинитивных оборотов.

1. Проблемы при оценке нефинитных глагольных форм

Изучение так называемых нефинитных глагольных форм алтайских языков имеет большое значение не только с точки зрения морфологии, но и синтаксиса. Это изучение осложняется, не только то, что в современной англоязычной и русскоязычной научных описаниях нет полностью обоснованной общепризнанной теории в связи так называемых нефинитных форм глаголов, сверх того отсутствует и подходящая терминология. Кажется, что в современной международной лингвистической литературе инфинитив, причастие и деепричастие чаще всего считается частью глагольной парадигмы, то есть глагольной (вербальной) формой. Но в случае алтайских и типологически на них похожих языков это не окажется слишком обоснованном, потому что по морфологическим свойствам нефинитные формы не имеют никакого общего с глаголами. Более целесообразно считать, что так называемые нефинитные глагольные формы являются не глагольными а только отглагольными (девербальными) формами. Возникается вопрос, что инфинитив, причастие и деепричастие являются ли самостоятельными частями речи, или они какие-нибудь переходные части речи, или просто они входят в рамки ту часть речи, которую они могут заменить, то есть причастия – это имена прилагательные, деепричастия – это наречия, а инфинитив – это имя существительное. К этой теме добавляется ещё вопрос имена действия (poen actionis). Некоторые лингвисты считают его отдельной нефинитной формой, другие либо инфинитивом, либо именем существительным.

2. Причастия

Причастия в монгольском языке в отличие от турецкого могут выступать в качестве

любого из членов предложения. Причастие в положении перед именем является его определением, а причастие в форме косвенных падежей или послелогом является дополнением или обстоятельством в обоих языках. В монгольском языке причастие в форме именительного падежа, чаще всего, с лично-притяжательными частицами, которые функционируют детерминантом, является подлежащим, а в турецком языке вместо причастия может выполнять роль подлежащего инфинитив. В обоих языках причастие может служить составной частью сказуемого. Но в монгольском языке причастие может быть сказуемым даже самостоятельно, занимая в предложении самое последнее по порядку место. Но это свойство вторичное явление.

Монгольские причастия могут окказионально обозначать не только действие, но и исполнителя, объект или результат действия. (Санжеев 1964: 195). Монгольские причастия могут выполнять не только функции причастия (*participium*), а функции инфинитива (*infinitivus*), поэтому они в некоторых грамматиках называются глагольными именами (*nomen verbale*). Морфологическая особенность причастий обоих языков, что могут склоняться по падежам и управляться послелогом. Причастия могут иметь (синтетическую) отрицательную форму в обоих языках. Кроме того могут иметь притяжательные суффиксы, в турецком лично-притяжательный, а в монгольском возвратно-притяжательный.

В монгольском языке когда причастие обозначает лишь исполнителей действия, оно может принимать и суффикс множественного числа, например: *ирсэд* 'прибывшие' от *ирсэн* 'прибывший' (Санжеев 1964: 196).

3. Деепричастия

In time words may modify their meaning. Mongolian and Turkish have also been influenced by this evolutionary dimension. This article proceeds by defining the content and scope of linguistics and semantics, and concludes with semantic analyses of connotation differentiation of some Mongolian and Turkish words.

Keywords : Word meaning, change of word, Mongolian and Turkish

Үгийн утга нь хэлний түүхэн хөгжлийн явцад байнга хувьсан өөрчлөгдөж шинэ олон утгаар баяжиж байхын хамт тухайн үгийн хэрэглээний хүрээ хязгаар ч мөн адил түүнийг даган хувирч байдаг ажээ. Нэг хэлэнд үгийн сангийн түвшинд илрэх утга нөгөө хэлэнд хэлзүйн бүтээврээр илэрч болох бөгөөд энэхүү үзэгдэл хэлний хөгжлийн үе шатуудад нэг хэлэнд ч үүсч болно. Аливаа нэг үг цөм утгаас гадна хэд хэдэн салаа утгатай байж болох бөгөөд тэрхүү цөм утгад түшиглэн бусад дэд утгууд салаалан үүсдэг билээ. Профессор Д.Бадамдорж “Монгол хэлний үгийн сангийн утгазүй” номдоо “... Нэг үг цөм утгаас гадна хэд хэдэн салмал утгатай байж болно. Тухайн үгийн цөм утга нь тэр үгийнхээ салмал олон утгыг нэвчин хэлхэж, хэл эзэмдэгч хүний ой тоонд эхлэн буух шинжтэй юм. Ийм учраас үгийн салмал утгаас бусад утгыг өмнөх хойдхи үг буюу хам хүрээллээс мэдэж болно”(Д.Бадамдорж, 2006: тал.162) хэмээн тэмдэглэсэн бол эрдэмтэн Ж.Төмөрцэрэн “Үг бүр ганц утгатай байх албагүй, зарим үг зүйл зүйлийн санаа нэвтрүүлсэн олон

* МУИС, Ази судлалын тэнхим / gerelmaa@num.edu.mn
(National University of Mongolia)

утгатай хэрэглэгдэх нь цөөнгүй. Нэг үгийн өөр өөр салбар утгатай болсоныг олон утгат үг гэж нэрлэнэ”(Ж.Төмөрцэрэн, 2001: тал.27) гэжээ. Үгийн олон утга нь анхны цөм утгаас салбарлан үүссэн, хоорондоо харилцан холбоотой, ойролцоо утгууд байдаг.

Бид энэхүү өгүүлэлдээ үгийн олон утга хэрхэн бүрэлдэн тогтдог болох, түүнийг хэлний түвшин тус бүрт авч үзэх, түүнчлэн төрөл хэлүүд хийгээд аман аялгууны доторхой жишээ баримттай харьцуулан тайлбарлахыг зорьсон болно. Үгийн утгын өөрчлөлтийг илрэх түвшингээр нь үгийн сангийн ба хэлзүйн түвшин хэмээн үндсэн хоёр зүйл болгон авч үзэх боломжтой.

1. Үгийн сангийн түвшинд утга өөрчлөгдөх нь:

Үг хэллэгийн үгийн сан, өгүүлбэрзүйн түвшинд илэрхийлэх олон утгыг аман аялгуу болон төрөл хэлүүдийн хүрээнд авч үзэх нь тухайн үгийн гарал язгуур хийгээд бүтцийг зөв тодорхойлоход илүү дөхөм болж байна. Тодорхой хэдэн жишээгээр тайлбарлая.

Монгол хэлний “keji-” буюу хэжих хэмээх үйл үг нь “уул хавцгайн хажуу халил, ус мөрний хясаа мэтийн явах туулах бэрх замаар явах”(Я.Цэвэл, 2013: тал.1039) утгыг илэрхийлдэг билээ. Энэхүү үйл үндэсээскеjih(бартаат замаар явах), kejiü(бартаат зам), kejlüür(бартаатай), kejiimeg(бартаа, саад), keč(хад асгатай, бэрх) гэх мэт төрөл үгс үүссэн байна. Мөн баруун монголчууд хүүхэд тогтдоггүй айл хаалганыхаа дээд талд улаан өнгийн бөс даавуугаар хийсэн дээс татдаг уламжлалтай бөгөөд үүнийг “kejim”(хэжим) хэмээн нэрлэдэг ажээ. “Хэжим” нь тухайн айлд гадны хүн орохыг хориглосон тэмдэг, саад болдог тул “keji-” үйл үндэсээс үүссэн үг мөн байна. Энэхүү үг монгол хэлтэй төрөл гарал нэг түрэг хэлний эртний бичгийн дурсгалд мөн тохиолдож буй.

Тоньюкукийн гэрэлт хөшөөний бичээсийн хойт талын 1-р мөрөнд,

галиг: aq termel keče kelti.

орчуулга: Ак Тэрмэл(уулын нэр)-ийг хэжиж ирэв.

Тоньюкукийн гэрэлт хөшөөний бичээсийн баруун талын 3-р мөрөнд,

галиг: ertiš ügüzüg keče keltimiz.

орчуулга: Эртиш мөрнийг гатлан ирэв бид.

Кэлтигиний гэрэлт хөшөөний бичээсийн зүүн талын 39-р мөрөнд,

галиг: yinčü ügüzüg yüzüti kečip...

орчуулга: Еинчү голыг гатлан ... хэмээн тус тус тохиолдож байна. Эртний түрэг

хэлний толь бичигт тухайн үйл үгийг “явах, гатлах, давах” гэсэн утгатай хэмээн тэмдэглэжээ(В.М.Наделяев., 1969: стр.648). Сурвалж дахь хам сэдвээс үзэхэд явж туулахад бэрх өндөр уул давааг давах, эсвэл томоохон гол мөрнийг гатлахыг “keç-” үйл үгээр илэрхийлсэн байдаг. Харин орчин цагийн түрк хэлэнд “geç-” хэлбэрээр уламжлан үлдсэн бөгөөд утгын хувьд харьцангуй ерөнхий болж “өнгөрөх, явж өнгөрөх, давах, давж гарах”(Türkçe sözlük, TDK, 2005: s.917) гэсэн утгаар хэрэглэгдэж буй. Иймээс “keji-” үйл язгуурын уугуул цөм утга нь монгол хэлний хэрэглээнд хадгалагдан үлдсэн “хэжиж явах” утга болно.

Үгийн утга хэлний хэрэглээний явцад тодорхойгоос ерөнхий, ерөнхийгөөс тодорхой болж өөрчлөгдөж болно. Монгол хэлний “cingna-”буюу “чагнах” үйл үг “тодорхой зорилготой, анхааралтай сонсох, эсвээс нууцаар сонсох, сэм сонсох”(Я.Цэвэл, 2013: тал.1114) гэсэн утгатай. Авианы түүхэн хувьслын үр дүнд “tingna-;cingna-;çagna” хэлбэрээр хадгалагдан үлджээ. “cingy-a” буюу “хатуу, чанга” гэх үгтэй гарал нэг гэж үзвээс “сонсох” ерөнхий утга бус “хатуу чанад сонсох, сайн сонсох, анхааран сонсох” гэсэн тодорхой утга илэрхийлж байна. Эртний түрэгийн үеийн руни бичгийн сонгодог дурсгалд “qadırdı tıñlä-” буюу “хатуу чанга сонс-, сайтар сонс-” гэсэн холбоо үгийн илэрхийлэх утга монгол хэлний баримттай тохирч байгаа юм. Үгийн “tingna-;tıñlä-” хэлбэрүүд нь “mangnai; manglai”(магнай;манлай) –тай нэгэн адил “-na; -la” үеийн сэлгэцээр үүссэн нэг үгийн хувилбарууд гэж үзэх нь зүйтэй. Орчин цагийн түрк хэлэнд авианы хувьслын үр дүнд тухайн үгийн эхний “t” гийгүүлэгч “d” болж “dinle-” хэлбэрээр хадгалагдан үлдсэн хэдий ч илтгэх утгын хувьд “сонсох, дуулах” гэсэн ерөнхий утгатай болжээ.

Монгол хэлний зарим аялгуунд тухайлбал баруун монголчууд “нохойн гөлөг, чонын бэлтрэг”-ийг “kičig”(кичиг) гэж нэрлэнэ. Мөн арслангийн зулзагыг нэрлэх “güyüg”(геүг)-ийг энэхүү үгтэй гарал холбоотой хэмээн үздэг. Аливаа амьтны үр төлийг нэрлэж буй эдгээр үгсийн нийтлэг цөм утгыг түрэг хэлний баримтаас сурвалжлан үзвэл орчин цагийн түрэг хэлнээ “бага, жижиг” гэдгийг “küçük”, эртний түрэг хэлний бичгийн дурсгалд “kičig” гэсэн хэлбэрээр тус тус тохиолдож байна. Уугуул гол утга нь “бага, жижиг” овор хэмжээг заасан тэмдэг нэрийн утга байгаад хожуу “амьтны үр, зулзага”-ыг заан нэрлэсэн тодорхой утгатай болсон хэмээн үзэж байна. Монгол хэлний “öcüken”(өчүүхэн) гэх үгийн утга, гарал язгуур үүнийг давхар баталж байна. “Маш бага, жижигхэн” гэсэн утгатай энэ үгийн бүтцийг “öcüк+ken(тэмдэг нэрэнд залгаж утгыг багасгах үүрэгтэй дагавар)” хэмээн задлан тайлбарлах боломжтой. Монгол, түрэг төрөл хэлүүдэд энэ мэт үгийн эхний гийгүүлэгч аль нэг хэлэнд нь гээгдэх зүй тогтол арвин тохиолддог билээ(Го.Jorigyту, 2004:).

Үгийн утга ерөнхийгөөс тодорхой болон өөрчлөгдсөн жишээнд монгол хэлний

“qulaqi”(хулхи) гэх үгийг оруулж болно. “Чихэн дотор хуралдсан хаг мэт наалдаа зүйл”(Я.Цэвэл, 2013: тал.1000)-ийг бид “хулхи” гэж нэрлэдэг боловч “хулхи нь буух”(омог нь буурах, урам нь хугарах), “хулхин дээр нь цэцэг ургуулах”(наанаа гоё сайхан үг хэлээд далдуур хууран мэхлэх), “хулгар”(хүн амьтны чих хэвийн хэмжээнээс бага байх), “хулмайх”(мал адгуусны чихээ гэдрэг болгох) гэх мэт олон хэлц хэллэгээс гол цөм утга нь “чих” болохыг мэдэж болно. Түрэг хэлэнд “kulak”(чих) хэлбэрээр идэвхтэй хэрэглэгдэж байна.

Монгол хэлний үгийн сан дахь аялга үгийн утга, хэрэглээний онцлогийг ажиглан үзвэл ихээхэн өвөрмөц шинжтэй байдаг. Тухайлбал, Монголчуудын мал аж ахуйтай холбоотой аялга үгсийн дотор тэмээг хэвтүүлэхдээ хэлдэг “sög sög”(сөг сөг) хэмээх үг бий. Энэ язгуураас sögüd(хоёр хөлийг бохирч, өвдгөө газарт хүргэх, сөхрөх)(Я.Цэвэл, 2013: тал.667), sökür(өвдөг нугалан бохирох, сөхөрч мөргөх)(Я.Цэвэл, 2013: тал.670) гэх мэт үйл үг үүсчээ. Анхдагч “sög; sök”язгуурын утгыг бид төрөл хэлний баримтаас тодруулах боломжтой. Жишээ нь, руни бичгийн сонгодог томоохон дурсгалуудад “*bašligig yükiüntürtüm, tizligig sökürtüm*”(толгойтныг бөхийлгөв, тойгтныг сөхрүүлэв, би) гэсэн өгүүлэмж хэдэнтээ тохиолдоно. Энд буй “sökürtüm” гэх үгийг бүтцээр задлан үзвэл sök-(сөхрөх үйл язгуур) +r(үйлдүүлэх хэвийн бүтээвэр) +tü(өнгөрсөн цагийн нөхцөл) +m(эзэн биед хамаатуулах нөхцөл) болно. Харин орчин цагийн түрэг бичгийн хэлний хэрэглээнд “çök-”хэлбэрээр тохиолдож байна. Ийн үзвэл монгол хэлний “sög sög” аялга үг нь “сөгд сөгд” гэсэн утгатай бие даасан үйл үг байсан бөгөөд хэлний түүхэн хөгжлийн явцад хэрэглээний хувьд явцуу болжээ. Өөрөөр хэлбэл тэмээ малыг хэвтүүлэхэд хэрэглэхээс бус хүний “өвдөг нугалан сөгдөх, сөхрөх”-ийг илэрхийлэхгүй юм.

Үгийн гол цөм утга нь мал аж ахуйтай холбогдох аялга үгэнд хадгалагдан үлдсэн нь ихээхэн сонирхолтой хийгээд анхааран үзэх баримт мөн билээ.

Монгол хэлний “ай хөөрхий, ай халаг, ай зайлуул, ай даа” гэх мэт зэмлэх, буруушаах, халаглах, баярлах, өрөвдөх, энэрэх хүний сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлэх үгийн бүрэлдэхүүнд байх “ай” аялга үгийн утга, хэрэглээний онцлог шинж мөн адил бидний анхаарлыг татаж байна. Энэхүү язгуураас “айлд-”(Хүндэтгэвэл зохих хүнд үг хэлэх, өгүүлэх, соёрхон айлдах) болон “айлтга-”(Дээд хүмүүст үг хэлэх, албан бичиг өргөх, биеэр саналаа илтгэх, учир явдлаа мэдүүлэх) гэх мэт үйл үг үүсчээ. Хүндэтгэх утгаар найруулгын дээд түвшинд голлон хэрэглэгдэж буй энэхүү үгийн утга нь эртний түрэг хэлний баримтаар илүү тодорхой болж байна. “ау-”(ярих, ярилцах) ба “ауит-”(зөвших, зөвлөх) хэлбэрээр хэрэглэгдэж байсан энэхүү үг монгол хэлнээ “ярих, өгүүлэх”-ийн хүндэтгэл утгатай болж анхны язгуур нь аялга үгийн бүтцэд хадгалагдан үлдсэн байна.

2. Хэлзүйн түвшинд утга өөрчлөгдөх нь:

Нэг хэлэнд үгийн сангийн түвшинд илрэх утга нөгөө хэлэнд хэлзүйн бүтээврээр илэрч болно. Энэ зүй тогтол хэлний түүхэн хөгжлийн явцад нэг хэлэнд ч мөн үүсч болох юм. Үүнд төрөл хэлүүдийн харьцуулсан судалгаа чухал баримт болж чадна.

Монгол хэлэнд дээрх мэт онцлог байдлаар илэрдэг утга бол үйл үгийн нийлмэл бүтэц мөн билээ. Өөрөөр хэлбэл үүнд уламжлалт нэршлээр туслах үйл үгийн утгыг авч үзэх хэрэгтэй.

Монгол хэлний үйл үгийн одоо цаг энэ мэт үйл нийлэмжээр илэрдэг. Аливаа нэг мэдээллийг дамжуулж буй цаг нь үйл хэрэгжих цагтай давхцаж байвал одоо цаг хэмээн үздэг. Орчин цагийн Монгол хийгээд түрэг хэлний үйлүгийн одоо цагийн хэлбэрийг харьцуулан үзүүлье.

Монгол хэлний үйл үгийн одоо цаг:

Үйл үг + ж+ байна

Түрэг хэлний үйл үгийн одоо цаг:

Үйл үг +уог

(Үйл нийлэмжээр илэрч байна)(Тусгай бүтээврээр илэрч байна)

Орчин цагийн түрэг хэлний одоо цаг заах хамгийн түгээмэл хэрэглэгддэг нөхцөл бол –*yor*бүтээвр юм. Эртний түрэг хэлний уог- буюу “явах” гэсэн үйл үг өгүүлбэрт гол үйл үгтээ туслах үүргээр орж үйлийн үргэлжлэх байдлын утга илтгэж байсан бөгөөд энэхүү үйл нийлэмж хэлний хэмнэлийн үр дүнд бүтцийн хувьд нэг болж арын туслах үйл үг нь өнөөгийн –уог гэсэн бүтээврийг үүсгэжээ. Жишээ нь, *başla-u-yog*;-*başlıyog*(эхэлж явах буюу эхэлж байна) болно. Өнөө энэхүү бүтээврийг бүх үйл үгэнд чанга хөндий ялгахгүй залгаж болдог. Цаг заах төлөвийн бусад нөхцөлүүд цөм чанга, хөндий, уруулын, уруулын бус шинжээс хамааран тус бүр дөрвөн хувилбартай байгаа бол –уог гэх нөхцөл ганц хэлбэрээр тохиолдож байгаа нь дээр тайлбарласанчлан туслах үйл үгээс үүссэнтэй холбоотой.

Профессор З.Коркмаз түрэг хэлний бүрэн хэлзүйн номдоо орчин цагийн түрэг хэлний одоо цаг заах “-уог” бүтээвр нь эртний түрэг хэлний “*al-a*(авч) уог(яв- гэх туслах үйл үг)-г(“*geniş zaman*” буюу давтагдах цагийн нөхцөл)” гэсэн хэлбэрээс хэлний үе хэмнэх зарчимын дагуу *al-a yori-r*(авч явдаг) гэдэг нь *al-i-yor*(авч байна) гэсэн одоо цагийн хэлбэртэй болсоныг тэмдэглэжээ(Korkmaz, 2003: s.611). Түркийн эрдэмтэн Ахмет Карадоган “-уог”нөхцөлийг үйл үгийн үргэлжлэх байдлын утгыг хэлзүйн төвшинд илрүүлдэг(Ahmet Karadoğan, 2009: s.29-31) хэмээн үзсэн нь утгаа дээрхи тайлбартай тохирч байгаа юм.

Түрэг хэлний уог-(яв-) хэмээх үйл үг бичгийн дурсгалууд хийгээд орчин цагийн түрэг хэлэнд гадаад хэлбэр болон илтгэх утгын хувьд ихээхэн өвөрмөц байгаа билээ.

Эртний түрэг хэлний толь бичигт энэхүү үгийг дараах мэт утгатай болохыг тэмдэглэжээ. Үүнд, 1. явах, хөдлөх, зайлах, 2. орох, 3. байх, орших гэх мэт болно (В.М.Наделяев., 1969: стр. 274).

“уог-”хэмээх үйл үг өгүүлбэрт гол үйл үгийн үүргээр тохиолдохоос гадна туслах үүргээр орж үйлийн үргэлжлэн хэрэгжсэнийг илтгэж байжээ. Жишээ нь,

Көлтигиний бичээсийн өмнө талын 9-р мөрөнд,

галиг: *anta qalmış yir sayu toruölü yoriyur erteg.*

орчуулга: *Тийн үлдсэн нь газар бүр үхэн хатаж явж(байсан) бөлгөө.*

Дээрхи үйл нийлэмж нь хэлний түүхэн хөгжлийн явцад нэгдэн нийлж туслах үүрэгтэй орсон “уог-” үйл үг үгийн сангийн утгаа зарим талаар алдаж зөвхөн үйлийн байдлын айн утга илтгэх үүргээ хадгалан үлдсэнээр үргэлжлэх утга илэрхийлсэн бүтээвэр болж хувирсан байна. Эдгээр жишээ баримтаас үзэхэд монгол түрэг хоёр хэлэнд үйлийн үргэлжилж буй одоо цагийг илэрхийлэх хэлбэр нь туслах үйл үг бүхий нийлэмж байгаад түүхэн хөгжлийн явцад түрэг хэлэнд энэхүүтуслах үүрэгтэй орсон үйл үг нь бие даасан бүтээвэр болж хувирсан байна. Харин монгол хэлэнд хэвээр хадгалагдан үлджээ.

Зарим түрэг төрөл хэлэнд тухайлбал, тува, тофалар мэт хэлэнд үйлийн төгс байдлын утгыг –авыт(-ivit, -увыт, увут) дагавраар илрүүлдэг болохыг тэмдэглэжээ(В.И.Рассадин, 1978: стр.149;Ф.Г.Искаков, А.А.Пальмбах, 1961: стр.410). Жишээ нь:

тоф. *Булут айны дуглавыткан. (Үүл сарыг халхалчихав)*

Мен аьтымын тургузувыттым. (Би морио аль хэдийн унасан)

Мен алзывыттым. (Би хожигдчихлоо)

Энэхүү “-ывыт-” төгс байдлын утгатай бүтээвэр нь “ыг-” буюу “явуулах, илгээх” гэх утгатай үйл үгээс үүсэлтэй ажээ. Өөрөөр хэлбэл өгүүлбэрт туслах үүргээр орж төгсөх байдлын утга илэрхийлсэн “ыг-” гэх үйл үг нь өмнөх гол үйл үгийн нөхцөл үйл үгийн хэлбэртэй нэгдэн дээрх “-ывыт-” дагавар үүссэн байна. Эртний түрэг хэлэнд “явуулах” гэсэн үгийн сангийн утгатай “id-”гэх үйл үг туслах үйл үгийн үүргээр хэрэглэгдэж байсан баримт буй.

Көлтигиний бичээсийн зүүн талын 6-р мөрөнд,

галиг: *türük bodun illedük ilin içünü idmiş qayanladuq qayanın yitirü idmiş*

орчуулга: *Түрэг түмэн улс болгосон улсаа алдан явуулав, хаан болгосон хаанаа хаяж явуулав.*

утгачилсан орчуулга: *Түрэг түмэн байгуулсан улсаа алдаж орхив, өргөмжилсөн хаанаа хаяж орхив.*

Энэ мэт хэлзүйн утга илэрхийлж байсан туслах үйл үгс өөрийн бие даасан үгийн сангийн утгаа алдаж тусгай бүтээвэр, нөхцөл болж өөрчлөгдөх нь үгийн утгын өөрчлөлттэй холбоотой байна. Үүнийг бид төрөл хэлүүд болон аман аялгууны баримттай харьцуулан авч үзэх хэрэгтэй.

Бид энэхүү өгүүлэлдээ монгол хэлний үгийн утгын өөрчлөлт, хэлний хэрэглээн дэх өвөрмөц онцлогийг аман аялгуу болон бусад төрөл хэлүүдийн жишээ баримттай харьцуулан судалж анхдагч, гол утгыг тодруулан гаргахыг зорьсон болно. Нэг үгийн олон утга, түүний өөрчлөгдөх зүй тогтлыг судлан шинжлэхэд төрөл хэлний харьцуулсан судалгаа чухал баримт болохыг тэмдэглэе.

Ашигласан ном, эх хэрэглэгдэхүүн

Латин үсгээрхи:

Ahmet Karadoğan, Türkiye türkçesinde kılınış, Ankara, 2009.

Çenggeltei, Odu üy-e-yin mongyul kelen-ü jüi, ÖMAKQ, Köke qota, 1992.

Doğan Aksan, Anlam bilim- Anlambilim konuları ve Türkçenin anlambilimi, Ankara, 2005.

Nurettin Koç, Dilbilgisi terimleri sözlüğü, İstanbul, 1992.

Talat Tekin, Orhon yazıtları, Kültigin, Bilge Kağan, Tunyukuk, Istanbul, 2003.

Tahsin Banguoğlu, Türkçenin grameri, TDK, Ankara, 2004.

Türkçe sözlük, TDK, Ankara, 2005.

Zeynep Korkmaz, Türkiye türkçesi grameri, TDK, Ankara, 2003.

Кирилл үсгээрхи:

Бадамдорж Д. Монгол хэлний үгийн сангийн утгазүй, Улаанбаатар, 2006.

Искаков Ф.Г., Пальмбах А.А., Грамматика тувинского языка, Фонетика и морфология, Москва, 1961.

Наделяев В.М., Древнетюркский словарь, Л., 1969.

Рассадин В.И., Морфология тофаларского языка в сравнительном освещении, Москва, 1978.

Сун Бёнгү, Орчин цагийн монгол хэлний туслах үйл үгийн судалгаа, -Нэг сэдэвт зохиол, Улаанбаатар, 2011.

Төмөрцэрэн Ж, Монгол хэлний үгийн сан судлал, Улаанбаатар, 2001.

Цэвэл Я, Монгол хэлний товч тайлбар толь, Нэмж дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2013.

논 문 투 고 일 : 2018년 10월 30일
논 문 심 사 일 : 2018년 11월 15일
논문게재결정일 : 2018년 11월 30일

Буриад үндэсний эмэгтэй дээлийн бүрдэлийн нэр*

Бальжинимаева Б.Д.**

Abstract

Terms for parts of Women's Garment in Buryat

Balzhinimaeva B.D.**

Vivid expression of ethnic characteristics is the national dress. Buryat national clothing as a part of Buryats' material culture has centuries-old traditions, reflects climatic conditions and type of household activities. The description of the Mongolian national clothing, including the Buryats, is found in works of Johann de Plano Carpini, Wilhelm de Rubruk, as well as in the notes of some participants of the 18th century Siberian academic expedition, such as P.S. Pallas, I.G. Georgi, I. Tatarinov. The lexemes denoting the types of national clothing and its details are formed in various ways of word production. Also in the studied vocabulary layer, a linguistic phenomenon of transferring meaning is common.

Keywords : material culture, national clothing, buryat language, lexic

Буриад үндэстэн бид буриадууд гэж харуулах онц зүйлнүүдийн нэг нь үндэсний буриад хувцас юм. Эрт цагаас хойш монгол туургатан хувцсаар бие биеэ таньж, аль үндэсний, хэн болох вэ мэдэлцдэг байсан.

Буриадууд нэн эрт цагаас нүүдлийн мал аж ахуйг эрхлэн, Төв Азийн эрс тэс уур амьсгалтай удам нутагт нүүдэллэн аж төрсөөр ирсэн. Тэдний эрхэлсэн мал аж ахуй, оршин суусан нутгийн байгаль, цаг уурын нөхцөл нь өөрсдийн хэрэгцээ шаардлагад тохирсон үндэсний хувцсаа бүтээсэн юм.

Эмэгтэйчүүдийн хувцас бол уламжлалт соёлоо хадгалах гоёл чимэг илүүтэй байх

* Исследование выполнено при финансовой поддержке РФФИ в рамках научного проекта № 16-24-03001-ОГН

** Бурятский государственный университет / bairka2002@list.ru
(Buryat State University)

онцлогтой бөгөөд бүс нутгийн өвөрмөц хийц загвар гоёлтой байдгаараа эрэгтэйчүүдийн хувцаснаас өвөрмөц байна.

Буриад үндэсний хувцасны талаар Л. Линховоины «Заметки о дореволюционном быте агинских бурят» [1972], Р. Д. Бадмаевагийн «Бурятский женский костюм» [1987, 2016], Ц. Б. Базаровагийн «Национальная одежда агинских бурят: лексико-семантический аспект» [2003], М. Б. Дагдановагийн «Традиционный женский костюм западных бурят: дифференцирующие функции» [2005], А. А. Бадмаевын «Женская одежда у бурят во второй половине XIX – начале XX века» [2012], «Бурятский традиционный костюм» [2017] судалсан эрдэм шинжилгээний ажил, бүтээлүүдийг бичсэнийг онцолж байна.

Буриад хувцас шинжилсэн бүтээлүүдийг харж үзэхэд, газар газрын буриадуудын хувцас нь бага зэрэг ялгаатай. Жишээлэхэд, баруун буриадуудын эхнэр дээл хори буриадуудын эхнэр дээлээс юугаар ондоо гэхэд ханцуй нь олон хэсгээс бүрдэхгүй, цээж нь хормойн залгаагаараа гоёлгүй, харин энгэр хормой хоёр нь олон давхар хөвөөтэй. Баруун буриадуудын энгэрийн гоёолт хори буриадуудын охин бүсгүйчүүдийн ба эрэгтэй хүний дээлтэй адил мөртлөө торго, хилэн хөвөөгийн хажуугаар энгэр нь халиуны арьсаар гоёогдсон байлаа. Баруун буриадуудын эхнэр дээлийн хилэн хөвөө нь *тяаза*, торго хөвөө нь *хүдхан* эсвэл *гизгэ* гэж нэртэй байсан. Бас үүний талаар буриад хувцас шинжилсэн Р.Д. Бадмаевагийн номд ингэж бичигдсэн байдаг: «При общей основе одежды замужних женщин некоторые детали покроя и декора выделяли ее локальные своеобразия, которые особенно четко проявляются при сравнительном изучении одежды разных групп бурят» [Бадмаева 1987: 62 х.]. Газар газрын буриадуудын хувцсанд хамаатай үгнүүд адил гэвч бага зэргийн ялгаатай, заримдаа өөр өөр юмыг тэмдэглэсэн байж болдог.

13-14 наснаас аваад хадамд мордох хүртлээ охид бүсгүйчүүдийн өмсдөг гадуур хувцас *басаган дэгэл* гэж нэрлэнэ. Охид бүсгүйчүүдийн дээл нь бусад дээлтэй төстэй мөртлөө өөрийн онц гоёлтнуудтай юм. Энгэр хурц омогтой, гурвалсан эмжээртэй тэрхүү эмжээрийн дээд хэсэг нь хөх ногоон өнгийн эд үүнийхээ удаа хар хилэнгээр мөн удаанд нь улаан өнгийн бөсөөр өнгө хослуулан эмжих онцлогтой. Дээл тэрлэгний энгэрийн эмжээр гоёлоо дээд, дунд, доод тэнгэр хэмээн эрхэмлэдэг. Охид бүсгүйчүүдийн дээлийн бүслүүрээр *татаахан* гэж нэрлэдэг улаан, шар, ногоон гурван өнгийн эд барьж оёсон байдаг бөгөөд ар, өвөр хоёр талдаа бий.

Энэ нь зөвхөн урд талд биш тойроод оёсон байдаг юм. Ийм эртний ёс заншлаар охид бүсгүйчүүдийн дээлийн оёлгыг Шинэхээн нутгийн буриадууд одоо хүртэл авч явж байна. Одоо охид бүсгүйчүүдийн дээл нь бага зэрэг өөр болсон гэж тэмдэглэмээр байна.

Буриад эхнэр дээл нь (*хамган дэгэл*) охид бүсгүйчүүдийн дээлнээс ялгаатай. Буриад

эхнэр хувцасны өнгө тод, гоёл чимэг харьцангуй их. Буриад эхнэрийн дээлийн ард хормой, цээж биеийн хямд зүйлээр, харин урд хормойг торго магнагаар хийдэг байжээ. Нэрт буриад угсаатан зүйч Лодон Линховоин үүний тухай бичихдээ буриад зүйр үг хүргэсэн байна: «Гэрэй гоё арадаа, гэргэдэй гоё урдаа» [Линховоин 1972: 28 х].

Буриад эхнэрийн дээл нь зах, энгэр, өр, өвөр, цээж, хормой зэрэг найман хэсгээс нийлэн бүтдэг. Дээлийн босоо захыг эргэн тойрон тууз, хоргой, хар хилэнгээр нарийн хөвөөлж эмждэг (*захын хүбөө*).

Захыг халиуны арьсаар буюу сэгсүүргээр чимэглэдэг байв (*захын үнгэсэ*).

Одоо босоо зах хийдэггүй, дөрвөлжин маягийн зах хийдэг (*нэхэмэл зах*).

Охид бүсгүйчүүдийн болон эхнэр дээлийн цээжний доод захыг хөвөөлсөн нарийн хөвөөг бол *мүихөөһэн* гэдэг. Дээлийн цээж хормой хоёрын залгаагаар хуниас (*хуняаһан*, шинэхээн буриад *эбхэмэл хуняаһан*) гарган оёдог (*хуняаһа хунаха*). Эхнэр дээлийн зөвхөн урд энгэрт байдаг залгаас дээр нь гурван хурга тухай өргөнтэй улаан ногоон юм уу, шар ногоон хоёр утас ойр ойрхон оёсон гоёолт бол *татааһан*. Урд нь татаасыг өөрсдөө нэхэдэг байсан учраас ийм буриад оньсого байсан: «Жалгыё уруу жаран гүрөөһэн гүйбэ, Жарантайн һамган мунсаа баряад гүйбэ». Дээлийн заханд нэг, энгэрт хоёр, суганд нэг товч хадна.

Эхнэр дээлийн ханцуй нь мөрөөрөө залгаа, хэдэн хэсгээс бүрдсэн байна. Энэ нь *хамсын үзүүр*, *булуубиша*, *тохоног*. *Хамсын үзүүр* бол цээжид залгагдадаг, залгагдахад хормой хуниасанд адил нэг төө урттай. Дараа нь гурван хуруу тухай өргөнтэй хоргойгоор хийсэн гоёлыг *булуубиша* гэдэг. Булуубишийг хоргой сөөлжүүлж эсгээд, дээд захыг нь ханцуйн үзүүрт оёж бэхлээд, доод захыг нь утсан тасмаар даруулдаг байна. Дараа нь тохоногоос царвуу хүртэл хэсгийг *тохоног/тохой* гэдэг. Торго нь эрээн юм уу, өөр өнгөтэй гоё торгоор оёдог байсан. Тохногийн доод үзүүрт утастай (*хамсын хүбөө*). Эхнэр дээл заавал нударгатай байна (*туруу/нударга*). Дээлний нударга нь хүндэтгэл, бэлгэдэл, гоёлын учир утгатай байхаас гадна гарыг хамгаалах үүрэгтэй.

Эмэгтэйчүүд дээлнээсээ бага зэрэг богино ууж өмсөх бөгөөд түүнийг төрийн өмсгөл гэж хүндэлнэ. Ууж нь хормойтой ба цээж гэж хоёр янзын байдаг. Богино цээживч нь товчгүй боловч дээд хэсэгтээ туузан уяатай (*богони уужа/оодон уужа/сээжэбиэ*). Уужны урт нь дээлийн ургаас хоёр хуруу богино болох ба хормойтой ууж нь ар цээжийн татааснаас доош оноотой нь туузаар эмжсэн байдаг (хори буриад *морин уужа*, *хормойтой уужа*, эхирид буриад *дэглээ/дэглэй дабхаса*). Аларь, унгиин, бохан буриадууд цээж хормой хоёрын залгаагүй уужийг *хубайси* гэдэг. Гоёлын хубайси дээр мөнгөн зоос (*хадалга*) ба эржин товч хаддаг. Хормойтой уужийг эмэгтэйчүүд баяр ёслолын үеэр, цээж

уужийг гэр зуур, хөдөлмөр хийхдээ өмсдөг. Ууж нь ар нурууны хуниаснаас доош задгай оноотой, энгэр шулуун байна. Уужны энгэр, ар оноог туузаар эмжинэ.

Тэрлэг зуны цагт өмсдөг. Оёгдсон эдийн нэрээр зуны дээлнүүдийг нэрлэдэг байсан юм: *шэришүү тэрлиг* «летний халат из чесучи», *түхэрезэн хээтэй торгон тэрлиг* «шелковый халат с круглым узорчатым рисунком», *магнал тэрлиг* «летний халат, сшитый из шелка с рисунком дракона, вышитый золотистыми и серебристыми нитями», *буха магнал тэрлиг* «плотный шелковый халат», *хамба торгон тэрлиг* «летний халат из китайского шелка с узорчатым круглым рисунком», *даалин тэрлиг* «халат из далембы». Судлаачдын бичвэрээс тэрлэг хийх бөс эдийн төрөл хоорондын ялгаанаас хамаарч тэрлэг эсгэх найман арга байна. Эдгээр аргуудыг шинжлэн судалж олны хүртээл болгох нь чухал юм [Эрдэнэчимэг 2016: 10х.]. Тэрлэгийг сайтар бодож, нягт нямбай эсгэдэг тул үйлчид тэрлэг эсгэсний дараа өөдөс бараг үлдэхгүй, эгэл атлаа нарийн эсгүүр хийцтэй байдаг нь ихэд гайхамшигтай юм.

Хар хилэн буюу халиу булганы арьсаар тойруулсан сэвсэг хүрээтэй, хөх торгон шовгор оройтой, улаан утсан цацаг залаатай, хээ угалз сийлсэн шүрэв мөнгөн дэнзтэй малгай бол *тооробишо/тойробишо малгай*. Эмэгтэйчүүд даруулга хэмээх хув шүрэн зүүлтээр сэвсгийг нь чимэж өмсдөг. *Юүдэн малгайг* цэмбээр урладаг бөгөөд сэрүүн улиралд өмсдөг. *Шэгэбишэтай малгай/хасабишатай малгай* бол хурганы арьсаар доторлосон хоёр урт чихэвчтэй шовгор өвлийн малгай. Г. Гантогтох бичихдээ: «Сагаалганаар буриад зон золгохдоо хасабша малгайгаа сушандаа хавчуулаад хоёр гараа сунгаж мэхийж золгодог заншилтай» [Гантогтох 2005: 146 х].

Буриадууд гутлыг (*эрмэгтэй гутал*) зулгыг *сараг*, хавчаарыг *зулаг*, улыг *эрмэг* гэж нэрлэдэг. Гутлын улыг ахарын эсгийгээр хийнэ. Зулагтай улаан ногоон өнгийн утас (*хабишаахан*) барьж оёод зуузайн хэсэгт угалз тавина. Зуны улиралд булигаар, өвөлд арьс нэхийгээр хийсэн гутал өмсөнө.

Үндэсний дээл, тэрлэг өмсөх ёс заншил эрт үеэс уламжилсан байдаг. Эсгэсэн бөс эдээ газар тавилгүй аль болохоор хурдан оёж дуусгахыг хичээнэ. Оёж дуустлаа бөс эдээс үлдсэн өөдсийг хаялгүй хадгалж байгаад бага зэрэг бурханыг мялааж баярлуулдаг заншил бий. Энэ нь галын бурханд мөн адил торгон тэрлэг хийж өгч байна гэсэн сана агуулдаг байна. Тэрлэг эсгэхэд гарсан өөдсийг «үйл бүт» гэж хэлээд галд өргөнө. Харин тэрлэгээ оёж дуусахаас өмнө эсгүүрээс үлдсэн өөдөс даавуугаа хаявал үйл бүтэлгүйтнэ гэнэ.

Даяаршлын эрин үед оршин тогтнож байсан цагт хувцас маань элбэг болсон үе цагт биед зохид, тааруу, хөнгөн хувцсыг өмсдөг болсон. Орчин үед үндэсний хувцасны зарим хэсгийг хүн ард нийтлэн хэрэглэхээ больсон ч зарим газарт, жэшээ нь, Агын буриадууд,

Шинэхээн нутгийн буриадууд хуримд, цагаан сар болон баярын үед (Алтаргана наадам, Ёохор бүжгийн наадам) үндэсний хувцасаа өмсдөг гэж тэмдэглэмээр байна.

Одоо буриад дээлээ урлах ухааныг авч үлдэх түүнийгээ дараа үедээ дамжуулан өвлүүлэх хэрэгтэй гэдэгт эрмэлзэлгүй зорилго юм. Энэхүү оёдлын нэр томьёонд мэргэжлийн бус хүнд мэдэгдэхгүй шахам болсон үгс, үгийн сангийн хэрэгцээнээс шахагдан гарч идэвхгүй үгийн нөөцөд орсон үгс тохиолддог учир энэ ажил маань оюутан судлаач хэн бүхэнд сонирхолтой байх болно гэж итгэж байна.

Ашигласан ном:

1. Бадмаева Р. Д. Бурятский народный костюм. - Улан-Удэ, 1987. - 141 с.
2. Базарова Ц. Б. Национальная одежда агинских бурят: лексико-семантический аспект. - Улан-Удэ: Издательство Бурятского госуниверситета, 2003. - 114 с.
3. Бальжинимаева Б. Д. Некоторые особенности терминов швейного производства шэнэхэнских и агинских бурят // Проблемы исторического развития монгольских языков. – Спб., 2007.- С. 12-15.
4. Бальжинимаева Ц. Ц. Терминология швейного производства у бурят // Этнокультурная лексика монгольских языков. – Улан-Удэ, 1994. – с. 127-132.
5. Г. Гантогтох. Дашбалбар. Дашбалбарайнхин. – Улаанбаатар, 2005 он.
6. Линховоин Л. Л. Заметки о дореволюционном быте агинских бурят. - Улан-Удэ, 1972. - 102 с.
7. Монгол улсын угсаатны зүй. – III боть. – Улаанбаатар, 2012 он.
8. О. Эрдэнэчимэг. Монгол тэрлэг эсгэх аргад хийсэн судалгааны дүн // Proceedings of the Mongolian Academy of Sciences. - Vol. 56 No 02 (218). – 2016. – 5-16 х.

нон монтгойл: 2018н 10л 30л
нон монтсйл: 2018н 11л 15л
нонмонтгеллйл: 2018н 11л 30л

Исторические нарративы бурят: семантика, структура, особенности языка

Лариса Батоевна Бадмаева *

Abstract

The Historical Narratives of the Buryats: semantics, structure, peculiarities of the language

Larisa Batoevna Badmaeva *

The article is devoted to consideration the historical narratives of the Buryats of the XIX century, written by buryat authors in the Old Mongolian Script. In these Annals presents the history of the Buryats from the earliest times to the beginning of the XXth century. There are more than 40 handwritten historical chronicles. The structure of the texts of the chronicles is logical and consistent. The subject of the texts is multifaceted and meaningful. The tradition of the Buryat chronicle continued in the beginning of the XXth century. There are continuations of the chronicle of Sh.-N. Khobituev, written by different authors.

Keywords : the historical narratives, the Buryat Annals, the monuments of the written culture of the Buryats, the Old Mongolian Script, the Buryat annalists

В последние годы в Бурятии все большую актуальность приобретает введение в научный оборот бурятских исторических нарративов или летописей.

Как известно, *нарратив* – самостоятельно созданное повествование о некотором множестве взаимосвязанных событий, представленное читателю или слушателю в виде последовательности слов или образов. Часть значений термина «нарратив» совпадает с общеупотребительными словами *повествование, рассказ*¹⁾.

* Институт монголоведения, буддологии и тибетологии СО РАН, Улан-Удэ / lorabadm@mail.ru
(The Institute for Mongolian, Buddhist and Tibetan Studies of the Siberian Branch of the Russian Academy of Sciences, Ulan-Ude)

1) Источник: *narrative* - <https://ru.wikipedia.org>

Историческая информация становится все более популярной у читателей, вытесняя увлечения представлениями массовой культуры и детективами. Историческая память — необходимая категория для развития самосознания и самопознания народа, фактор его самообогащения. Забвение исторической памяти особенно пагубно для подрастающего поколения.

Бурятские исторические нарративы или летописи на монгольском письме стали появляться в XVIII в. в связи с консолидацией бурят в самостоятельную народность. Среди старописьменных памятников бурят они занимают исключительно важное место. Летописи являются не только ценными источниками исторической и культурологической информации, содержащими богатый материал по истории, быту, традиционной культуре и верованиям бурят, живущих в Байкальском регионе, но и значимыми памятниками письменной культуры бурят.

Летописи пользовались большой популярностью среди бурятских читателей, имели хождение исключительно в рукописях, которые распространялись подвижниками-библиофилами бурятских степей. Бурятские летописи не похожи на европейские или русские летописи, даже на собственно монгольские. Характерной особенностью бурятских нарративов является их синкретизм, смешение исторического и литературного жанров, стилей. Бурятские авторы излагают наиболее важные события, происходившие в жизни тех или иных родов и племен. Вместе с тем в них, в отличие от монгольских летописей, содержится большое количество этнографических, хозяйственных, религиозных сведений.

До революции публиковались лишь отдельные бурятские летописи: в 1869 г. в «Иркутских губернских ведомостях» был издан труд Н. Ц.-Ж. Сахарова «Об инородцах, обитающих в Баргузинском округе Забайкальской области», в 1900 г. А. М. Позднеев в своей «Монгольской хрестоматии» опубликовал «Предание о Бальжин-хатуне», в 1905 г. вышел в свет труд Агвана Доржиева о происхождении бурят.

Широкое изучение и издание бурятских летописей началось в 1930-х гг. в Институте востоковедения АН СССР благодаря усилиям монголистов Н. Н. Поппе, А. И. Вострикова, В. А. Казакевича, Т. А. Бурдуковой. В 1935 г. в Ленинграде были изданы на монгольском письме «Летопись баргузинских бурят» (11); летописи хоринских бурят Тулгултура Тобоева, Вандана Юмсунова (13), Шираб-Нимбо Хобитуева (15), в 1936 г. — «История селенгинских монголо-бурят» Дамби-Жалцан Ломбоцыренова (12). В 1940 г. Н. Н. Поппе выпустил в переводе на русский язык «Летописи хоринских бурят», куда вошли летописи Т. Тобоева и В. Юмсунова (14).

После войны некоторые баргузинские летописи были изданы Г. Н. Румянцевым (18),

селенгинские – 3. Т. Тагаровым (19).

В послевоенные годы началось изучение языка бурятских летописей бурятоведами Д. Д. Доржиевым (10), Ц. Б. Цыдендамбаевым (20). Благодаря инициативе Ш. Б. Чимитдоржиева в 1992 г. были изданы 9 бурятских летописей в переложении на современный бурятский язык (24). К этой работе были привлечены ученые Ж. С. Сажин, Д. Д. Доржиев, Р. Е. Пубаев, Ц.-А. Н. Дугарнимаев, Г. О. Туденов, Л. Д. Шагдаров, Б. З. Базарова, Г. Н. Очирова, Ц. П. Ванчикова, Х. Ж. Гармаева, Л. Б. Бадмаева.

В 1995 г. на русском языке было опубликовано 9 летописей в книге «Бурятские летописи» (составители Ш. Б. Чимитдоржиев, Ц. П. Ванчикова) (6). В 2011 г. эта работа была переиздана с добавлением 8 письменных памятников, переведенных Ц. П. Ванчиковой и М. В. Аюшеевой (7).

В 2001 г. Г. Н. Очирова переложила на современный бурятский язык и опубликовала в журнале «Морин хуур» «Ацагатский очерк о хори-бурятах» (*‘Хори буряадууд тухай Асагата бэшэгдээн тобио түүхэ’*) (16).

Среди летописных произведений также следует особо выделить и другие исторические сочинения, популярные среди народа: “Бишыхан запискэ” / *“Bičiqan qayudasu”* (1832), летопись Сайнцак Юмова (1887), летопись Цыдэб-Жаба Сахарова (1879), “Ацагатский очерк о хори-бурятах” (1917), летописи Цэжэб Цэрэнова (1908, 1917) и др.

Следует отметить, что точных сведений о количестве бурятских исторических нарративов и об их авторах пока еще не установлено, поскольку их рукописи находятся в различных архивных фондах Улан-Удэ, Иркутска, Читы, Томска, Москвы, Санкт-Петербурга, Улан-Батора, Хухэ-Хото, Пекина, а также в частных коллекциях (Бадмаева 2012: 22).

В настоящее время выявлено около 40 больших и малых бурятских летописей, из них опубликовано на современном бурятском языке 20 хроник, переведено на русский язык и опубликовано 11 летописей, на английском языке – 1 хроника, на старописьменном монгольском языке опубликовано – 9 летописей (Бадмаева 2005: 8). Изданные бурятские хроники составляют лишь некоторую часть летописного наследия бурят, а большая их часть все еще остается в рукописях.

Учитывая значимость летописных текстов в изучении письменной культуры бурят, переизданы летописи Вандана Юмсунова (2), Цыдэб-Жаба Сахарова (8), Д.-Ж. Ломбоцыренова (21), Ш.-Н. Хобитуева (4) с транслитерацией и в сопровождении исследований языковых особенностей памятников.

Бурятские исторические хроники, являясь составной частью культурного наследия

бурят, отражают многие стороны их общественной жизни, поэтому они заслуживают специального изучения. В эпоху тоталитарного режима данные памятники историографии Бурятии XVII-XIX вв., как и все литературное наследие бурят на старомонгольской письменности, долгое время находились в забвении, отодвинутые на задний план, более того, многие ценные памятники были варварски уничтожены.

Как отмечает исследователь бурятской дидактической литературы Д. Б. Дашиев: “После революции в ходе борьбы, с так называемым, буржуазным национализмом и панмонголизмом вся эта литература (на монгольском письме – *Л. Б.*) была объявлена антинародной и изъята из обращения. Смена письменности в последующие годы привела почти к полному забвению, как авторов, так и самих памятников” (Дашиев 1997: 3).

Бурятские исторические сочинения писались по образцу монгольских летописей, но в отличие от них бурятские летописи написаны на основании подлинных документов степных дум. Более того, при ссылке на документы указываются даты и номера соответствующих распоряжений властей, что придает им более достоверный очерковый характер. Например, в хрониках широко использованы деловые документы, ранее написанные летописные работы, устные легенды и предания бурят. Все это придавало летописям характер научного очерка.

В целом, структура исторических нарративов достаточно логична и последовательна. Повествование ведется в соответствии с историческими событиями, происходившими в жизни бурят. Их тематика многопланова и содержательна. В частности, Ш.-Н. Хобитуев подробно излагает по существу те же вопросы, что и В. Юмсунов, но в отличие от него он располагает события в хронологической последовательности, например, распространение буддизма среди селенгинских и хоринских бурят; сведения о развитии хозяйственной деятельности разбросаны по датам. Хронологически последовательно описаны события о выделении хоринскими бурятами 105 тысяч десятин земли по Ингоде русским переселенцам из Кавказа, а также отделение агинских бурят от хоринских и т. д.

Байкальский регион с древности представлял зону этнокультурных связей народов Центральной Азии, Западной и Восточной Сибири, что повлияло на формирование особой культуры открытого типа, способной к культурным инновациям, терпимой к иноэтническому присутствию.

Вхождение Бурятии в состав Российского государства было поворотным событием в истории бурятского народа - автохтона Прибайкалья и Забайкалья. Этот процесс был сложным и длительным. Этот факт имел историческое значение для бурят не только в социальном и культурном плане, но и в языковом отношении. В связи с проникновением

элементов русской материальной и духовной культуры в язык бурят вливается огромное количество заимствованной лексики из русского языка, обозначающих новые реалии. Некоторые лексемы подверглись влиянию разговорного бурятского языка, который не терпит в начале, конце слова и в одном слоге стечения нескольких согласных, характерного для русского языка. Например, летописи В. Юмсунова, Ш.-Н. Хобитуева, Д.-Ж. Ломбоцыренова, Ц. Сахарова и других авторов являются одними из первых достоверных источников, где отражены письменные формы заимствованных слов из русского языка в XVII-XIX вв.

Заимствованную лексику из русского языка в текстах бурятских летописей на старомонгольской письменности можно подразделить на следующие группы: 1) слова, обозначающие места компактного проживания русских поселенцев: *yourud* ‘город’, *derebing* // *derebeng* // *derebeni* ‘деревня’, *ostoroy* ‘острог’, *ciliini* ‘селение’;

2) названия дворянских титулов, должностей, обязанностей: *boyibod stoolniy* ‘воевода стольник’, *voyevod* ‘воевода’, *veibarnui starusta* ‘выборный староста’, *γarab* ‘граф’, *gūbirnatur* ‘губернатор’, *general gūbirnatur* ‘генерал-губернатор’, *imperator* // *impiratur* ‘император’, *imperaturca* ‘императорица’, *inobirčiske jasedatel* // *jasedatil* ‘иноверческий заседатель’, *kinis* ‘князь’, *minister* // *miniistar* ‘министр’, *bolnomusnui miniistar* ‘полномочный министр’, *inobirčiske jasedatel* // *jasedatil* ‘иноверческий заседатель’, *desbeyitelnui tayinui sobidniy* ‘действительный тайный советник’, *nadbornui sobudniy* ‘надворный советник’, *stadski sobudniy* ‘статский советник’, *tituliirnui sobiidniy* ‘титулярный советник’, *činobniy* ‘чиновник’, *ciyritar* ‘секретарь’ и др.;

3) военные термины (звания, атрибуты): *adyutant* ‘адъютант’, *bolqobniy* // *polqobniy* ‘полковник’, *bingtetei buu* ‘винтовка’, *dinsig* // *dinčig* ‘денщик’, *yesa-a-uvl* ‘есаул’, *giniral* // *geniral* ‘генерал’, *kiris* / *keris* ‘крест’, *midal* ‘медаль’, *piidisedniy* ‘пятидесятник’, *pool* ‘полк’, *qavalir* ‘кавалер’, *qasay* ‘казак’, *qoritiy* / *qortiy* ‘кортик’, *viingce* ‘венец (военного флага)’ и др.;

4) термины, обозначающие занятия, статус человека: *biiburnui* ‘выборный’, *γoluba* ‘глава’, *jasedatil* ‘заседатель’, *liikar* ‘лекарь’, *qangdad* // *qangdidad* ‘кандидат’, *pismovoditil* ‘письмоводитель’, *pridsidatil* ‘председатель’, *γalabnui tayiša-a* ‘главный тайша’, *smotriitil* ‘смотритель’, *stüdingte* ‘студент’, *trapijiniy* ‘трапезник’, *üsinig* ‘ученик’ и др.;

5) канцелярские термины: *düsi* // *düüsi* ‘душа’ (в значении податной единицы), *γaramata* // *γaramuti* ‘грамота’, *nagrad* ‘награда’, *qommitet* ‘комитет’, *oblasti* ‘область’, *prikodska suryuli* ‘приходская школа’, *obsistau-a* ‘общество’, *pa-a-rti* ‘партия’, *patiyengta* // *patingta* ‘патент’, *podpiske* ‘подписка’, *pobinosti* / *povinosti* ‘повинности’, *poustu* ‘почта’, *pingce*

‘пенсия’, *pribitilstava* ‘правительство’, *priyovor* ‘приговор’, *ribiiĕ* ‘ревизия’, *qommiica* ‘комиссия’, *qompeled* ‘комплект’, *sluĭba* ‘служба’, *štad* ‘штат, штатный’, *taraytat* ‘трактат’ и др.;

6) присутственные места: *gubernske üprablini* ‘губернское управление’, *inorodnui upraba* ‘иностранная управа’, *erküü-yin namisnisisqui prabliini* ‘Иркутское наместническое управление’, *ĵemske // ĵimske süd* ‘земский суд’, *qangtor* ‘контора’, *qangceliiri* ‘канцелярия’, *stipnoi düm-e* ‘степная дума’ и др.;

7) названия новых овощных и зерновых культур: *obios* ‘овес’, *psiniica* ‘пшеница’, *roosi* ‘рожь’, *qaratopil* ‘картофель’, *qoolus* ‘колос’, *yaridca* ‘ярица’, *yišiming* ‘ячмень’ и др.;

8) названия средств, орудий, мест труда, предметов быта: *bouĭ* ‘возжи’, *duga* ‘дуга’, *fabric* ‘фабрика’, *keripiice // kirpiice // kerepeyce* ‘кирпич’, *litobke* ‘литовка’, *patiira* ‘квартира’, *poodosqu* ‘поддоска’, *serepei* ‘серп’, *stoulbu* ‘столб’, *sidoolq-a* ‘седелка’, *simadang* ‘чемодан’, *tarangtas terge* ‘тарантас’, *tüülke* ‘втулка’, *qomuud* ‘хомут’ и др.;

9) названия метрической системы мер: *ĵaranca* ‘гарнец’ – русская мера сыпучих тел, равная 1/8 четверика или 3, 28 литра (ТСРЯ: 543), *distiini* ‘десятина’ – старая русская мера земельной площади, равная 2400 кв. саженьям или 1,09 гектара, применявшаяся до введения метрической системы (СРЯ, т. I: 530).

Авторы бурятских летописей при переводе русских составных терминов иногда их полностью заимствуют, например: *bolnomusnui // polnomošnui miniistar // miniistir* ‘полномочный министр’, *gübiürnsqui sobiid* ‘губернский совет’, *distvitilmui stadsqui sobiitniĕ* ‘действительный статский советник’, *tituliirmui sobiidniĕ* ‘титулярный советник’, *stipnoi düm-e* ‘степная дума’, *yeqonomiisiqui manggaĭ-nar* ‘экономические магазины’ и др., а в некоторых случаях вместе с русизмами используют исконные слова в образовании сложных терминов: *erküü-giin sang-un arcinal* ‘Иркутский казенный арсенал’, *degedü pribitilstava* ‘высшее правительство’, *ĵiq-a-yin kereg-üd-ün qangceliiri* ‘канцелярия по пограничным делам’, *noyan dotur kereg-üd-ün miniistar* ‘господин министр внутренних дел’, *sibiiri-yin kile-yin ese ĵıysayaydaysan čereg* ‘Сибирское пограничное нерегулярное войско’, *abural-tu üker čečeg-üd-ün üsinig* ‘оспопрививательные ученики’ и т. д.

Следует отметить, что бурятские авторы довольно грамотно в письменной форме передают русские заимствования. Это говорит о том, что бурятские летописцы хорошо владели разговорным вариантом русского языка, например, Д.-Ж. Ломбоцыренов пишет: *qangtor* ‘контора’, *napoleon // napoleon* ‘Наполеон’, *impiratur qaĵan-u iinibersited* ‘Императорский Казанский университет’ и т. д., что вполне адекватно не письменной форме русского языка, а нормам устного произношения носителей русского языка. Важно

отметить, что в бурятских летописных текстах на старомонгольском языке письменные формы русских заимствований, в основном, транскрибируются, например: *adyutant* ‘адъютант’, *polqobniy* ‘полковник’, *fabric* ‘фабрика’, *povinosii* ‘повинности’, *napoleon* ‘Наполеон’, *general gübirnatur* ‘генерал-губернатор’, *pšiniica* ‘пшеница’, *priyovor* ‘приговор’ и т. д., а лексические единицы, проникшие через разговорный язык и прошедшие фонетическую адаптацию, фиксируются в бурятском произношении, например: *qangtor* ‘контора’, *patiira* ‘квартира’, *piidisedniy* ‘пятидесятник’, *üsinig* ‘ученик’, *jirsal* ‘зерцало’ и т.д.

Рассмотрение русских заимствований в языке бурятских летописей показало, что язык не является неким застывшим и неизменным феноменом, в процессе своего исторического развития он вбирает в себя спорадически включающиеся в него иноязычные элементы, например, многие русизмы, выявленные в текстах летописей XIX-XX вв., вошли в лексический фонд современного бурятского языка, например, *генерал*, *кандидат*, *квартира*, *комитет*, *полковник*, *трактат* и т. д.

В итоге рассмотрения языка исторических повествований бурят XIX-нач. XX вв. можно сделать вывод о том, что характер языка данных текстов в своей основе не отошел от системы классического монгольского языка, вместе с тем имеются довольно существенные отклонения в сторону разговорного бурятского языка. Анализ грамматической нормы однозначно показывает об ориентации авторов текстов на нормы старописьменного монгольского языка. В целом языковой фон бурятских исторических нарративов представляет собой промежуточный письменный вариант между классическим монгольским письменным языком и разговорной формой бурятского языка. Статус данного идиома определяется как бурятский извод старописьменного монгольского языка, который охватывал период с XVII в. – начало XX вв. Наличие летописных памятников у бурят показывает, прежде всего, высокую стадию письменной культуры, которой еще в XIX в. достигло бурятское общество Забайкалья.

Таким образом, заслуги бурятских летописцев очевидны. Их исторические нарративы, созданные на монгольском письме, которое являлось основой бурятского литературного (письменного) языка до начала 30-х годов XX в., вошли в золотой фонд бурятского летописного наследия и составляют в общепурятской литературе популярный жанр. Бурятские летописи представляют собой ценнейшие источники по истории и традиционной культуре бурятского народа.

Литература

1. Бадмаева, Л. Б. Язык бурятских летописей / Л. Б. Бадмаева. – Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2005. – 216 с.
2. Бадмаева, Л. Б. Летопись Вандана Юмсунова – памятник письменной культуры бурят XIX в. / Л. Б. Бадмаева. – Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2007. – 394 с.
3. Бадмаева, Л. Б. Языковое пространство бурятского летописного текста / Л. Б. Бадмаева. – Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2012. – 296 с.
4. Бадмаева, Л.Б. Летопись Ш.-Н. Хобитуева как памятник письменной культуры бурят / Л.Б. Бадмаева, Г.Н. Очирова. – Улан-Удэ: «Бэлиг», 2018. – 288 с., вкл.
5. Бурдукова, Т. А. Материалы для истории Бурят-Монголии (Бурятская историческая хроника Ш.-Н. Хобитуева): Дис. ...канд. филол наук / Т. А. Бурдукова. – Л., 1945.
6. Бурятские летописи / Сост. Ш. Б. Чимитдоржиев, Ц. П. Ванчикова (Пурбуева). – Улан-Удэ, 1995 – 197 с.
7. Бурятские летописи / Сост. Ц. П. Ванчикова, Ш. Б. Чимитдоржиев, М. В. Аюшева. – Улан-Удэ: Изд-во ОАО «Республиканская типография», 2011. – 224 с.
8. Востриков А. И., Поппе Н. Н. Летопись баргузинских бурят. Тексты и исследования. Вступ. статья, транслитерация, комментарии Л. Б. Бадмаевой. – Улан-Удэ: Изд-во БНЦ СО РА, 2007. – 120 с.
9. Дашиев, Д. Б. Бурятская дидактическая литература : проблемы жанрового состава : автореф. дис...канд. филол. наук : 10.01.02 / Дашиев Дандар Базаржапович. – Улан-Удэ, 1997. – 15 с.
10. Доржиев, Д. Д. Язык старомонгольской письменности Бурятии : автореф. дис. ... канд. филол. наук / Д.-Н. Д. Доржиев. – М., 1955. – 18 с.
